



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ - 2017

Улаанбаатар хот
2018 он

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА: ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ - 2017

- I. ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН
- II. АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН
- III. ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Захиалагч байгууллага:

Санхүүжүүлэгч байгууллага:

Судалгааны ажлын удирдагч:

Судалгааны ажлын гүйцэтгэгч:

Судалгааны дүнг боловсруулсан:

Цагдаагийн ерөнхий газар

Нээлттэй Нийгэм Форум

Б.Энхболд¹ (Ph.D)

Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

П.Мөнхтуяа¹ (Ph.D)

Г.Золзаяа² (Ph.D)

Ш.Баярдулам² (MSc)

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

Жамьян гүний гудамж - 5/1

Улаанбаатар 14240

Монгол Улс

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

И-мэйл: osf@forum.mn

¹ ХСИС-ийн Цагдаагийн сургууль, Эрүүгийн эрх зүй, Криминологийн тэнхим,
Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цагдаа судлалын төв

² ХААИС, Эдийн засаг, Бизнесийн сургуулийн Эдийн засгийн статистик, математик загварчлалын тэнхим

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум нь Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг хөндлөнгийн мониторинг, бодлогын судалгаагаар дэмжих, шинэчлэгдсэн эрх зүйн орчинд ажиллахад шаардлагатай техникийн туслалцааг хуулийн болон хууль сахиулах байгууллагад үзүүлэх, иргэний нийгмийг хууль сахиулах үйл явц дахь хүний эрхийн асуудлаар чадавхжуулахад анхаарал хандуулж ирлээ.

Цагдаагийн албаны үйл ажиллагаанд хэрэглэгчийн сэтгэл ханамж ямар байгааг судлах нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бодлогоо тодорхойлох, цагдаагийн албаны үйл ажиллагаанд бодитой үнэлэлт дүгнэлт өгөх, эрх зүйн шинэчлэлийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход онцгой ач холбогдолтой. Тиймээс ч улс орнууд энэ чиглэлээр тогтмол хугацаанд үнэлгээ хийхийг чухалчлан үздэг. Манай улсын хувьд энэхүү судалгааг хөндлөнгийн байгууллагаар жил бүр хийлгэх үүргийг цагдаагийн байгууллагад хүлээлгэсэн бөгөөд сүүлийн 5 жилд тасралтгүй хийж байгаа ажээ. ННФ нь 2017 оны 9 дүгээр сард ЦЕГ-тай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчийн үнэлгээ-2017” судалгааг санхүүжүүлж, техникийн туслалцаа үзүүлж ажиллалаа. Энэ удаагийн судалгааны онцлог нь анх удаа үндэсний хэмжээнд хийгдэж байгаагаас гадна олон улсын аргачлалын дагуу явагдаж байгаа явдал юм. Үүний зэрэгцээ цагдаагийн албаны шинэчлэл эхлээд 4 орчим жил болоод байгаа тул шинэчлэлийн үр нөлөөг үнэлэхэд тодорхой хувь нэмэр оруулах боломжтой.

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг хийж гүйцэтгэсэн орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын ажилтнууд нь ННФ-аас 2015-2017 онд зохион байгуулсан хоёр шатны сургалтад хамрагдсан тул сургалтаар олж авсан мэдлэгээ практикт турших боломж олдсоны зэрэгцээ нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, хамтран ажиллах эхлэл тавигдсан юм. Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн шинэчлэл эхэлж байгаа үед энэ чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллага цөөн, ялангуяа хөдөө орон нутагт ажилладаг байгууллага байхгүй байсан үетэй харьцуулахад тун чухал ахиц гарсанд баяртай байна. Тус судалгаанд их дээд сургуулийн багш нар, нийслэл болон 21 аймгийн 70 орчим төрийн бус байгууллага хамтран ажиллалаа.

Төгсгөлд нь судалгааны ажлыг удирдсан Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, Криминологийн тэнхимийн эрхлэгч, доктор Б.Энхболд, судалгааны мэдээлэл боловсруулсан ХААИС-ийн Эдийн засаг, Бизнесийн сургуулийн Эдийн засгийн статистик, математик загварчлалын тэнхимийн эрхлэгч, доктор П.Мөнхтуяа, багш, доктор Г.Золзаяа, магистр Ш.Баярдулам нар болон судалгаа авах ажлыг хийж гүйцэтгэсэн төрийн бус байгууллагуудад гүн талархал илэрхийлье. Тэрчлэн энэхүү судалгааг хараат бус хийх боломж олгосон ЦЕГ-ын газрын удирдлагад талархал илэрхийлье.

Та бүхний гарт очиж буй энэхүү судалгаа нь цагдаагийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлэх, энэ чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахад үнэтэй хувь нэмэр болно гэдэгт найдаж байна.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

АГУУЛГА

УДИРТГАЛ	iii
Судалгааны үндэслэл, шаардлага	iii
Судалгааны ажлын зорилго, зорилт	iv
Судалгааны ажлын онцлог	iv
Түүврийн хэмжээ	iv
Санал асуулга	viii
Хэрэглэгчийн үнэлгээний дүнг тооцсон аргачлал	viii
Мэдээлэл цуглуулах, боловсруулах үе шат	ix
Судалгааны хамрах хүрээ, хязгаарлалт	x
I. ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН	1
II. АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН	121
III. ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН	211
ХАВСРАЛТ	267

УДИРТГАЛ

Ардчиллын үзэл санаанд тулгуурласан нийгмийн томоохон өөрчлөлт нь Монгол Улс дахь гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, тэр дундаа цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд томоохон шинэчлэлт бий болгосон. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах замаар иргэдийн аюулгүй, тайван орчинд амьдрах баталгааг хангах үүрэг хүлээдэг бөгөөд энэхүү үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас тэдэнд хандах олон нийтийн сэтгэл ханамж тодорхойлогдож байдаг.

Сүүлийн 40 гаруй жилд дэлхийн олон улс оронд цагдаад итгэх олон нийтийн итгэл, иргэдийн сэтгэл ханамжийн талаарх судалгааг тасралтгүй явуулж, үр дүнг цагдаагийн байгууллага үйл ажиллагааныхаа чанар, хүртээмжийг сайжруулахад ашиглаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлт”, Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг,

байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний аргачлал”-ыг үндэслэн Цагдаагийн ерөнхий газар хэрэглэгчийн үнэлгээний тайланг жил бүр гаргах үүрэг хүлээсэн. 2012-2016 онд Цагдаагийн ерөнхий газрын захиалгаар хөндлөнгийн судалгааны байгууллагууд дээрх тайланг 5 удаа гаргаад байна. Судалгааны дүнгээс үзвэл Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамж жилээс жилд бага ч атугай дээшилжээ.

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Сүүлийн жилүүдэд хэрэглэгчийн үнэлгээний тайланг үндэслэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн олон талт арга хэмжээ хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч олон нийт, ялангуяа гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрх ашиг нь хөндөгдсөн иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд төдийлөн сэтгэл ханамжгүй

байгаа бол алба хаагчид ч ажлын нөхцөл, цалин хангамждаа төдийлөн сэтгэл ханамжгүй хэвээр байна. Ийм нөхцөл байдал удаан үргэлжлэх нь гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг иргэд цагдаад мэдээлэхгүй байх, улмаар оршин суугаа нутаг дэвсгэртээ аюулгүй тайван амьдрах итгэлгүй болж, гэмт хэргээс түгших мэдрэмж нэмэгддэг. Иймээс гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд хэрэглэгчийн үнэлгээний судалгаа онцгой ач холбогдолтой.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрэглэгч болон алба хаагчийн зүгээс үнэлэх судалгааны аргачлал боловсруулах, уг аргачлалын дагуу судалгаа явуулж, дүгнэлт хийх, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулахад уг судалгааны ажлын зорилго оршино. Судалгааны ажлын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлж, зөвлөмж боловсруулах;
2. Цагдаагийн алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлж, зөвлөмж боловсруулах;
3. Цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг байгууллагуудын сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлж, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ОНЦЛОГ

Энэ чиглэлээр хийгдсэн өмнөх судалгаанууд нь ихэвчлэн Улаанбаатар хотын дүүргүүдийн хүрээнд 575-1200 иргэнийг хамруулан явуулж байсан бол энэ удаа нийслэлийн 6 дүүргээс гадна 21 аймгийн төлөөллийг бүрэн хамруулаа. Өмнө нь хийгдсэн судалгааны арга зүй, санал асуулгын асуулт нь харилцан адилгүй, агуулгын хувьд ихээхэн ялгаатай байсныг харгалзан энэхүү судалгаанд цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний асуулгыг олон улсын жишигт нийцүүлэн, бусад улсад түгээмэл хэрэглэгддэг аргачлалд тулгуурлан боловсруулж, үр дүнг улсын хэмжээнд, бүс, Улаанбаатар хотын дүүрэг, аймаг тус бүрээр гаргаж нэгтгэн дүгнэснээрээ онцлогтой болов.

ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

Судалгааны түүвэрлэлтийг иргэд, алба хаагч, хамтран ажилладаг байгууллага гэсэн 3 бүлэгт хуваан сонгосон.

Иргэдийн судалгааны түүвэр:

Иргэдийн судалгаанд нийт 810 иргэн хамрагдсанаас 632 нь 21 аймгаас, 178 нь Улаанбаатар хотын 6 дүүргээс тус тус оролцсон ба түүвэрлэлтэд нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн төвөөс тус бүр 30 оршин суугчийг сонгон авсан

(Хүснэгт 1) бөгөөд 2017 оны байдлаар цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн байх шалгуурыг удирдлага болгосон. Судалгаанд хамрагдсан иргэдийг

Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах төвийн мэдээллийн сангаас санамсаргүй түүврийн аргаар сонгосон болно.

Хүснэгт 1. Иргэдийн судалгааны түүвэрлэлтийн загвар

Бүс	Дүүрэг, аймаг	Судалгаанд оролцогчид	Нийт
Баруун бүс	Баян-Өлгий	30	$21 \times 30 = 632$
	Говь-Алтай	30	
	Завхан	30	
	Увс	30	
	Ховд	30	
Хангайн бүс	Архангай	30	
	Баянхонгор	30	
	Булган	30	
	Орхон	30	
	Өвөрхангай	30	
	Хөвсгөл	30	
Төвийн бүс	Говьсүмбэр	30	
	Дархан-Уул	30	
	Дорноговь	30	
	Дундговь	30	
	Өмнөговь	30	
	Сэлэнгэ	30	
	Төв	30	
Зүүн бүс	Дорнод	30	
	Сүхбаатар	30	
	Хэнтий	30	
Улаанбаатар хот	Баянгол	30	$6 \times 30 = 178 (-2)$
	Баянзүрх	30	
	Сонгинохайрхан	30	
	Сүхбаатар	30	
	Хан-Уул	30	
	Чингэлтэй	30	
Нийт		810	$27 \times 30 = 810$

Алба хаагчдын судалгааны түүвэр: Цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүрэг, 21 аймгийн 402 алба хаагч оролцсон бөгөөд түүвэрлэлтийг тухайн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдын нэрийн жагсаалтаас санамсаргүй түүврийн аргаар албад бүрийн төлөөллийг оролцуулах байдлаар

сонгосон бөгөөд түүврийн загварыг Хүснэгт 2-т харуулав.

Хамтран ажилладаг байгууллагын түүвэр: Байгууллагын төлөөллийг сонгохдоо цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг хамгийн гол 10 чиглэлийг харгалзсан ба судалгаанд нийт 291 оролцогч байгууллагаа төлөөлөн оролцсон.

Хүснэгт 2. Алба хаагчдын судалгааны түүвэрлэлтийн загвар

Бүс	Аймаг, дүүрэг	Судалгаанд оролцогчид	Нийт
Баруун бүс	Баян-Өлгий	14	69
	Говь-Алтай	16	
	Завхан	14	
	Увс	10	
	Ховд	15	
Хангайн бүс	Архангай	15	87
	Баянхонгор	10	
	Булган	20	
	Орхон	16	
	Өвөрхангай	11	
	Хөвсгөл	15	
Төвийн бүс	Говьсүмбэр	15	107
	Дархан-Уул	16	
	Дорноговь	15	
	Дундговь	15	
	Өмнөговь	16	
	Сэлэнгэ	15	
	Төв	15	
Зүүн бүс	Дорнод	16	51
	Сүхбаатар	16	
	Хэнтий	19	
Улаанбаатар хот	Баянгол	15	88
	Баянзүрх	15	
	Сонгинохайрхан	14	
	Сүхбаатар	14	
	Хан-Уул	15	
	Чингэлтэй	15	
Нийт			402

Хамтран ажиллагсдын төлөөллөөс түүвэрлэлт хийхдээ тухайн байгууллагын өмнөөс асуултад оновчтой хариулт өгөх туршлагатай хүнийг өөрсдөө санал болгох замаар бүрдүүлсэн

бөгөөд Таны хариулт байгууллагыг тань төлөөлж байгаа гэдгийг тэдэнд тайлбарлаж ойлгуулсан. Түүвэрлэлтийн дүнг Хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. Хамтран ажилладаг байгууллагын түүвэрлэлтийн загвар

Бүс	Дүүрэг, аймаг	Судалгаанд оролцогч байгууллагын тоо	Нийт
Баруун бүс	Баян-Өлгий	5	46
	Говь-Алтай	10	
	Завхан	10	
	Увс	10	
	Ховд	11	
Хангайн бүс	Архангай	15	79
	Баянхонгор	10	
	Булган	10	
	Орхон	18	
	Өвөрхангай	10	
	Хөвсгөл	16	
Төвийн бүс	Говьсүмбэр	10	78
	Дархан-Уул	16	
	Дорноговь	10	
	Дундговь	10	
	Өмнөговь	10	
	Сэлэнгэ	10	
	Төв	12	
Зүүн бүс	Дорнод	10	30
	Сүхбаатар	10	
	Хэнтий	10	
Улаанбаатар хот	Баянгол	11	58
	Баянзүрх	10	
	Сонгинохайрхан	7	
	Сүхбаатар	10	
	Хан-Уул	10	
	Чингэлтэй	10	
Нийт		291	

САНАЛ АСУУЛГА

Иргэдийн судалгааны асуулга:

Судалгааны асуулгыг олон улсад түгээмэл хэрэглэгддэг аргачлалд тулгуурлан боловсруулсан ба “Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ”, “Орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ”, “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ”, “Иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ”, “Нээлттэй асуулт” гэсэн 7 бүлэгт багцлагдах нийт 36 асуулттай. Энэ аргачлалаар АНУ-ын зарим муж, Их Британи Өмнөд Ирландын Нэгдсэн Вант Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Канад, Япон, Бүгд Найрамдах Солонгос улсуудад цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг хоёр жил тутамд хийж байна.

Алба хаагчдын судалгааны асуулга:

Цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийг дараах асуулгын хүрээнд авсан. Үүнд: “Цагдаагийн алба хаагчийн сэтгэл ханамжийн ерөнхий байдал”, “Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэгт алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ”, “Хууль ёсны зарчмын хэрэгжилтэд алба хаагчдын өгсөн үнэлгээ”, “Хүний нөөцийн бодлогын талаарх алба хаагчдын сэтгэл

ханамжийн үнэлгээ”, “Байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүй”, “Удирдлагын манлайлал”, “Алба хаагчийн баталгаа”, “Нээлттэй асуулт” гэсэн 8 бүлэгт багцлагдах 30 асуулттай.

Хамтран ажилладаг байгууллагын

асуулга: Цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг байгууллагуудын сэтгэл ханамжийг дараах асуулгын хүрээнд тодорхойлсон. Үүнд: “Хамтын ажиллагааны чиглэл”, “Хууль ёсны зарчмын хэрэгжилт”, “Байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүй”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж”, “Нээлттэй асуулт” гэсэн 5 бүлэгт багцлагдах 21 асуулттай.

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГ ТООЦСОН АРГАЧЛАЛ

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны бүрдэл хэсэгт Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамж, Алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамж, Хамтран ажилладаг байгууллагын сэтгэл ханамж гэсэн 3 дэд судалгааг хамааруулж санал асуулгын аргаар явууллаа. Санал асуулгын асуулт тус бүрийн хариултыг “1=Огт санал нийлэхгүй”, “2=Санал нийлэхгүй”, “3=Дунд зэрэг”, “4=Санал нийлнэ”, “5=Санал бүрэн нийлнэ” гэсэн хувилбаруудтай ликертийн хэмжүүрээр 1-5 хүртэлх оноо өгч сэтгэл ханамжийн түвшнийг улс, бүс, Улаанбаатар хотын хэмжээнд тус тус тодорхойлов. Үнэлгээг дараах 3 нөхцөлөөр тодорхойлно. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэд болон алба хаагчдын сэтгэл ханамжийн судалгаанд ашигласан “Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ”, “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийн үнэлгээ”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ”, Алба хаагчдын судалгаанд ашигласан “Хүний нөөцийн бодлогын талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ”, “Байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүй”, “Удирдлагын манлайлал”, “Алба хаагчийн баталгаа” зэрэг нийт 8 бүлэг асуулгын үнэлгээг хариултуудын дундаж утгаар тодорхойлсон ба 5.0 утгад ойртох тутам **сэтгэл ханамжтай** гэсэн утга илэрхийлнэ. Харин орон нутгийн аюулгүй байдал гэсэн 4 дүгээр бүлгийн үр дүнг тооцохдоо сөрөг 5, эерэг 3 асуулт тавьж сөрөг асуултыг 5 руу ойртох тутам “аюултай”, эерэг асуултын хувьд 5 руу ойртох тутам “аюулгүй” гэсэн утга илэрхийлэхээр тооцсон. Тооцсон аргачлал нь 1.0-2.9 хүртэл **сэтгэл ханамжгүй**, 3.0-3.99 хүртэл **сэтгэл ханамж дунд зэрэг**, 4.0-5.0 хүртэл **сэтгэл ханамжтай** байна.
2. Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд ашигласан “Иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ” бүлгийн асуултуудын хувьд

хариулт нь “1=Огт айдасгүй байдаг”, “2=Айдасгүй байдаг”, “3=Дунд зэрэг”, “4=Айдастай байдаг”, “5=Айдас ихтэй байдаг” гэсэн сонголтууд байна. Дундаж үнэлгээ 5.0 утгад ойртох тутам **айдас ихтэй** гэсэн утга илэрхийлэх бөгөөд 1.0-2.9 хүртэл **айдас бага**, 3.0-3.99 хүртэл **айдас дунд зэрэг**, 4.0-5.0 хүртэл **айдас ихтэй** байна.

3. Иргэд, Алба хаагч, Хамтран ажилладаг байгууллага зэрэг гурван дэд судалгаанд ашигласан “Нээлттэй асуулт” бүлгийн дүнг тооцохдоо Улаанбаатар хот, орон нутгаас өгсөн санал тус бүрийг нэг бүрчлэн тусгаж, хамгийн олон давтамжтай эхний 6 асуултад дүгнэлт хийв.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ

Судалгааг Улаанбаатар хот болон орон нутаг дахь төрийн бус байгууллагуудаар дамжуулан гүйцэтгэсэн бөгөөд эдгээр төрийн бус байгууллагын¹ ажилтнууд нь Нээлттэй Нийгэм Форумаас зохион байгуулсан “Хууль сахих байгууллагын үйл ажиллагаанд мониторинг хийх чадавхыг бэхжүүлэх” сургалтад хамрагдсан байв. Төрийн бус байгууллагын ажилтнуудад судалгаа явуулах аргачлал, аюулгүй байдлаа хангах сургалт, асуулгын сорилын урьдчилсан судалгаа, хэлэлцүүлгийг

¹ Судалгааг гүйцэтгэсэн иргэний нийгмийн байгууллагын нэрсийг Хавсралтаас үзнэ үү.

2017 оны 8 дугаар сарын 24-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн сургалтын төвд зохион байгуулж, оролцогчдын саналыг тусгасан. Орон нутаг дахь судалгааг 2017 оны 10 дугаар сарын 1-ээс 11 дүгээр сарын 6-ны хооронд, Улаанбаатар хотын судалгааг 2017 оны 12 дугаар сарын 3-аас 12 дугаар сарын 20-ны хооронд явуулж нүүр тулсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан болно.

Судалгааны мэдээллийг SPSS.21 програм ашиглан боловсруулж, үзүүлэлт бүрийн жигнэсэн дундаж болон дээд, доод утга, медиан, стандарт хазайлт зэрэг статистик үзүүлэлтийг тооцохын зэрэгцээ, үзүүлэлтүүд хоорондын хамаарлыг статистик шинжүүрийн тусламжтайгаар тооцон тодорхойлж, зохих сорил шинжүүрээр шалгаж магадлалаа. Судалгааны үр дүн, дүгнэлт нь зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон бодит байдалд үндэслэгдсэн бөгөөд эдгээрт судлаачийн үзэл бодол, таамаглал тусгагдаагүй болно.

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ХЯЗГААРЛАЛТ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх иргэдийн сэтгэл ханамж, алба хаагчдын албандаа хандах болон хамтран ажилладаг байгууллагын судалгааг 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд хязгаарыг тогтоож, 2017 онд цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэд, хамтран ажилласан байгууллагыг хамруулав. Харин алба хаагчдын судалгааг тухайн цагдаагийн байгууллагад нэгээс доошгүй жил ажилласан алба хаагчдын дунд явуулсан. Улаанбаатар хотын хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тодорхойлох судалгаа хугацаанаас хожимдож эхэлсэнтэй холбоотойгоор зөвхөн төвийн 6 дүүргийн иргэдийг хамрууллаа. Улаанбаатар хотын 6 дүүрэгт цагдаагийн нийт 14 хэлтэс үйл ажиллагаа явуулж байгаа ба дүүрэг бүрийн гэр болон орон сууцны хорооллоос судалгаанд оролцогчдыг төлөөлүүлэн сонгож авсан. Тиймээс тайланд дурдагдсан нийслэлийн дүүргүүдийн дүн нь хэлтэс тус бүрээр гараагүйг анхаарна уу.



ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

I

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	6
НЭГ. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
ХОЁР. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААРХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ	10
2.1 Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ	10
2.1.1 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ	16
2.1.2 Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ	19
2.1.3 Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ	22
2.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ	25
2.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ	28
ГУРАВ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ ЁСНЫ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ	31
3.1 Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	31
3.1.1 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	35
3.1.2 Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	37
3.1.3 Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	39
3.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	41
3.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	43
ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	45
4.1 Улсын хэмжээнд орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ	45
4.1.1 Баруун бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ	51
4.1.2 Хангайн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ	53
4.1.3 Төвийн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ	56
4.1.4 Зүүн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ	58
4.1.5 Улаанбаатар хотын аюулгүй байдлын үнэлгээ	60
ТАВ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙН ТӨЛӨВШЛИЙН ҮНЭЛГЭЭ	64
5.1 Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	64
5.1.1 Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	66
5.1.2 Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	69
5.1.3 Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	71

5.1.4	Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	74
5.1.5	Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	75
ЗУРГАА. ГЭМТ ХЭРГЭЭС ТҮГШИХ ЕРӨНХИЙ ХАНДЛАГА		78
6.1	Улсын хэмжээнд иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ	78
6.1.1	Баруун бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ	80
6.1.2	Хангайн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ	82
6.1.3	Төвийн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ	83
6.1.4	Зүүн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ	85
6.1.5	Улаанбаатар хотын иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ	86
ДОЛОО. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ		88
7.1	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	88
7.1.1	Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	90
7.1.2	Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	92
7.1.3	Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	93
7.1.4	Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	95
7.1.5	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	96
НАЙМ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		98
ЕС. НЭЭЛТТЭЙ АСУУЛТЫН ХАРИУЛТ		105
ДҮГНЭЛТ		107
ЗӨВЛӨМЖ		110
ХАВСРАЛТ-1		112

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт I.1.	Судалгаанд хамрагдсан иргэдийн шинж байдал, бүсээр	9
Хүснэгт I.2.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, хувиар	12
Хүснэгт I.3.	Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, бүсээр	14
Хүснэгт I.4.	Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар	16
Хүснэгт I.5.	Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар	19
Хүснэгт I.6.	Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар	22
Хүснэгт I.7.	Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар	25
Хүснэгт I.8.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, дүүргээр	29
Хүснэгт I.9.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, хувиар	32
Хүснэгт I.10.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, бүсээр	33
Хүснэгт I.11.	Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	35
Хүснэгт I.12.	Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	37
Хүснэгт I.13.	Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	39
Хүснэгт I.14.	Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	41
Хүснэгт I.15.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	43
Хүснэгт I.16.	Орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, хувиар	46
Хүснэгт I.17.	Орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, хувиар (үр дүнг шалгах эерэг асуулт)	46
Хүснэгт I.18.	Орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, бүсээр	50
Хүснэгт I.19.	Орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ (үр дүнг шалгах эерэг асуулт)	50
Хүснэгт I.20.	Баруун бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар	51
Хүснэгт I.21.	Баруун бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, бүсээр (үр дүнг шалгах эерэг асуулт)	52
Хүснэгт I.22.	Хангайн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар	54
Хүснэгт I.23.	Хангайн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар (үр дүнг шалгах эерэг асуулт)	55
Хүснэгт I.24.	Төвийн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар	56
Хүснэгт I.25.	Төвийн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар (үр дүнг шалгах эерэг асуулт)	57
Хүснэгт I.26.	Зүүн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар	59
Хүснэгт I.27.	Зүүн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар (үр дүнг шалгах эерэг асуулт)	60

Хүснэгт I.28.	Улаанбаатар хотын аюулгүй байдлын үнэлгээ, дүүргээр	61
Хүснэгт I.29.	Улаанбаатар хотын аюулгүй байдлын үнэлгээ, дүүргээр (үр дүнг шалгах эерэг асуулт)	63
Хүснэгт I.30.	Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, хувиар	65
Хүснэгт I.31.	Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, бүсээр	66
Хүснэгт I.32.	Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	67
Хүснэгт I.33.	Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	69
Хүснэгт I.34.	Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	71
Хүснэгт I.35.	Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	74
Хүснэгт I.36.	Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	76
Хүснэгт I.37.	Улсын хэмжээнд гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, хувиар	79
Хүснэгт I.38.	Бүсүүдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ	80
Хүснэгт I.39.	Баруун бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар	81
Хүснэгт I.40.	Хангайн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар	82
Хүснэгт I.41.	Төвийн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар	84
Хүснэгт I.42.	Зүүн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар	85
Хүснэгт I.43.	Улаанбаатар хотын иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, дүүргээр	87
Хүснэгт I.44.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, хувиар	89
Хүснэгт I.45.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, бүсээр	89
Хүснэгт I.46.	Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	91
Хүснэгт I.47.	Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	92
Хүснэгт I.48.	Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	94
Хүснэгт I.49.	Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	95
Хүснэгт I.50.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дүүргээр	97
Хүснэгт I.51.	Иргэдийн өгсөн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ	99
Хүснэгт I.52.	Улсын хэмжээнд гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ	103
Хүснэгт I.53.	Гэмт хэргээс түгших байдлын нэгдсэн үнэлгээ, аймгаар	104
Хүснэгт I.54.	Иргэдээс өгсөн саналын хамгийн их давталттай саналууд	106
Хавсралт I.1.	Иргэдээс авсан нээлттэй асуултын дүн, давталтаар	112

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График I.1.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ	13
График I.2.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, хувиар	15
График I.3.	Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар	18
График I.4.	Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар	21
График I.5.	Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар	24
График I.6.	Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар	27
График I.7.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, дүүргээр	30
График I.8.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, хувиар	34
График I.9.	Баруун бүсийн цагдаагийн байгууллагын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар	36
График I.10.	Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	38
График I.11.	Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	40
График I.12.	Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	42
График I.13.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	44
График I.14.	Орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, үзүүлэлт тус бүрээр	47
График I.15.	Орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, хувиар	48
График I.16.	Орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, хувиар (үр дүнг шалгах эерэг асуулт)	49
График I.17.	Баруун бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар	52
График I.18.	Баруун бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар (үр дүнг шалгах эерэг асуулт)	53
График I.19.	Хангайн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар	54
График I.20.	Хангайн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар (үр дүнг шалгах эерэг асуулт)	55
График I.21.	Төвийн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар	57
График I.22.	Төвийн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар (үр дүнг шалгах эерэг асуулт)	58
График I.23.	Зүүн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар	59
График I.24.	Зүүн бүсийн орон нутгийн аюулгүй байдлын үнэлгээ, аймгаар (үр дүнг шалгах эерэг асуулт)	60
График I.25.	Улаанбаатар хотын аюулгүй байдлын үнэлгээ, дүүргээр	62
График I.26.	Улаанбаатар хотын аюулгүй байдлын үнэлгээ, дүүргээр (үр дүнг шалгах эерэг асуулт)	63
График I.27.	Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар	68

График I.28.	Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар	70
График I.29.	Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар	73
График I.30.	Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар	75
График I.31.	Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, дүүргээр	77
График I.32.	Баруун бүсийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар	81
График I.33.	Хангайн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар	83
График I.34.	Төвийн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар	84
График I.35.	Зүүн бүсийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар	86
График I.36.	Улаанбаатар хотын иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, дүүргээр	87
График I.37.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, бүсээр	90
График I.38.	Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	91
График I.39.	Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	93
График I.40.	Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	94
График I.41.	Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	96
График I.42.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дүүргээр	97
График I.43.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ	100
График I.44.	Орон нутгийн цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	101
График I.45.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дүүргээр	102
График I.46.	Иргэдээс өгсөн санал, тоогоор	106

НЭГ. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд нийт 21 аймаг, 6 дүүргийн 810 иргэн оролцсоноос Баруун бүсээс 150, Хангайн бүсээс 181, Төвийн бүсээс 210, Зүүн бүсээс 91, Улаанбаатар хотоос 178 иргэн тус тус хамрагдав.

Судалгаанд оролцогчдын 54.9 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 45.1 хувь нь эрэгтэйчүүд байв. Насны хувьд 60.4 хувь нь 25-44 насныхан, 20 орчим хувь нь 24-өөс доош болон 55-аас дээш насныхан оролцов. Оролцогчдын 45 хувь нь дээд боловсролтой, 52 хувь нь бүрэн болон бүрэн бус дунд, 3 орчим хувь нь бага

боловсролтой болон боловсролгүй иргэд байв. Нийт оролцогчдын 40 орчим хувь нь 500000 төгрөгөөс доош орлоготой байсан ба 33.2 хувь нь гэр хороололд, 15.2 хувь нь түрээсийн болон урт хугацааны зээлээр авсан орон сууцанд, үлдсэн нь орон сууц болон байшинд амьдардаг ажээ.

Судалгаанд оролцогчдын шинж байдал нь цагдаагийн байгууллагыг үнэлэх нийгэм, хүн ам зүйн болон эдийн засгийн шинжийг хангаж чадсан бөгөөд оролцогчдыг бүсээр ангилан Хүснэгт I.1-д харуулав.

Хүснэгт I.1. Судалгаанд хамрагдсан иргэдийн шинж байдал, бүсээр

Үзүүлэлт	Шинж байдал	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо				
		Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Хүйс	Эрэгтэй	72	76	74	39	105
	Эмэгтэй	78	105	136	52	73
Гэрлэлтийн байдал	Ганц бие	29	29	29	9	47
	Гэрлэсэн	111	138	163	78	124
	Бэлэвсэн	10	46	18	34	7
Нас	24 -өөс доош	11	13	10	4	28
	25 - 34	47	72	67	27	72
	35 - 44	38	43	52	27	44
	45 - 54	32	30	53	24	20
	55-аас дээш	22	23	28	9	14
Боловсролын байдал	Боловсролгүй	1	2	1	0	1
	Бага	3	2	12	3	2
	Бүрэн бус дунд	41	44	71	29	35
	Бүрэн дунд	30	48	39	30	56
	Дээд	75	85	87	29	84
Сууцны төрөл	Гэрт	57	54	56	30	60
	Байшинд	51	61	47	24	49
	Орон сууц	26	35	74	21	37
	Зээлийн орон сууц	9	14	20	12	11
	Түрээсийн байр	7	17	19	4	21
Гэр бүлийн гишүүдийн сарын орлого	500.000-аас доош	66	86	95	47	30
	500.000 - 1.000.000	37	48	57	21	58
	1.000.000 - 2.000.000	13	25	32	39	37
	2.000.000 - 3.000.000	7	3	7	52	11
	3.000.000 - 4.000.000	6	7	5	9	10
	4.000.000 - 5.000.000	3	1	1	78	8
	5.000.000 - 6.000.000	8	3	2	34	11
	6.000.000 - 7.000.000	4	1	2	4	3
7.000.000-аас дээш	6	7	9	27	10	

Эх сурвалж: Судалгааны өгөгдлийг SPSS 21 програмаар боловсруулсан дүн

ХОЁР. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААРХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт засгийн газар нь “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх”², Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн”³, түүнчлэн хуулийн 10, 11, 12 дугаар зүйлд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэгт гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн. Тиймээс цагдаагийн байгууллага хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас иргэдийн сэтгэл ханамж шууд шалтгаална. Энэхүү судалгаагаар

цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, түүний агуулгыг тодорхойлох 8 асуултыг судалгаанд оролцогчдод тавьж, асуулт тус бүрээр дүн шинжилгээ хийв.

2.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ҮНЭЛГЭЭ

Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн дундаж үнэлгээ 3.4 гарсан нь иргэдийн сэтгэл ханамж **дунд зэрэг** байгааг илэрхийлнэ. Дунджаас доогуур үнэлгээ авсан үзүүлэлтүүд нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгт хамаарч байгаа бол дунджаас дээгүүр үнэлгээ нь нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгт хамаарч байна. Тухайлбал, “Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг”, “Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж

² Монгол Улсын Үндсэн хууль-Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 1992, №1.

³ Цагдаагийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 2017, №8.

баривчилдаг”, “Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаа үр дүнтэй хэрэгжүүлдэг” гэсэн үзүүлэлтүүдийн үнэлгээ 3.12-3.27 байгаа нь улсын дунджаас 0.30-0.13 пунктээр доогуур байна. Харин “Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 69.7 хувь, “Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй хэрэгжүүлдэг” гэсэн асуултад 58.1 хувь нь, “Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах зорилгоор манай нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг маш сайн гүйцэтгэдэг” гэсэн асуултад 49.7 хувь нь *санал нийлнэ, санал бүрэн нийлнэ* гэсэн

хариултыг сонгосон нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.13-0.42-оор дээгүүр байна (Хүснэгт I.2).

Улсын дунджаас дээгүүр болон доогуур авсан зарим үзүүлэлтийг График I.1-д үзүүлэв.

Судалгааны дүнгээс үзэхэд үзүүлэлт бүр харилцан адилгүй байгаа ч агуулгын хувьд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргээ гүйцэтгэж байгаа байдлыг *дунд зэрэг* гэж үнэлсэн байна. Улаанбаатар хот бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Харин Зүүн, Баруун, Төвийн бүсүүд тус бүр 2 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Хүснэгт I.3-т цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үзүүлэлтийг улсын дундажтай харьцуулан бүсүүдээр харуулав.


**Хүснэгт I.2. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын
үндсэн чиг үүргийн үнэлгээ, хувиар**

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд зэрэг	Санал нийлнэ	Санал бүрэн нийлнэ
Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд аль болох богино хугацаанд хүрэлцэн ирдэг	810	3.43	6.5	7.9	36.3	34.7	14.6
Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг	810	3.19	7.5	17.9	32.5	32.5	9.6
Ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллага түргэн шуурхай илрүүлдэг	810	3.43	4.9	13.1	32.0	34.4	15.6
Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг	810	3.12	9.4	17.3	34.6	29.0	9.8
Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаа үр дүнтэй хэрэгжүүлдэг	810	3.27	5.4	12.8	41.1	30.7	9.9
Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах зорилгоор манай нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг маш сайн гүйцэтгэдэг	810	3.42	5.9	12.1	32.2	33.3	16.4
Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг	810	3.82	4.4	5.8	19.9	42.8	26.9
Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй хэрэгжүүлдэг	810	3.53	4.6	10.4	29.0	39.4	16.7
Улсын дундаж	810	3.40	6.1	12.1	32.2	34.6	15.0


Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График I.1. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ


а. Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг (дундаж үнэлгээ 3.12)




б. Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг (дундаж үнэлгээ 3.43)



в. Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй хэрэгжүүлдэг (дундаж үнэлгээ 3.53)



г. Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг (дундаж үнэлгээ 3.82)



Хүснэгт I.3. Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, бүсээр

Асуултууд	Дундаж үнэлгээ					
	Улсын хэмжээнд	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд аль болох богино хугацаанд хүрэлцэн ирдэг	3.43	3.25	3.33	3.42	3.32	3.70
Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг	3.19	3.01	3.05	3.18	3.20	3.45
Ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллага түргэн шуурхай илрүүлдэг	3.43	3.33	2.27	3.33	3.44	3.75
Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг	3.12	2.99	2.96	3.11	3.05	3.45
Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаа үр дүнтэй хэрэгжүүлдэг	3.27	3.22	3.21	3.15	3.36	3.44
Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах зорилгоор манай нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг маш сайн гүйцэтгэдэг	3.42	3.43	3.29	3.31	3.40	3.65
Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг	3.82	3.93	3.66	3.85	3.79	3.83
Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй хэрэгжүүлдэг	3.53	3.51	3.37	3.55	3.53	3.68
Улсын дундаж	3.40	3.33	3.26	3.36	3.38	3.62


Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

“Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг” гэсэн асуултад Баруун бүс хамгийн өндөр үнэлгээ авсан нь улсын дунджаас 0.11 пунктээр дээгүүр байна.

Харин “Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг

хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг” гэсэн асуултад бүх бүс хамгийн бага үнэлгээ авсан бөгөөд Баруун болон Хангайн бүсийн үнэлгээ 2.96-2.99 байгаа нь судалгаанд оролцогчдын 40 орчим хувь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлнэ. Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн 8 асуулт тус бүрийн үнэлгээг График I.2-т нэгтгэн харуулав.

График 1.2. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, хувиар



■ Огт санал нийлэхгүй ■ Дунд зэрэг ■ Санал нийлнэ

2.1.1 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ

Баруун бүсийн аймгууд дахь цагдаагийн байгууллага үндсэн чиг үүргээ биелүүлж байгаа байдлыг иргэд **дунд зэрэг** гэж үнэлжээ. Нийт 8 асуултын хариултаас

харахад Увс аймаг 7, Завхан аймаг 5, Баян-Өлгий аймаг 2, Ховд аймаг 1 үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Говь-Алтай аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Хүснэгт I.4-т баруун бүсийн иргэдийн өгсөн үнэлгээг улсын дундажтай харьцуулан үзүүлэв.

Хүснэгт I.4. Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар


Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлэгдсэн аймаг	Дунджаас доош үнэлэгдсэн аймаг
Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд аль болох богино хугацаанд хүрэлцэн ирдэг	3.43	Сэтгэл ханамж дунд зэрэг	Завхан Увс	Баян-Өлгий Говь-Алтай Ховд
Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг	3.19	Сэтгэл ханамж дунд зэрэг	Увс	Говь-Алтай Завхан Баян-Өлгий Ховд
Ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллага түргэн шуурхай илрүүлдэг	3.43	Сэтгэл ханамж дунд зэрэг	Увс	Баян-Өлгий Говь-Алтай Завхан Ховд
Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг	3.12	Сэтгэл ханамж дунд зэрэг	Увс	Баян-Өлгий Говь-Алтай Завхан Ховд
Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаа үр дүнтэй хэрэгжүүлдэг	3.27	Сэтгэл ханамж дунд зэрэг	Завхан Увс	Баян-Өлгий Говь-Алтай Ховд
Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах зорилгоор манай нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг маш сайн гүйцэтгэдэг	3.42	Сэтгэл ханамж дунд зэрэг	Баян-Өлгий Завхан Увс Ховд	Говь-Алтай
Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг	3.82	Сэтгэл ханамж дунд зэрэг	Баян-Өлгий Завхан Увс	Говь-Алтай Ховд
Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй хэрэгжүүлдэг	3.53	Сэтгэл ханамж дунд зэрэг	Завхан	Баян-Өлгий Говь-Алтай Увс Ховд

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Баруун бүсээс Завхан, Говь-Алтай аймгийн иргэд “Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг” гэсэн асуултад хамгийн бага үнэлгээ (2.23-2.40) өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлж байна. Харин Завхан, Увс аймгийн хувьд “Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан

спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг” гэсэн асуултад 4.07-4.31 буюу харьцангуй өндөр үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамж өндөр** байгааг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.25-0.4 пунктээр дээгүүр үнэлгээ юм. Баруун бүсийн судалгааны дүнг асуулт тус бүрээр задлан График I.3-т харуулав.

График 1.3. Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймаар



2.1.2 Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ

Хангайн бүсийн аймгууд дахь цагдаагийн байгууллага үндсэн чиг үүргээ хэрхэн гүйцэтгэж байгааг иргэд **дунд зэрэг** гэж үнэлжээ. Нийт 8 асуултын дүнгээр Орхон аймаг 7, Архангай

аймаг 6, Өвөрхангай аймаг 5, Хөвсгөл, Баянхонгор аймаг 2 үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн бол Булган аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Хүснэгт I.5-д Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээг улсын дундажтай харьцуулан үзүүлэв.

Хүснэгт I.5. Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар

Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд аль болох богино хугацаанд хүрэлцэн ирдэг	3.43	Сэтгэл ханамж дунд зэрэг	Архангай Орхон Өвөрхангай	Булган Хөвсгөл Баянхонгор
Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг	3.19	Сэтгэл ханамж дунд зэрэг	Архангай Баянхонгор Орхон	Булган Хөвсгөл Өвөрхангай
Ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллага түргэн шуурхай илрүүлдэг	3.43	Сэтгэл ханамж дунд зэрэг	Архангай Орхон Хөвсгөл	Баянхонгор Өвөрхангай Булган
Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг	3.12	Сэтгэл ханамж дунд зэрэг	Архангай Орхон Өвөрхангай	Баянхонгор Булган Хөвсгөл
Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаа үр дүнтэй хэрэгжүүлдэг	3.27	Сэтгэл ханамж дунд зэрэг	Архангай Орхон Өвөрхангай	Булган Баянхонгор Хөвсгөл
Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах зорилгоор манай нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг маш сайн гүйцэтгэдэг	3.42	Сэтгэл ханамж дунд зэрэг	Баянхонгор Орхон Өвөрхангай	Архангай Хөвсгөл Булган
Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг	3.82	Сэтгэл ханамж дунд зэрэг	Архангай Хөвсгөл	Баянхонгор Булган Өвөрхангай Орхон
Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй хэрэгжүүлдэг	3.53	Сэтгэл ханамж дунд зэрэг	Орхон Өвөрхангай	Архангай Баянхонгор Хөвсгөл Булган

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Хангайн бүсээс Булган аймгийн иргэд нийт 8 асуултын 4-т нь **сэтгэл ханамжгүй** байгаагаа илэрхийлсэн үнэлгээ өгсөн байна. Тухайлбал “Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг”, “Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг”, “Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг”, “Цагдаагийн алба хаагч

замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй хэрэгжүүлдэг” гэсэн асуултуудад харьцангуй доогуур үнэлгээ (2.25-2.39) өгчээ. Харин Орхон аймгийн хувьд “Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг” гэсэн асуултад 4.23 гэсэн үнэлгээ авсан нь **сэтгэл ханамж өндөр** байгааг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.41 пунктээр дээгүүр байна. Хангайн бүсийн үнэлгээг нийт 8 асуултаар нэгтгэн График I.4-т харуулав.

График 1.4. Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар



2.1.3 Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ

Төвийн бүсийн аймгуудын цагдаагийн байгууллага үндсэн чиг үүргээ хэрхэн гүйцэтгэж байгааг иргэд **дунд зэрэг** гэж үнэлжээ. Нийт 8 асуултын дүнгээр Дорноговь, Сэлэнгэ аймаг тус бүр 5,

Дундговь аймаг 4, Дархан-Уул, Өмнөговь аймаг 2, Төв аймаг 1 үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн бол Говьсүмбэр аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Төвийн бүсийн үнэлгээг улсын дундажтай харьцуулан Хүснэгт I.6-д үзүүлэв.

Хүснэгт I.6. Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, аймгаар


Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд аль болох богино хугацаанд хүрэлцэн ирдэг	3.43	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дархан-Уул Дорноговь Дундговь	Говьсүмбэр Өмнөговь Сэлэнгэ Төв
Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг	3.19	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорноговь Дундговь Өмнөговь Сэлэнгэ	Говьсүмбэр Дархан-Уул Төв
Ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллага түргэн шуурхай илрүүлдэг	3.43	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дархан-Уул Сэлэнгэ	Дорноговь Говьсүмбэр Дундговь Өмнөговь Төв
Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг	3.12	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорноговь Дундговь Сэлэнгэ	Говьсүмбэр Дархан-Уул Өмнөговь Төв
Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаа үр дүнтэй хэрэгжүүлдэг	3.27	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорноговь Сэлэнгэ	Говьсүмбэр Дархан-Уул Өмнөговь Дундговь Төв
Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах зорилгоор манай нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг маш сайн гүйцэтгэдэг	3.42	Сэтгэл ханамж дунд зэрэг	Сэлэнгэ	Говьсүмбэр Дархан-Уул Дорноговь Дундговь Өмнөговь Төв
Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Улсын дундаж үнэлгээ	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд зэрэг	Санал нийлнэ	Санал бүрэн нийлнэ
Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	810	2.96	12.5	15.9	41.5	23.3	6.8
Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбар байдаг	810	3.01	9.5	19.8	35.9	29.4	5.4
Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайлал үзүүлдэг	810	3.28	7.8	12.0	34.8	35.8	9.6
Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг	810	3.17	7.1	16.2	36.5	31.5	8.3
Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай	810	3.28	5.2	13.0	39.5	33.0	9.4
Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг	810	3.19	7.7	17.5	33.0	31.5	10.4
Улсын дундаж	810	3.14	8.4	15.8	36.8	30.7	8.3

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Улсын хэмжээнд Улаанбаатар хот бүх үзүүлэлтээр, Зүүн бүс 5, Төвийн бүс 2 үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Баруун

ба Хангайн бүсүүд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ (Хүснэгт I.31).

Хүснэгт I.31. Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, бүсээр

Асуултууд	Дундаж үнэлгээ					
	Улсын хэмжээнд	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хог
Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	2.96	2.72	2.80	2.99	3.07	3.22
Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбар байдаг	3.01	2.84	2.82	2.94	3.07	3.39
Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайлал үзүүлдэг	3.28	3.06	3.24	3.21	3.29	3.54
Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг	3.17	2.98	3.14	3.21	3.13	3.38
Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай	3.28	3.10	3.21	3.23	3.34	3.53
Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг	3.19	3.01	3.04	3.05	3.26	3.60
Улсын дундаж	3.15	2.95	3.04	3.11	3.19	3.44

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

5.1.1 Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Баруун бүсийн хувьд цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн байдалд иргэд **сэтгэл дундуур** буюу **дунд зэрэг** үнэлгээ өгчээ. Хүснэгт I.32-т баруун бүсийн

6 аймгийн иргэдийн өгсөн үнэлгээг нэгтгэн харуулав. Хүснэгтээс харахад Увс аймаг бүх үзүүлэлтээр, Завхан аймаг 4, Ховд аймаг 2 үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Баян-Өлгий, Говь-Алтай аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ.

Хүснэгт I.32. Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ


Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	2.96	Сэтгэл ханамжгүй	Увс	Баян-Өлгий Говь-Алтай Завхан Ховд
Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбар байдаг	3.01	Сэтгэл ханамж дунд зэрэг	Завхан Увс	Говь-Алтай Баян-Өлгий Ховд
Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайлал үзүүлдэг	3.28	Сэтгэл ханамж дунд зэрэг	Увс Завхан	Говь-Алтай
Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг	3.17	Сэтгэл ханамж дунд зэрэг	Завхан Увс	Ховд Говь-Алтай Баян-Өлгий
Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай	3.28	Сэтгэл ханамж дунд зэрэг	Ховд Увс	Баян-Өлгий Говь-Алтай Завхан
Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг	3.19	Сэтгэл ханамж дунд зэрэг	Завхан Увс Ховд	Говь-Алтай Баян-Өлгий

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Баруун бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр авч үзвэл, Говь-Алтай аймгийн иргэд “Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбар байдаг”, “Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг” гэсэн асуултуудад 2.47-2.50 үнэлгээ

өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлэх дүн юм. Харин Увс аймаг “Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай” гэсэн асуултад 3.5 авсан нь бусад аймагтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.22 пунктээр дээгүүр байна (График I.27).

График I.27. Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар



5.1.2 Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Хангайн бүсийн хувьд цагдаагийн байгууллагын алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйн байдалд иргэд **сэтгэл дундуур** байдгаа илэрхийлжээ

(Хүснэгт I.33). Нийт 6 асуултаар үнэлсэн дүнгээр Өвөрхангай, Орхон аймгууд тус бүр 5, Архангай, Хөвсгөл аймгууд тус бүр 4, Баянхонгор аймаг 1 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Булган аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ.

Хүснэгт I.33. Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ


Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	2.96	Сэтгэл ханамжгүй	Архангай Орхон Өвөрхангай Хөвсгөл	Баянхонгор Булган
Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбар байдаг	3.01	Сэтгэл ханамж дунд зэрэг	Архангай Өвөрхангай	Баянхонгор Булган Орхон Хөвсгөл
Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайл үзүүлдэг	3.28	Сэтгэл ханамж дунд зэрэг	Орхон Өвөрхангай Хөвсгөл Архангай	Баянхонгор Булган
Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг	3.17	Сэтгэл ханамж дунд зэрэг	Орхон Хөвсгөл Баянхонгор	Булган Өвөрхангай Архангай
Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай	3.28	Сэтгэл ханамж дунд зэрэг	Архангай Орхон Өвөрхангай	Булган Баянхонгор Хөвсгөл
Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг	3.19	Сэтгэл ханамж дунд зэрэг	Орхон Өвөрхангай Хөвсгөл	Архангай Баянхонгор Булган

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Хангайн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр нь нэгтгэн График I.28-д харуулав. Графикаас харахад Булган аймгийн иргэд “Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад бусдаас хамгийн бага үнэлгээ (2.0) өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг

илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 0.96 пунктээр бага байна. Харин Орхон аймгийн иргэд “Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайл үзүүлдэг” гэсэн асуултад бусдаас өндөр үнэлгээ (3.77) өгсөн нь улсын дунджаас 0.49 пунктээр дээгүүр байна.

График I.28. Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар



5.1.3 Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Төвийн бүсийн хувьд цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн байдалд иргэд **сэтгэл дундуур** байна (Хүснэгт I.34). Сэлэнгэ аймаг бүх 6 асуултаар,

Дорноговь, Дундговь аймгууд тус бүр 5, Дархан-Уул 4, Өмнөговь 2, Говьсүмбэр болон Баянхонгор аймгууд тус бүр 1 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Харин Төв аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь **сэтгэл ханамжгүйг** илэрхийлэх үзүүлэлт юм.

Хүснэгт I.34. Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ


Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	2.96	Сэтгэл ханамжгүй	Говьсүмбэр Дархан-Уул Дорноговь Дундговь Сэлэнгэ	Өмнөговь Төв
Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбар байдаг	3.01	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дархан-Уул Дорноговь Дундговь Өмнөговь Сэлэнгэ	Төв Говьсүмбэр
Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайлал үзүүлдэг	3.28	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дархан-Уул Дорноговь Дундговь Сэлэнгэ	Өмнөговь Төв Говьсүмбэр
Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг	3.17	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дархан-Уул Дорноговь Дундговь Өмнөговь Сэлэнгэ	Говьсүмбэр Төв
Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай	3.28	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорноговь Дундговь Сэлэнгэ	Төв Говьсүмбэр Өмнөговь Дархануул
Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг	3.19	Сэтгэл ханамж дунд зэрэг	Сэлэнгэ	Говьсүмбэр Дархан-Уул Дорноговь Дундговь Өмнөговь Төв

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Төвийн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр нэгтэн График I.29-д харуулав. Графикаас харахад “Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг” гэсэн асуултад Сэлэнгээс бусад аймаг улсын дунджаас доогуур үнэлгээтэй гарч байгаа нь анхаарал татаж байна. Түүний дотор Төв аймгийн иргэд “Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг”, “Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход

хялбар байдаг” гэсэн хоёр асуултад бусад аймгаас хамгийн бага үнэлгээ (2.3; 2.27) өгсөн нь эдгээр үзүүлэлтэд иргэд **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 0.66 пунктээр бага байна. Харин Дорноговь аймгийн хувьд “Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг” гэсэн асуултад бусад аймагтай харьцуулахад хамгийн өндөр үнэлгээ (3.53) өгсөн бөгөөд энэ нь улсын дунджаас 0.36 пунктээр дээгүүр байна.

График I.29. Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар



5.1.4 Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Зүүн бүсийн хувьд цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн байдлыг иргэд *сэтгэл дундуур* гэж

үнэлжээ (Хүснэгт I.35). Хэнтий аймаг 6, Дорнод аймаг 5, Сүхбаатар аймаг 1 үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Сүхбаатар аймаг бүх 5 үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээтэй байна.

Хүснэгт I.35. Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ


Асуулт	Дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	2.96	Сэтгэл ханамжгүй	Хэнтий	Дорнод Сүхбаатар
Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбар байдаг	3.01	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорнод Хэнтий	Сүхбаатар
Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайлал үзүүлдэг	3.28	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорнод Хэнтий	Сүхбаатар
Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг	3.17	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорнод Хэнтий	Сүхбаатар
Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай	3.28	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорнод Хэнтий	Сүхбаатар
Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг	3.19	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорнод Сүхбаатар Хэнтий	-

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Зүүн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр нэгтгэн График I.30-д харуулав. Графикаас харахад Сүхбаатар аймгийн иргэд “Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбар байдаг” гэсэн асуултыг 2.7 гэж үнэлсэн нь *сэтгэл ханамжгүй* байгааг илэрхийлэх бөгөөд

улсын дунджаас 0.31 пунктээр бага байна. Харин Хэнтий аймгийн иргэд “Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайлал үзүүлдэг” гэсэн асуултад хамгийн өндөр үнэлгээ (3.87) өгсөн нь улсын дунджаас 0.59 пунктээр өндөр байна.

График I.30. Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар



5.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Улаанбаатар хотын иргэд цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйн байдалд **сэтгэл дундуур** байдгаа илэрхийлжээ (Хүснэгт I.36). Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд 6 асуултад улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Харин Хан-Уул, Баянгол дүүргүүд тус бүр хоёр, Чингэлтэй дүүрэг нэг үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээтэй байна.

Улаанбаатар хотын дүүргүүдийн үнэлгээг асуулт тус бүрээр нэгтгэн


График I.31-д үзүүлэв. Графикаас харахад Сүхбаатар дүүргийн иргэд “Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг” гэсэн асуултад бусад дүүргээс өндөр үнэлгээ (4.1) өгсөн нь улсын дунджаас 0.91 пунктээр дээгүүр байна. Харин Баянгол дүүргийн иргэдийн “Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад өгсөн үнэлгээ (2.79) нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 0.17 пунктээр бага байна.

Хүснэгт I.36. Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Асуулт	Дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй дүүрэг	Дунджаас доош үнэлгээтэй дүүрэг
Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	2.96	Сэтгэл ханамжгүй	Баянзүрх Сонгинохайрхан Сүхбаатар	Баянгол Чингэлтэй Хан-Уул
Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбар байдаг	3.01	Сэтгэл ханамж дунд зэрэг	Баянгол Баянзүрх Сонгинохайрхан Сүхбаатар Хан-Уул Чингэлтэй	-
Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайлал үзүүлдэг	3.28	Сэтгэл ханамж дунд зэрэг	Баянгол Баянзүрх Сонгинохайрхан Сүхбаатар Хан-Уул Чингэлтэй	-
Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг	3.17	Сэтгэл ханамж дунд зэрэг	Баянгол Баянзүрх Сонгинохайрхан Сүхбаатар Чингэлтэй	Хан-Уул
Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай	3.28	Сэтгэл ханамж дунд зэрэг	Баянзүрх Сонгинохайрхан Сүхбаатар Хан-Уул Чингэлтэй	Баянгол
Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг	3.19	Сэтгэл ханамж дунд зэрэг	Баянгол Баянзүрх Сонгинохайрхан Сүхбаатар Хан-Уул Чингэлтэй	-

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График I.31. Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, дүүргээр



ЗУРГАА. ГЭМТ ХЭРГЭЭС ТҮГШИХ ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх олон улсын жишиг асуултад тухайн орон нутаг дахь оршин суугчдын гэмт хэргээс түгших байдлын түвшинг тодорхойлох явдал багтдаг. Гэмт хэргээс түгших мэдрэмж өндөр байх тутам цагдааг үнэлэх иргэдийн сэтгэл ханамж буурдаг. Гэмт хэргийн индекс гаргадаг Олон Улсын байгууллагын судалгаагаар 2016 онд Монгол Улс дахь иргэдийн аюулгүй байдлын түвшин 42.2 хувь, иргэд гэмт хэрэгт өртөх эрсдэл буюу гэмт хэргийн түвшин 57.6 хувьтай байсан. Энэ нь дэлхийн 118 улсаас 23 дугаар байрт орсон үзүүлэлт байсан бол 2017 оны байдлаар иргэдийн аюулгүй байдлын түвшин 33.2 хувь, гэмт хэргийн түвшин 66.7 хувьтай болж өмнөх жилтэй харьцуулахад нөхцөл байдал хүндэрч 13 дугаар байрт оржээ.⁴

6.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ИРГЭДИЙН ГЭМТ ХЭРГЭЭС ТҮГШИХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Судалгаанд оролцогчдын үнэлгээгээр гэмт хэргээс түгших байдлын дундаж үзүүлэлт 3.14 байгаа нь **дунд зэрэг айдастай** байгааг харуулж байна. Тухайлбал, “Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед” гэсэн асуултад нийт оролцогчдын 47.9 хувь, “Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед”, “Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй” гэсэн асуултад нийт оролцогчдын 40-өөс дээш хувь нь **айдастай байдаг, их айдастай байдаг** гэсэн хариулт сонгосон нь анхаарал татаж байна. Харин “Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед” **айдасгүй байдаг** гэж судалгаанд оролцогчдын 47.4 хувь нь хариулжээ (Хүснэгт I.37).

⁴ <https://www.numbeo.com/crime/in/Ulaanbaatar>

Хүснэгт I.37. Улсын хэмжээнд гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, хувиар

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Улсын дундаж үнэлгээ	Огт айдасгүй байдаг	Айдасгүй байдаг	Дунд зэрэг	Айдастай байдаг	Их айдастай байдаг
Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед	810	2.61	18.9	28.5	29.4	19.5	3.7
Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед	810	3.12	7.9	21.4	30.0	32.6	8.1
Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед	810	3.52	3.5	12.8	25.7	44.4	13.6
Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй үед	810	3.34	5.4	14.2	32.8	36.0	11.5
Улсын дундаж	810	3.14	8.9	19.2	29.5	33.1	9.3

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Улсын хэмжээнд гэмт хэргээс түгших байдал ямар байгааг бүсээр нь ангилан Хүснэгт I.38-д асуулт тус бүрээр нь харуулав. Хүснэгтээс харахад зүүн бүсийн иргэд харьцангуй **айдасгүй** гэж хариулсан бол бусад бүсийн иргэд **дунд зэрэг айдастай** байдаг гэж хариулсан нь анхаарал татаж байна. Тухайлбал, Улаанбаатар хот, Хангайн бүс тус бүр дөрөв, Төвийн бүс гурав, Баруун бүс нэг үзүүлэлтээр айдсын түвшин нь улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй буюу айдастай байна. Зүүн бүс бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур

үнэлгээ авсан бөгөөд энэ нь **айдасгүй** гэсэн утга илэрхийлнэ. Түүнчлэн Зүүн бүсийн иргэд оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед **огт айдасгүй байдаг** (2.32) гэж хариулсан бол Хангайн бүсийн иргэд хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед **хамгийн их айдастай** (3.60) байдаг гэж тус тус хариулжээ.

Судалгааны дүнгээс үзэхэд иргэдийн гэмт хэргээс түгших байдлын түвшнийг бууруулах шаардлагатай байна. Ингэснээр цагдаагийн үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэх боломжтой.

Хүснэгт I.38. Бүсүүдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ

Асуултууд	Дундаж үнэлгээ					
	Улсын хэмжээнд	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед	3.12	3.06	3.20	3.19	2.81	3.15
Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед	3.52	3.44	3.60	3.52	3.36	3.56
Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй үед	3.34	3.07	3.47	3.25	3.25	3.56
Улсын дундаж	3.14	3.03	3.24	3.14	2.93	3.24

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам айдсын түвшин өндөр гэсэн утга илэрхийлнэ.

6.1.1 Баруун бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ

Баруун бүсийн хувьд иргэдийн гэмт хэргээс түгших байдлын түвшин **дунд зэрэг** гэсэн үнэлгээтэй гарчээ. Нийт 4 асуултын дүнгээр Ховд аймаг хоёр, Увс, Говь-Алтай аймгууд нэг үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Харин Баян-Өлгий аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь харьцангуй **айдасгүй** байгааг илэрхийлнэ (Хүснэгт I.39).


Баруун бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр авч үзвэл, Завхан аймгийн иргэд “Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед” гэсэн асуултад 3.67 үнэлгээ өгсөн нь **айдас ихтэй** буюу сэтгэл ханамжгүй байгааг илэрхийлж байна. Харин Говь-Алтай аймгийн хувьд “Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед” гэсэн асуултад 2.23 үнэлгээ өгсөн нь бусад аймагтай харьцуулахад хамгийн **бага айдас**тай байгаа утга бөгөөд улсын дунджаас 0.38 пунктээр доогуур байна (График I.32).

Хүснэгт I.39. Баруун бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар

Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед	2.61	Айдасгүй	Ховд Увс	Баян-Өлгий Говь-Алтай Завхан
Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед	3.12	Дунд зэрэг айдастай	Говь-Алтай Ховд	Баян-Өлгий Завхан Увс
Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед	3.52	Айдастай	Завхан	Баян-Өлгий Говь-Алтай Ховд Увс
Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй үед	3.34	Дунд зэрэг айдастай	-	Говь-Алтай Баян-Өлгий Завхан Увс Ховд

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам айдсын түвшин өндөр гэсэн утга илэрхийлнэ.

График I.32. Баруун бүсийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар



6.1.2 Хангайн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ

Хүснэгт I.40-өөс харахад Хангайн бүсийн хувьд иргэдийн гэмт хэргээс түгших байдлын түвшин **дунд зэрэг** байна. Нийт 4 асуултын дүнгээр Хөвсгөл, Булган аймгууд тус бүр дөрөв, Баянхонгор аймаг гурав, Архангай, Орхон аймгууд тус бүр нэг үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ (График I.33).

Хангайн бүсээс Баянхонгор, Булган, Хөвсгөл, Архангай аймгуудын иргэд


“Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед” гэсэн асуултад 3.5-аас дээш үнэлгээ өгсөн нь **айдас ихтэй** буюу сэтгэл ханамжгүй байгааг илэрхийлж байна. Харин Орхон, Архангай аймгуудын иргэд “Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед” **бага айдас**тай (2.5-аас доош үнэлгээтэй) байгаа нь бусад аймагтай харьцуулахад харьцангуй сайн үзүүлэлт юм. График I.33-т Хангайн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт бүрээр нэгтгэн харуулав.

Хүснэгт I.40. Хангайн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар

Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед	2.61	Айдасгүй	Булган Хөвсгөл	Архангай Баянхонгор Орхон Өвөрхангай
Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед	3.12	Дунд зэрэг айдас	Баянхонгор Булган Хөвсгөл	Орхон Өвөрхангай Архангай
Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед	3.52	Дунд зэрэг айдас	Архангай Баянхонгор Булган Өвөрхангай Хөвсгөл	Орхон
Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй үед	3.34	Дунд зэрэг айдас	Баянхонгор Булган Орхон Өвөрхангай Хөвсгөл	Архангай

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам айдсын түвшин өндөр гэсэн утга илэрхийлнэ.

График I.33. Хангайн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар



6.1.3 Төвийн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ

Төвийн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын түвшин **дунд зэрэг** байна. Дорноговь, Сэлэнгэ аймгууд 4 үзүүлэлтээр, Төв, Дархан-Уул аймгууд тус бүр хоёр, Өмнөговь аймаг нэг үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан нь тухайн асуудлаар дээр дурдсан аймгуудад **айдас ихтэй** байгааг илэрхийлнэ (Хүснэгт I.41).

Төвийн бүсээс Дундговь, Өмнөговь, Төв аймгуудын иргэд “Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед” гэсэн асуултад 2.5-


аас доош үнэлгээ авсан нь **огт айдасгүй** байдгийг илэрхийлж байна. Харин “Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед” гэсэн асуултад Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгуудын иргэдийн өгсөн үнэлгээ 3.5 байгаа нь тухайн бүс нутагт оршин суугчид **айдас ихтэй** байгааг харуулж байна. Мөн Сэлэнгэ аймгийн иргэд “Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед” **айдас**тай байдаг гэж хариулсан буюу дундаж үзүүлэлт 3.63 байгаа нь улсын дунджаас 0.51 пунктээр дээгүүр үзүүлэлт юм. Төвийн бүсийн аймгуудын дүнг График I.34-т асуулт тус бүрээр нэгтгэн харуулав.

Хүснэгт I.41. Төвийн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар

Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед	2.61	Айдасгүй	Дорноговь Сэлэнгэ	Говьсүмбэр Дархан-Уул Дундговь Өмнөговь Төв
Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед	3.12	Дунд зэрэг айдастай	Дорноговь Сэлэнгэ Төв	Говьсүмбэр Дархан-Уул Дундговь Өмнөговь
Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед	3.52	Дунд зэрэг айдастай	Дархан-Уул Дорноговь Өмнөговь Сэлэнгэ Төв	Говьсүмбэр Дундговь
Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй үед	3.34	Дунд зэрэг айдастай	Дархан-Уул Дорноговь Сэлэнгэ	Говьсүмбэр Дундговь Өмнөговь

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам айдсын түвшин өндөр гэсэн утга илэрхийлнэ.

График I.34. Төвийн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар



6.1.4 Зүүн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ

Хүснэгт I.42-т үзүүлснээр зүүн бүсийн хувьд иргэдийн гэмт хэргээс түгших байдлын түвшин **бага** (2.93) байна. Зүүн бүсээс Хэнтий, Дорнод аймгууд бүх үзүүлэлтээр дунджаас доогуур үнэлгээ авсан нь тухайн аймгуудын иргэд **айдасгүй** байгааг илэрхийлж байна (Хүснэгт I.42). Харин Сүхбаатар аймаг нэг үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр

үнэлгээ авсан нь тухайн асуудлаар тус аймгийн иргэд **айдас**тай байгааг харуулна.


Зүүн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр нэгтгэн График I.35-д харуулав. Графикаас харахад “Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед”, “Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед” **айдас ихтэй, айдас**тай байдаг нь харагдаж байна.

Хүснэгт I.42. Зүүн бүсийн иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар

Асуулт	Дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед	2.61	Айдасгүй	-	Дорнод Сүхбаатар Хэнтий
Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед	3.12	Дунд зэрэг айдас	-	Дорнод Сүхбаатар Хэнтий
Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед	3.52	Дунд зэрэг айдас	Сүхбаатар	Дорнод Хэнтий
Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй үед	3.34	Дунд зэрэг айдас	-	Дорнод Сүхбаатар Хэнтий

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам айдсын түвшин өндөр гэсэн утга илэрхийлнэ.

График I.35. Зүүн бүсийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, аймгаар



6.1.5 Улаанбаатар хотын иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ

Улаанбаатар хотын иргэд **дунд зэрэг айдастай** (3.24) байдаг ажээ. Баянгол, Сонгинохайрхан дүүргүүд 4 үзүүлэлтээр, Хан-Уул, Баянзүрх дүүргүүд тус бүр 3, Сүхбаатар дүүрэг 2, Чингэлтэй дүүрэг 1 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан нь иргэд **айдастай, дунд зэрэг айдастай** байгааг илтгэнэ (Хүснэгт I.43). Харин Чингэлтэй дүүрэг 3, Сүхбаатар дүүрэг 2, Хан-Уул, Баянзүрх дүүрэг тус бүр 1 үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь дээрх үзүүлэлтээр хотын иргэд харьцангуй айдас багатай байгааг харуулж байна.

Улаанбаатар хотоос Сонгинохайрхан дүүргийн иргэд оройн цагаар гэртээ ганцаараа байх үедээ **айдастай байдаг** буюу дундаж үзүүлэлт 3.12 гарсан нь


бусад дүүрэгтэй харьцуулахад өндөр үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.51 пунктээр өндөр байна. Энэ нь Сонгинохайрхан дүүрэг хотын төвөөс алслагдсан, гэр хороолол ихтэй, орчны тохижилт муу зэргээс шалтгаалдаг байж болох юм. Баянгол, Хан-Уул дүүргүүдийн иргэд “Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй” гэсэн асуултад 3.7-оос дээш үнэлгээ өгсөн нь **айдас ихтэй** байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 0.36 пунктээр өндөр байна. Мөн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдийн иргэд “Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед” **айдас ихтэй** байдаг гэж хариулжээ. Эдгээр дүүргийн үнэлгээ 3.6-аас дээш байгаа нь улсын дунджаас 0.08 пунктээр дээгүүр үзүүлэлт юм (График I.36).

Хүснэгт I.43. Улаанбаатар хотын иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, дүүргээр

Асуулт	Дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй
Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед	2.61	Айдасгүй	Баянгол Сонгинохайрхан Сүхбаатар Хан-Уул	Баянзүрх Чингэлтэй
Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед	3.12	Дунд зэрэг айдастай	Баянгол Баянзүрх Сонгинохайрхан	Сүхбаатар Хан-Уул Чингэлтэй
Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед	3.52	Дунд зэрэг айдастай	Баянгол Баянзүрх Сонгинохайрхан Хан-Уул	Сүхбаатар Чингэлтэй
Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй үед	3.34	Дунд зэрэг айдастай	Баянгол Баянзүрх Сонгинохайрхан Сүхбаатар Хан-Уул Чингэлтэй	-

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам айдсын түвшин өндөр гэсэн утга илэрхийлнэ.

График I.36. Улаанбаатар хотын иргэдийн гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ, дүүргээр



ДОЛОО. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийг (i) Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан, (ii) Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг, (iii) Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг гэсэн 3 асуултын хүрээнд судалж үр дүнг улс, бүс, Улаанбаатар хотын хэмжээнд харьцуулан боловсрууллаа.

7.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Судалгаанд 21 аймаг, Улаанбаатар хотоос нийт 810 иргэн оролцсон бөгөөд сэтгэл ханамж **дунд зэрэг** буюу ерөнхий үнэлгээ 3.52 байна. Судалгаанд оролцогчдын дээрх 3 асуултад өгсөн хариултыг авч үзэхэд 55 хувь нь **санал нийлнэ, санал бүрэн нийлнэ** гэсэн хариултыг сонгожээ. Харин 2 дахь асуултын хувьд судалгаанд оролцогчдын 72.6 хувь нь **санал нийлнэ,**

санал бүрэн нийлнэ гэсэн хариултыг сонгосон нь цагдаад итгэх олон нийтийн хандлага өндөр байгааг илэрхийлж байна. Иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг Хүснэгт I.44-т нэгтгэн үзүүлэв.

Судалгаанаас харахад “Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан” гэсэн асуултад иргэдийн 22.6 хувь нь **сэтгэл ханамжгүй** байсан гэх хариултыг сонгожээ.

Аль бүсэд оршин сууж байгаагаасаа үл хамаараад иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ерөнхийд нь **дунд зэрэг** гэж үнэлсэн ба үзүүлэлт бүрээр харилцан адилгүй дүн гарчээ (Хүснэгт I.45). Хүснэгтээс харахад Улаанбаатар хот 3, Зүүн бүс 2, Төвийн бүс 1 үзүүлэлтээр тус тус улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй байна. Харин Баруун болон Хангайн бүс бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн дүнг График I.37-д нэгтгэн харуулав. Графикаас харахад Улаанбаатар хотын иргэд “Би эсхүл миний гэр бүлийн

гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг” гэсэн асуултад 4.05 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжтай** буюу цагдаад итгэж байгааг илэрхийлэх бөгөөд энэ нь улсын дунджаас 0.15 пунктээр дээгүүр байна. Харин Баруун болон Хангайн бүсийн

иргэд “Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан” гэсэн үзүүлэлтэд **сэтгэл ханамжгүй** (2.9) үнэлгээ өгсөн. Энэ нь цагдаад итгэх итгэл сул байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас **0.12** пунктээр доогуур байгаа нь анхаарал татаж байна.

Хүснэгт I.44. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, хувиар

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Улсын дундаж үнэлгээ	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд зэрэг	Санал нийлнэ	Санал бүрэн нийлнэ
Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан	810	3.11	9.3	13.3	43.3	24.9	9.1
Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг	810	3.85	2.7	6.5	18.1	48.0	24.6
Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг	810	3.60	5.9	10.0	25.4	34.9	23.7
Улсын дундаж	810	3.52	6.0	10.0	29.0	35.9	19.1


Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Хүснэгт I.45. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, бүсээр

Асуултууд	Дундаж үнэлгээ					
	Улсын хэмжээнд	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан	3.11	2.99	2.95	3.18	3.15	3.26
Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг	3.85	3.75	3.68	3.90	3.79	4.05
Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг	3.60	3.50	3.51	3.59	3.71	3.71
Улсын дундаж	3.52	3.41	3.38	3.55	3.55	3.67

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График I.37. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, бүсээр



7.1.1 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Баруун бүсийн хувьд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамж **дунд зэрэг** байна. Баруун бүсээс Завхан аймаг 3 үзүүлэлтээр, Увс аймаг 2 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Нийт 3 асуулт тус бүрээр иргэд ямар санал өгснийг Хүснэгт I.46-д нэгтгэн харуулав.

Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг аймгуудаар нь ангилан График I.38-д


харуулав. Завхан аймаг “Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг”, “Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг” гэсэн асуултуудад 4.03 үнэлгээтэй гарсан нь **сэтгэл ханамжтай** байх үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.15-0.43 пунктээр дээгүүр байна. Харин Баян-Өлгий аймгийн иргэд “Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан” гэсэн асуултад 2.53 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 0.58 пунктээр доогуур байна.

Хүснэгт I.46. Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар

Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан	3.11	Сэтгэл ханамж дунд зэрэг	Завхан Увс	Баян-Өлгий Говь-Алтай Ховд
Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг	3.85	Сэтгэл ханамж дунд зэрэг	Завхан	Баян-Өлгий Говь-Алтай Увс Ховд
Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг	3.60	Сэтгэл ханамж дунд зэрэг	Завхан Увс	Баян-Өлгий Говь-Алтай Ховд

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График I.38. Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар



7.1.2 Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Хангайн бүсийн хувьд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамж **дунд зэрэг** гэж үнэлэгджээ (Хүснэгт I.47). Хүснэгтээс харахад, Орхон аймаг нийт 3 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Булган аймаг эсрэгээрээ бүх 3 үзүүлэлтээрээ улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ.

Хангайн бүсийн иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг График I.39-д


аймгуудаар нь харуулсан бөгөөд Орхон аймаг “Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг” гэсэн асуултад 4.2 үнэлгээ авсан нь **сэтгэл ханамжтай** байх үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.35 пунктээр дээгүүр байна. Харин Булган аймгийн иргэд “Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан” гэсэн асуултад 2.36 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 1.24 пунктээр доогуур байна.

Хүснэгт I.47. Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар

Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг
Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан	3.11	Сэтгэл ханамж дунд зэрэг	Орхон	Архангай Хөвсгөл Баянхонгор Өвөрхангай Булган
Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг	3.85	Сэтгэл ханамж дунд зэрэг	Орхон	Баянхонгор Булган Өвөрхангай Хөвсгөл Архангай
Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг	3.60	Сэтгэл ханамж дунд зэрэг	Архангай Баянхонгор Орхон Өвөрхангай Хөвсгөл	Булган

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График I.39. Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар



7.1.3 Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Төвийн бүсийн иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд **дунд зэрэг** (3.35) сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлжээ (Хүснэгт I.48). Дорноговь, Дундговь, Сэлэнгэ аймгууд бүх 3 үзүүлэлтээр, Говьсүмбэр, Өмнөговь аймгууд тус бүр 1 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Дархан-Уул, Төв аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Мөн Говьсүмбэр аймаг 2, Өмнөговь аймаг 1 үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ.

Төвийн бүсийн иргэдийн сэтгэл


ханамжийн үнэлгээг асуулт тус бүрээр нэгтгэн График I.40-д харуулсан ба Дорноговь Дундговь Өмнөговь Сэлэнгэ аймгуудын иргэд “Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг” гэсэн асуултад 4.03 буюу түүнээс дээш үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжтай** байх үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.13-0.23 пунктээр дээгүүр байна. Харин Төв аймгийн иргэд “Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан” гэсэн асуултад 2.93 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 0.25 пунктээр доогуур байна.

Хүснэгт I.48. Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар

Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас доош үнэлгээтэй аймаг
Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан	3.11	Сэтгэл ханамж дунд зэрэг	Говьсүмбэр Дорноговь Дундговь Сэлэнгэ	Дархан-Уул Өмнөговь Төв
Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг	3.85	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорноговь Дундговь Өмнөговь Сэлэнгэ	Говьсүмбэр Дархан-Уул Төв
Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг	3.60	Сэтгэл ханамж дунд зэрэг	Дорноговь Дундговь Өмнөговь Сэлэнгэ	Говьсүмбэр Дархан-Уул Төв

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График I.40. Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар



7.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Зүүн бүсийн иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд **дунд зэрэг** (3.35) үнэлгээ өгчээ (Хүснэгт I.49). Хэнтий аймаг бүх 3 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Дорнод, Сүхбаатар аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ.

Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг асуулт тус бүрээр нэгтгэн График I.41-д харуулав. Графикаас харахад Хэнтий аймгийн


иргэд “Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг”, “Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг” гэсэн асуултуудад 4.1 буюу түүнээс дээш үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлэх бөгөөд энэ үнэлгээ нь улсын дунджаас 0.25-0.5 пунктээр дээгүүр байна. Харин Дорнод аймгийн иргэд “Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан” гэсэн асуултад 2.84 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 0.25 пунктээр доогуур байна.

Хүснэгт I.49. Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар

Асуулт	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг	Дунджаас дээш үнэлгээтэй аймаг
Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан	3.11	Сэтгэл ханамж дунд зэрэг	Хэнтий	Дорнод Сүхбаатар
Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг	3.85	Сэтгэл ханамж дунд зэрэг	Хэнтий	Сүхбаатар Дорнод
Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг	3.60	Сэтгэл ханамж дунд зэрэг	Хэнтий	Дорнод Сүхбаатар

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График I.41. Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар



7.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Улаанбаатар хотын иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд **дунд зэрэг** (3.67) үнэлгээ өгчээ (Хүснэгт I.50). Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүд бүх 3 үзүүлэлтээр, Хан-Уул дүүрэг 2, Баянгол дүүрэг 1 үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Баянгол, Сонгинохайрхан дүүргүүд 2, Хан-Уул дүүрэг 1 үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ.

Улаанбаатар хотын иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг асуулт тус бүрээр нэгтгэн График I.42-т үзүүлэв.


Графикаас харахад Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэд “Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг” гэсэн асуултад 4.0 ба түүнээс дээш үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжтай** байх үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.15 пунктээр дээгүүр байна. Сүхбаатар дүүргийн иргэд “Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг” гэсэн асуултад 4.1 үнэлгээ өгсөн нь мөн **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлэх ба улсын дунджаас 0.5 пунктээр дээгүүр байна. Бүхэлд нь авч үзвэл, Улаанбаатар хотын иргэд **сэтгэл ханамжгүй** гэсэн үнэлгээг аль ч асуултад өгөөгүй байна.

Хүснэгт I.50. Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар

Асуулт	Дундаж оноо	Үнэлгээний утга	Дунджаас дээш үнэлгээтэй дүүрэг	Дунджаас доош үнэлгээтэй дүүрэг
Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан	3.11	Сэтгэл ханамж дунд зэрэг	Баянзүрх Сүхбаатар Чингэлтэй	Баянгол Сонгинохайрхан Хан-Уул
Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг	3.85	Сэтгэл ханамж дунд зэрэг	Баянзүрх Баянгол Сонгинохайрхан Чингэлтэй Сүхбаатар Хан-Уул	-
Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг	3.60	Сэтгэл ханамж дунд зэрэг	Сүхбаатар Хан-Уул Баянзүрх Чингэлтэй	Баянгол Сонгинохайрхан

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График I.42. Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дүүргээр



НАЙМ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээг судалгаанд хамрагдсан 4 бүс, Улаанбаатар хотын 810 иргэнээс 5 асуулгаар авч үр дүнг аймаг, дүүрэг тус бүрээр боловсруулж гаргав. Хүснэгт I.51-д үнэлгээний дүнг эрэмбэлэн харуулав.

Уг хүснэгтээс харахад нийт 5 бүлгийн 32 асуултын дүн **дунд зэрэг** (3.25) үнэлгээтэй байна. Нийтдээ 8 аймаг, 6 дүүрэг дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол 13 аймаг дунджаас доогуур үнэлгээ авчээ. Авсан үнэлгээгээр эрэмбэлэхэд **нэгдүгээрт** Сүхбаатар дүүрэг, **хоёрдугаарт** Чингэлтэй дүүрэг **гуравдугаарт** Хэнтий аймаг тус тус жагсаж байна. Сүхбаатар, Чингэлтэй,

Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүргүүд, Хэнтий, Увс, Орхон, Сэлэнгэ, Өвөрхангай, Завхан, Архангай, Дорноговь аймгууд дунджаас дээгүүр үнэлгээ авсан байна. Харин Дундговь, Баянхонгор, Хөвсгөл, Дархан-Уул, Дорнод, Өмнөговь, Говьсүмбэр, Ховд, Сүхбаатар, Баян-Өлгий, Төв, Говь-Алтай, Булган аймгууд дунджаас доогуур үнэлгээ авчээ. Дэлгэрэнгүй тоон үзүүлэлтийг График I.43-т үзүүлэв.


Орон нутгийн иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг 5 бүлгийн 32 асуултаар дүгнэж үзэхэд дундаж үнэлгээ 3.18 байв. Нийт 21 аймгаас 10 нь дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол 11 нь дунджаас доогуур үнэлгээ авчээ (График I.44).

Хүснэгт I.51. Иргэдийн өгсөн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ

Орон нутаг	Цагдаагийн байгууллагын иргэдээс авсан санал асуулгын үнэлгээ					Нийт дүн	Байр
	Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг	Хууль ёсны зарчмын хэрэгжилт	Орон нутгийн аюулгүй байдал	Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшил	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн байдал		
Сүхбаатар дүүрэг	3.82	3.77	3.4	3.83	4.01	3.77	I
Чингэлтэй дүүрэг	3.64	3.58	3.3	3.62	3.82	3.59	II
Хэнтий аймаг	3.72	3.39	3.28	3.52	3.94	3.57	III
Увс аймаг	3.67	3.39	3.37	3.32	3.66	3.48	IV
Хан-Уул дүүрэг	3.75	3.32	3.31	3.23	3.61	3.44	V
Орхон аймаг	3.61	3.13	3.14	3.33	3.83	3.41	VI
Сонгинохайрхан дүүрэг	3.48	3.34	3.36	3.37	3.45	3.40	VII
Баянзүрх дүүрэг	3.55	3.16	3.08	3.37	3.73	3.38	VIII
Сэлэнгэ аймаг	3.63	3.32	3.1	3.28	3.5	3.37	IX
Өвөрхангай аймаг	3.51	3.1	3.4	3.25	3.53	3.36	X
Завхан аймаг	3.54	3.11	3.18	3.17	3.78	3.36	X
Баянгол дүүрэг	3.48	3.21	3.41	3.12	3.45	3.33	XI
Архангай аймаг	3.56	3.31	2.95	3.25	3.48	3.31	XII
Дорноговь аймаг	3.47	3.27	3.2	3.27	3.23	3.29	XIII
Дундговь аймаг	3.47	3.29	3.18	3.31	2.97	3.24	XIV
Баянхонгор аймаг	3.28	3.07	3.35	2.94	3.43	3.21	XV
Хөвсгөл аймаг	3.2	2.99	3.02	3.14	3.5	3.17	XVI
Дархан-Уул аймаг	3.34	2.92	3.24	3.13	3.17	3.16	XVII
Дорнод аймаг	3.31	2.86	3.3	3.05	3.22	3.15	XVIII
Өмнөговь аймаг	3.28	3.07	3.11	3.15	2.99	3.12	XIX
Говьсүмбэр аймаг	3.16	3.12	3.35	2.89	2.98	3.10	XX
Ховд аймаг	3.21	2.9	3.22	2.95	3.17	3.09	XXI
Сүхбаатар аймаг	3.12	2.92	2.84	3	3.5	3.08	XXII
Баян-Өлгий аймаг	3.19	2.82	3.18	2.73	3.18	3.02	XXIII
Төв аймаг	3.18	2.6	3.55	2.62	2.98	2.99	XXIV
Говь-Алтай аймаг	3.04	2.4	3.07	2.59	3.27	2.87	XXV
Булган аймаг	2.45	2.48	3.19	2.23	2.52	2.57	XXVI


Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График I.43. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ



Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График I.44. Орон нутгийн цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар




Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Улаанбаатар хотын иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг 5 бүлгийн 32 асуултаар дүгнэж үзэхэд дундаж үзүүлэлт нь 3.48 байв. Хоёр дүүрэг

дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол 4 дүүрэг дунджаас доогуур үнэлгээ авчээ (График I.45).

График I.45. Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дүүргээр



Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Иргэдийн гэмт хэргээс түгших байдлын түвшнийг нийт 4 асуултын хүрээнд тодорхойллоо. Үр дүнг 21 аймаг, 6 дүүргээр эрэмбэлэн Хүснэгт I.52-т нэгтгэн харуулав.

Хүснэгт I.52-оос харахад 4 асуулгаар авсан хариултын дундаж үнэлгээ 3.14 байгаа нь улсын хэмжээнд иргэд **дунд зэргийн айдас**тай байгааг илэрхийлнэ. Нийт 13 аймаг, 1 дүүрэг дунджаас доогуур үнэлгээ авсан бол 8 аймаг, 5 дүүрэг дунджаас дээгүүр үнэлгээ авсан нь тэдгээр орон нутагт

иргэд **дунд зэргийн айдас**тай байгааг харуулж байна. Баян-Өлгий, Дорнод, Хэнтий, Говь-Алтай, Орхон, Дундговь, Говьсүмбэр, Архангай, Өмнөговь, Увс, Сүхбаатар, Завхан, Өвөрхангай аймаг, Чингэлтэй дүүрэг дунджаас бага үнэлгээ авсан нь иргэд **айдас багатай** амьдардгийг харуулж байна. Харин Төв, Дархан-Уул, Дорноговь, Ховд, Баянхонгор, Хөвсгөл, Сэлэнгэ, Булган аймгууд, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол дүүргүүд дунджаас дээгүүр үнэлгээ авсан нь **айдас**тай амьдардгийг илэрхийлж байна.

Хүснэгт I.52. Улсын хэмжээнд гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ

Орон нутаг	Гэмт хэргээс түгших байдлын үнэлгээ	Эрэмбэ
Баян-Өлгий аймаг	2.85	I
Дорнод аймаг	2.87	II
Хэнтий аймаг	2.91	III
Говь-Алтай аймаг	2.95	IV
Орхон аймаг	2.96	V
Дундговь аймаг	2.97	VI
Говьсүмбэр аймаг	2.98	VII
Архангай аймаг	2.99	VIII
Өмнөговь аймаг	2.99	VIII
Увс аймаг	3.01	IX
Сүхбаатар аймаг	3.03	X
Чингэлтэй дүүрэг	3.06	XI
Завхан аймаг	3.08	XII
Өвөрхангай аймаг	3.10	XIII
Төв аймаг	3.16	XIV
Дархан-Уул аймаг	3.17	XV
Сүхбаатар дүүрэг	3.2	XVI
Баянзүрх дүүрэг	3.21	XVII
Дорноговь аймаг	3.23	XVIII
Хан-Уул дүүрэг	3.24	XIX
Ховд аймаг	3.27	XX
Баянхонгор аймаг	3.33	XXI
Сонгинохайрхан дүүрэг	3.38	XXII
Баянгол дүүрэг	3.39	XXIII
Хөвсгөл аймаг	3.47	XIV
Сэлэнгэ аймаг	3.5	XV
Булган аймаг	3.6	XVI

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам айдсын түвшин өндөр гэсэн утга илэрхийлнэ.

Хүснэгт I.53. Гэмт хэргээс түгших байдлын нэгдсэн үнэлгээ, аймгаар

Асуулт	Дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Дундаж үнэлгээнээс доош үнэлгээ өгсөн аймаг (айдас багатай)	Дундаж үнэлгээнээс дээш үнэлгээ өгсөн аймаг (айдастай)
Ямар нөхцөл байдалд айдсыг хир зэрэг мэдэрдэг эсэхийг тогтоох зорилготой үнэлгээ	3.14	Дунд зэргийн айдастай	Баян-Өлгий Дорнод Хэнтий Говь-Алтай Орхон Дундговь Говьсүмбэр Архангай Өмнөговь Увс Сүхбаатар Завхан Өвөрхангай Чингэлтэй	Төв Дархан-Уул Дорноговь Ховд Баянхонгор Хөвсгөл Сэлэнгэ Булган Сүхбаатар Баянзүрх Хан-Уул Сонгинохайрхан Баянгол

Жич: Дэлгэрэнгүйг 6 дугаар бүлгээс харна уу.

ЕС. НЭЭЛТТЭЙ АСУУЛТЫН ХАРИУЛТ

Иргэдээс өөрийн оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг сайжруулах, тэдний үйлчилгээг иргэдэд ойртуулах чиглэлээр ямар ажил хийх шаардлагатай талаар 810 иргэнээс нээлттэй санал асуулга авсан ба судалгаанд оролцогчид 258 төрлийн 674 хариулт өгсөн байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчдын харилцааны соёлыг дээшлүүлэх, хамтран ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх талаар иргэдээс өгсөн саналуудын хамгийн их давтагдсан эхний 6 саналыг тоймлон Хүснэгт I.54-т харуулав.


Нийт 674 саналаас 57.1 хувь нь дээрх 6 бүлэг саналд хамаарч байна. Цагдаагийн

алба хаагчид шударга, шуурхай байдлыг хангах талаар хамгийн их санал (128) өгчээ. Түүнчлэн орон нутгийн аюулгүй байдал, тохижилт, орчин нөхцөлийн талаар 111 санал өгсөн нь нийт саналын 29 хувийг эзэлж байна. Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн талаар 72 санал өгсөн бол цагдаагийн алба хаагч хүнд сурталтай гэж нийт судалгаанд оролцсон иргэдийн 12.2 хувь нь дүгнэжээ. Иргэд цагдаагийн алба хаагчдын хууль, дүрэм журмын мэдлэгийн талаар 14 санал өгсөн бол цагдаагийн алба хаагчдын хувцас, хэрэгслийг сайжруулах талаар 13 санал өгчээ (Дэлгэрэнгүй саналыг Хавсралт I.1-ээс үзнэ үү). Дээрх 6 бүлэг санал тус бүрийн эзлэх хувь, давталтын тоог График I.46-д харуулав.

Хүснэгт I.54. Иргэдээс өгсөн саналын хамгийн их давталттай саналууд

№	Иргэдээс өгсөн санал	Давталт	Нийт дүнд эзлэх хувь
1	Шударга, шуурхай байх	128	33.2
2	Орон нутгийн аюулгүй байдал, орчны тохижилтыг сайжруулах	111	29.0
3	Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйг сайжруулах	72	18.7
4	Алба хаагчдын хүнд суртлыг багасгах	47	12.2
5	Хууль, дүрэм журмын мэдлэгийг дээшлүүлэх	14	3.6
6	Цагдаагийн алба хаагчдын хувцас, хэрэгслийг сайжруулах	13	3.3
Нийт		385	100

График I.46. Иргэдээс өгсөн санал, тоогоор



ДҮГНЭЛТ

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг 2017 онд 5 бүлэгт багтах 32 асуултаар үнэлж, хэрэглэгчийн өгсөн үнэлгээг тооцож үзэхэд нийт 5.0 үнэлгээ авахаас 3.25 авсан нь 2016 оны 3.01 дүнтэй харьцуулахад бага зэрэг өссөн үзүүлэлт юм. Нийтдээ 8 аймаг, 6 дүүрэг улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол 13 аймаг дунджаас доогуур үнэлгээ авчээ. Эрэмбэлж үзэхэд нэгдүгээрт Сүхбаатар дүүрэг, хоёрдугаарт Чингэлтэй дүүрэг, гуравдугаарт Хэнтий аймаг тус тус орж байна. Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүргүүд, Хэнтий, Увс, Орхон, Сэлэнгэ, Өвөрхангай, Завхан, Архангай, Дорноговь аймгууд дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Дундговь, Баянхонгор, Хөвсгөл, Дархан-Уул, Дорнод, Өмнөговь, Говьсүмбэр, Ховд, Сүхбаатар, Баян-Өлгий, Төв, Говь-Алтай, Булган аймгууд дунджаас доогуур үнэлгээ авчээ.
2. Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг иргэд **дунд зэрэг** (3.38) гэж үнэлсэн бол “Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил”-д хамгийн бага үнэлгээ (3.11) өгчээ. Харин “Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийн арга хэмжээний аюулгүй байдлыг хангах ажил”-д хамгийн өндөр (3.81) үнэлгээ өгсөн байна. “Цагдаагийн байгууллага урьдчилан сэргийлэх арга хэмжээ тасралтгүй үр дүнтэй зохион байгуулдаг” гэсэн асуултад Улаанбаатар хотын оршин суугчдын үнэлгээ орон нутгийнхнаас харьцангуй өндөр байв.
3. Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд аль болох богино хугацаанд хүрэлцэн ирдэг байдлыг судалгаанд оролцогчид **дунд зэрэг**

- (3.43) гэж үнэлсэн бол “Цагдаагийн байгууллага иргэдээс хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэж, хариу өгдөг” байдлыг мөн **дунд зэрэг** (3.14) гэж үнэлжээ. Эндээс харахад хэрэг, учралын газарт цагдаагийн байгууллага, алба хаагч түргэн шуурхай очдог боловч асуудлыг хуулийн дагуу хурдан шийдвэрлэдэггүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна.
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн дундаж үзүүлэлт **дунд зэрэг** (3.09) гарсан бол “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод, эргэлзээгүй байдаг” гэсэн үзүүлэлтээр хамгийн бага үнэлгээ (2.98) авчээ. Харин хамгийн өндөр үнэлгээг “Гэмт хэрэг үйлдсэн, эсхүл сэрдэгдсэн болон тэдний гэр бүлийн гишүүдтэй цагдаагийн алба хаагч хуулийн дагуу харьцдаг” гэсэн асуултад авчээ. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй үнэлгээтэй гарсан байна. Энэ нь өмнөх жилийн үнэлгээнд ч мөн дурдагдаж байснаас үзэхэд иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ил тод биш гэж үзсээр байна. Иймэрхүү дүгнэлт цагдаагийн байгууллагатай хамтарч ажилладаг бусад байгууллагын сэтгэл ханамжийн судалгаагаар мөн гарсан.
5. Орон нутгийн нөхцөл байдлын талаар иргэдийн сэтгэл ханамж **дунд зэрэг** (3.21) байна. “Гудамж талбай, нийтийн эзэмшлийн газар бүрэн камержуулалтын системд холбогдсон” гэсэн асуултад сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 2.69 байгаа бөгөөд Төв, Улаанбаатар хотын иргэд дунджаас дээгүүр үнэлсэн бол Баруун, Хангай, Зүүн бүсүүдийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна. “Цэцэрлэгт хүүрээлэн, биеийн тамирын талбай, хүүхдийн тоглоомын газар зэрэг оршин суугчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх газар хангалттай байдаг” гэсэн асуултад сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 2.67 байгаа бөгөөд Хангай, Төв, Зүүн бүсүүдийн иргэд дунджаас дээгүүр үнэлгээг өгсөн бол Баруун бүс, Улаанбаатар хотын иргэд дунджаас доогуур үнэлгээ өгчээ. Иргэдийн аюулгүй, тайван амьдрах нөхцөл нь орон нутгийн нөхцөл байдлаас хамаардаг тул орон нутгийн нөхцөл байдал тааламжгүй байх нь нийгмийн хэв журам зөрчигдөх, гэмт хэрэг үйлдэгдэхэд таатай нөхцөл болж, иргэдийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлдэг. Энэ нь цагдааг үнэлэх иргэдийн хандлагад шууд нөлөөлдөг.
6. Цагдаагийн алба хаагчдын соёл, ёс зүйн төлөвшлийн байдалд иргэдийн сэтгэл ханамж **дунд зэрэг** (3.13)

байна. Судалгаанд оролцогчид “Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад дундаж үнэлгээ (2.96) өгсөн нь бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн бага байна. Өөрөөр хэлбэл, иргэд цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтөд сэтгэл ханамжгүй байна. Ялангуяа хөдөө орон нутгийн иргэд Улаанбаатар хотынхтой харьцуулахад сэтгэл ханамж харьцангуй доогуур байна.

7. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэхэд олон улсад хэрэглэдэг хамгийн гол шалгуур үзүүлэлт нь тухайн нутаг дэвсгэр дэх иргэдийн аюулгүй байдал хангагдах явдал юм. Энэ нөхцөл байдлыг тодруулах үүднээс “Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үедээ хэр айдастай байдаг вэ?” гэсэн асуулт тавихад судалгаанд оролцогчид сэтгэл ханамж **дунд зэрэг** (3.08) гэж хариулжээ. Хангай, Төвийн бүсүүд болон Улаанбаатар хотын иргэд дунджаас дээгүүр буюу **айдастай** гэж хариулсан бол Баруун, Зүүн бүсийн иргэд дунджаас доогуур буюу **айдас багатай** гэж хариулжээ.
8. Ерөнхийд нь авч үзвэл цагдааг үнэлэх иргэдийн сэтгэл ханамж эерэг байна. “Би цагдаагийн

байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан” гэсэн асуултад сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **дунд зэрэг** (3.10) байв. Төв, Зүүн бүсүүд, Улаанбаатар хотын иргэд дунджаас дээгүүр үнэлгээг өгсөн бол Баруун, Хангайн бүсийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгчээ. “Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг” гэсэн асуултад сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **дунд зэрэг** (3.83) байгаа бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Төв, Зүүн бүсүүд, Улаанбаатар хотын иргэд өгсөн бол Баруун, Хангайн бүсүүдийн иргэд дунджаас доогуур үнэлжээ.

9. Иргэдээс өөрийн оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг сайжруулах, тэднийг иргэдэд ойртуулах чиглэлээр ямар ажил хийх шаардлагатай талаар асуухад цагдаагийн алба хаагчид шударга, шуурхай байх, ёс зүйтэй байх (33.2 хувь), харилцааны соёлоо дээшлүүлэх (18.7 хувь), хүнд сурталгүй байх (12.2 хувь), хууль, дүрэм журмын мэдлэгээ нэмэгдүүлэх (3.6 хувь), хувцас, хэрэглэлээ сайжруулах (3.3 хувь) гэсэн саналууд гаргажээ (Хавсралт I.1).

ЗӨВЛӨМЖ

1. Дундаж ба дунджаас доогуур үнэлгээ авсан аймаг тус бүр хэрэглэгчийн үнэлгээг нэмэгдүүлэх, дунджаас дээгүүр үнэлгээ авсан аймаг тус бүр үйл ажиллагаагаа улам сайжруулах шаардлагатай. Судалгааны тайланд дурдагдсан үзүүлэлт тус бүрээр дүн шинжилгээ хийж улсын хэмжээнд хэрэглэгчийн үнэлгээний дундаж үзүүлэлтийг 4.0 ба түүнээс дээш түвшинд гаргах чиглэлээр ажиллах;
2. Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг нэмэгдүүлэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, оршин суугчдын аюулгүй тайван амьдрах, гэмт хэргээс түгших байдлын түвшнийг бууруулах, ялангуяа хөдөө орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангалтгүй зохион байгуулж байгаад анхаарч ажиллах;
3. Цагдаагийн байгууллага иргэдээс хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хуулийн дагуу шалгаж, хариу өгөх ажиллагааг шуурхай шийдвэрлэдэг байх, иргэдээс гаргасан гомдол мэдээллийн хариуг цаг тухайд нь мэдэгдэж, авсан арга хэмжээний талаар танилцуулж байх;
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод, эргэлзээгүй байдалд иргэд хамгийн доогуур үнэлгээ өгсөн байгааг анхаарч иргэдэд нээлттэй болгох мэдээллийн жагсаалтыг гаргах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, алба хаагчийн хувийн мэдээллийн талаар мэдээлэл авах хандлагатай байгаагаас шалтгаалан иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ил тод биш гэж үзэж байна. Тиймээс хуулийн хүрээнд ил болгох боломжтой мэдээллийн талаар оршин сууж буй нутаг дэвсгэрийнхээ иргэдэд мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж байх;
5. Цагдаагийн албаны тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

- тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн гудамж талбай, нийтийн эзэмшлийн газрыг бүрэн камержуулах, цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай, хүүхдийн тоглоомын газар зэрэг оршин суугчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх газрыг нэмэгдүүлэх талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад судалгааны үр дүнд үндэслэн тодорхой санал гаргаж, хамтран ажиллах;
6. Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшил, мэдлэг ур чадварыг сайжруулах талаар нэгдсэн сургалт, соёл, олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах, ялангуяа хөдөө орон нутгийн алба хаагчдад чиглэгдсэн арга хэмжээг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх;
7. Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ авах энэ аргачлалыг удирдлага болгон, судалгаанд оролцогчдын тоо, санхүүжилтийг нэмэгдүүлэх, судалгаа явуулах, дүн шинжилгээ хийх аргачлалд шинжлэх ухаанчаар хандаж бодит дүгнэлт гаргахад онцгой анхаарах;
8. Тухайн жилийн үнэлгээг өмнөх жилийнхтэй харьцуулах замаар хэрэглэгчийн үнэлгээнд гарч байгаа өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэслэн хариуцлага хүлээлгэх, урамшуулах тогтолцоонд шилжих.

ХАВСРАЛТ-I.1

ИРГЭДЭЭС АВСАН НЭЭЛТТЭЙ АСУУЛТЫН ДҮН

Баруун бүс		
Баян-Өлгий аймаг	Замын цагдаа нарын соёлыг дээшлүүлэх	4
	ЦАХ нь шуурхай, хохирогчдын эрх ашгийг хамгаалдаг байх	3
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө, сургалт байнга зохион байгуулах, сурталчлах	2
	Эмзэг бүлгийн хүмүүстэй тэгш үйлчлэх хэрэгтэй	1
	Цагдаагийн хүн, хүч хүрэлцээгүй	1
	Шөнийн цагт согтууруулах ундаагаар үйлчилдэг дэлгүүрт арга хэмжээ авч ажиллах	1
	Олон нийттэй харилцах ажлын төрлийг олшруулах	1
	Замын гэрлэн дохиог сайжруулах	1
Говь-Алтай аймаг	Нийгмийн хэв журмыг сахиулах	1
	Цагдаагийн алба хаагчид хүнтэй зөв боловсон харьцах	14
	Хуулиа бүрэн судалж эзэмшсэн, хуулиа дээдэлдэг, мөрддөг байх	5
	Нийтийн хэв журмыг сайн сахиулах	5
	Цагдаа нар дуудлага өгөхөд удаан ирдэг	4
	Хууль сурталчлан нээлттэй хаалганы өдрийг жилд 2-3 удаа хийж байх	3
	Иргэн, цагдаа хоёрын хоорондын харилцааг бэхжүүлэх	3
	Алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх	2
	Гудамж бүрт урьдчилан сэргийлэх бүлэг байгуулж ажиллах	2
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тодорхой хуулийн талаар мэдээлэл хийх	1
	Ажилтны нийгмийн асуудлыг сайжруулж, ажиллах бололцоогоор хангах	1
	Судалгааны үр дүнг бодит ажил болгох	1
Авлига авахаа зогсоох	1	
Завхан аймаг	Цагдаагийн байгууллагын ажилтнуудын харилцааны ёс зүйн төлөвшилд илүү соёлтой болгох арга хэмжээ авах	8
	ЦБ-ын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж муу	4
	Оройн цагаар хөдөлгөөнт эргүүл явуулах	4
	Улиастай хотыг бүрэн камержуулах	4
	Эргүүлийг байнга ажиллуулах	3
	Иргэдэд эрх зүй, хуулийн мэдээлэл сургалт тогтмол өгөх	3
	Цагдаагийн алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлж ажлын цол ахиулах сургалтад оролцох	3
Цагдаагийн ажлын үйл ажиллагааг ил тод байлгах	2	

	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож буй иргэнийг олж илрүүлж үйл ажиллагааг нь зогсоох	2
	Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах	2
	Цагдаа иргэдийн холбоог сайжруулах	1
	Шинэчлэгдсэн болон шинээр гарсан хууль тогтоомжийг цаг тухайд нь иргэдэд мэдээллийг түгээх	1
	Оршин сууж буй байранд багийн цагдаа нарыг тогтмол ажилтай байлгах	1
Увс аймаг	Шөнө оройн цагаар эргүүл сайн хийдэг болох	5
	ЦБ-аас хэрэг зөрчлийг шуурхай илрүүлж арга хэмжээ авч ажиллах	4
	Гудамж, эрсдэл гарч болзошгүй газарт камержуулах асуудлыг зохих байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх	3
	Сургалт, сурталчилгаа гарын авлага сайн тараах хэрэгтэй	3
	Олон нийтийн цагдааг ажиллуулах шаардлагатай	3
	Замын хөдөлгөөний байдалд анхаарч тэмдэг, түүний хэрэгжилтийг 7 хоног тутам байнга хянаж, айл өрх, иргэдэд мэдээлж байх	2
	Одоогоор ажил нь хангалттай сайн гэж бодож байна	1
	Цагдаа нар хүн ялгаварлаж торгодог	1
	Иргэдтэйгээ зөв тусч ажиллах шаардлагатай байна	1
	Техник хэрэгслээр хангах, шатах тослох материал нэмэгдүүлэх	1
Ховд аймаг	ЦАХ-ын харилцааны соёл маш өндөр баймаар байна	13
	Нутаг дэвсгэрийг хариуцсан цагдаа нар иргэдтэйгээ ойр харилцаж цагдаагийн үйл ажиллагааны талаар байнга сургалт сурталчилгаа явуулж ажиллавал сайн байна	6
	Хөдөө орон нутагт малын хулгай гарахаас өмнө таслан зогсоох мөн хулгайд малаа алдсан иргэдтэй ойр харьцаат түргэн шуурхай хулгайчийг илрүүлэх	3
	Политехник коллежийг хүүхдүүд гэмт хэрэгт холбогдох нь их байдаг. Иймээс энэ тал дээр сургуультай нь хамтран ажиллах	1
	Гадуур эргүүл сайн хийж, оройд цагдаа нарыг нэмэгдэж эргүүлээр явбал хүмүүс тайван явах боломжтой	1
	Багуудад байрлаж буй цагдаагийн постын байрыг тогтмол ажиллуулж байвал сайн байна	1
Хангайн бүс		
Архангай аймаг	Гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтыг хийх	5
	Нээлттэй арга хэмжээ зохион байгуулах	3
	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж мэдээлэл сайн өгөх, сурталчилгаа хийх	3
	Аймгийн төвийн гэрэлтүүлгийг шөнийн цагаар ажилладаг байлгах	1
	Гудамж талбайд номер сайн тавих	1
	Олон нийтийн цагдааг ажиллуулах	1

Баянхонгор аймаг	ЦАХ нь харьцааны соёл өндөртэй баймаар байна	9
	Өөрт ноогдсон ажлаа сайн хийх хяналтын камерыг бүрэн ажиллуулах хэрэгтэй, шалгуулахаар ажилладаг камер байдаггүй	6
	Хэргийг бүрэн хурдан шийдэж өгдөггүй мөнгөтэй хүнд үйлчилдэг	3
	МСҮТ болон ахлах ангийн сурагчдад хэрэг төвөгт орохгүй биеэ авч явах талаар ярих таниулга хийх	3
	Гудамжны гэрэлтүүлгийг сайжруулах	3
	Цагдаа нар бидний аюулгүй байдлын төлөө нойр хоолоо хасаад явдагт иргэн хүний хувьд сэтгэл ханамж өндөр байдаг	2
	Эргүүлийн цагдаа сайн явуулах	2
	ЦАХ-ын цалингийн асуудлыг нэмэгдүүлэх	1
Булган аймаг	Орой 22 цагаас хойш баг хороо гудамжаар эргүүл хийх шаардлагатай	2
	Иргэдийг мэдээллээр хангах	1
	Орон нутгийн телевизортой болох	1
	Цагдаад мотоцикл авч өгөх	1
	Цагдаагийн орон тоог нэмэгдүүлж, эргүүл хийх цагдааг олноор нь нэмэгдүүлэх	1
	Камержуулалт, гэрэлтүүлэг хийх	1
Орхон аймаг	ЦАХ-чид тухайн иргэдтэй хохирогч, хэрэгтэн гэж үзэхгүйгээр адил тэгш шударга хандах	4
	ЦАХ-дын харилцааны соёл, ёс зүй муу	3
	Манайд камержуулалт сайн боловч хяналт сайн тавих	2
	Иргэдтэйгээ зөв харьцаж хуулиа дээдлэх	2
	Эргүүлийн цагдааг шууд мэдээлэл өгөх авах техник, технологиор хангах	1
	Байнгын эргүүл хийж байх	1
	Багаасаа айлуудынхаа мэдээллийг авч асуудал үүсгэх магадлалтай айлуудад эргэлт хийх	1
	Баг хэсэг хариуцсан цагдаа нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах	1
Амралтын өдрүүдэд улиралд нэг удаа уулзалт хийж байх	1	
Өвөрхангай аймаг	ЦАХ иргэдтэй соёлтой харилцах	8
	Хяналтын камер байрлуулах, орчны гэрэлтүүлгийг сайжруулах шаардлагатай	7
	Эргүүлийн ажлыг сайжруулах	5
	Камержуулалтыг сайжруулах	4
	Урьдчилан сэргийлэх ажил сайн зохион байгуулах	4
	Мөрдөн байцаалт хангалтгүй хийдэг	2
	Ард түмэнтэйгээ ойр ажиллах	2
	Өөрсдөө ажилгүй амарч байх явцдаа ч ихэнх иргэд өөрсдийгөө цагдаа гэдэг	1

	Тэдний хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны багаж тоног төхөөрөмж хэрэгслээр бүрэн хангаж, эрүүл аюулгүй байх эрсдэлээс хамгаалах	1
	Архины хэрэглээг багасгаж үйлдвэрлэлийг цөөлөх	1
	Хог их байна түүнийг л цэвэрлэх хэрэгтэй	1
	Хорооны цагдаа нар ажил дээрээ байдаггүй	1
	Айлуудаас судалгаа авах	1
	Хөдөө орон нутгаар ажиллаж байгаа цагдаа нар тогтвор суурьшил муутай	1
	Архи ууж байгаа хүмүүст сургалт албадлагын эмчилгээ хийлгэх	1
Хөвсгөл аймаг	ЦАХ-ын харилцааны соёлтой байж ард иргэдээ хүндэтгэх	8
	Малын хулгай болон орон байрны хулгайг цаг алдалгүй хурдан шуурхай ирдэг байвал зүгээр байх юм	4
	Хороо гудамж хариуцсан цагдаагийн ажилчдын эргүүлийн ажлыг чангатгаж хариуцлагыг өндөржүүлэх	4
	Залуу чадалтай боловсон хүчнүүдээр бэлтгэгдмээр байна	4
	Оршин суугаа иргэдтэй уулзаж тодорхой ажил зохион байгуулах	3
	Хүнийг гадна байдлаас нь харж дүгнэж харьцахгүй байх	1
	Эзэнгүй үедээ гэр хашаагаа эргүүлдүүлж, мэдээлэл авч баймаар байна	1
	Энэ олон ажилгүй архичдыг цуглуулан ажил хийлгэмээр байна	1
	Миний бодсон үнэлгээгээр цагдаагийн байгууллагын ажил өндөр түвшинд явагдаж байдаг	1
	Цагдаагийн эргүүл явуулах	1
	Төрийн үйлчилгээний байгууллага гэдгээ ухамсарлаж ажиллах	1
	ЦБ-ын үйл ажиллагаа, ажил үүргийг олон улсын түвшинд хүргэх	1
	Хууль сурталчлах	1
	Оршин сууж буй газар нутагтаа шөнийн гэрэлтүүлэг тавьж хулгай дээрмээс хамгаалахыг хүсэж байна	1
Төвийн бүс		
Говьсүмбэр аймаг	ЦБ-ын ажилчдад ёс зүйн сургалт хийх. Мөн ард иргэдэд торгууль тавихаасаа илүү ойлгуулж ажиллах тал дээр анхаардаг байвал ард иргэдийн итгэл нэмэгдэнэ	5
	Сурталчилгааны ажил сайн хийгээд хийж байгаа ажлынхаа талаар сар бүр тайлагнаж байх хэрэгтэй	4
	Эргүүл тогтмол явуулах сургуулийн хүүхэд орой тарах үеэр ажиллуулах, камержуулах хэрэгтэй	4
	Гудамжны гэрэлтүүлэг хийх хэрэгтэй	2
	Иргэдийн саналыг сонсох	2
	Орчны бохирдолт ихтэй	1
	Бөөнөөрөө архидан согтуурч байгаа ажилгүй иргэдийг нийгэмшүүлж, ажилтай орлоготой болгох чиглэлээр ажиллах	1

	Согтууруулах ундааг ажлын бус цагаар дамлан худалдаалах явдалтай тэмцэх	1
	Хувцаслалт гадаад төрх байдалдаа анхаардаггүй	1
	Илт юмыг удаашруулдаг үнэнч шударга ажиллахыг хүсэж байна	1
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг орон нутагт бусад байгууллагуудын оролцоотой зохион байгуулах	1
	Гэр хорооллоор тогтмол эргүүл явдаг баймаар байна	5
	Гэрэлтүүлэг сайн хийх	5
	Улиралд нэг удаа баг бүр дээр гадаа талбайд нээлттэй өдөрлөг зохион байгуулж санал бодлоо солилцох	4
	Хороолол дунд цагдаагийн байгууллагад туслах албан байгууллагын туслах гишүүдийг олноор хамруулах	3
	Цагдаагийн мэдлэг боловсрол харилцааны соёлыг дээшлүүлэх	3
Дархан-Уул аймаг	Замын таних тэмдэг тэмдэглэгээг нэмэх, хөдөө замд тэмдэг заалтыг сайн тавих	2
	Цагдаагийн ажилтны хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэх	2
	Цагдаагийн тасаг, хэсгийг нэмэгдүүлэх хэрэгтэй	1
	Архинд донтсон байрны гадаа суудаг хүмүүсийг албадан ажил хийлгэж сургалт зохион байгуулах	1
	Техник тоног төхөөрөмж муу байдаг	1
	Камерыг стандарт шаардлагад хангахуйц мегафикселтэйгээр солих, нэмэгдүүлэх	1
	Орчны гэрэлтүүлгийг сайжруулж, сайн чанарын өндөр хүчин чадал бүхий камераар хангах	12
	Цагдаагийн ёс зүй, иргэдтэй харилцах талаар мэргэжлийн байгууллагад сургалт сурталчилгааг зохион байгуулах	9
	Гэмт хэргийн илрүүлэлтийг хурдан шуурхай болгох	5
	Иргэдээс ирсэн санал гомдлыг хурдан шуурхай хүлээн авдаг	4
Дорноговь аймаг	Олон нийтийн цагдааг сайн ажиллуулж аль болох иргэдтэй ойр хамтран ажиллах	4
	Хуулийн талаар иргэдтэй мэдээлэл олгох	2
	Танил тал хардаг	2
	Манай нутаг дэвсгэрт ажиллаж байгаа цагдаагийн байгууллага хангалттай сайн ажилладаг гэж боддог	2
	Машинтай эргүүлийг олон болгох, осол аюул хүчирхийлж гарч болзошгүй гудамжийг ойр ойрхон эргэж байх	2
	Хувцас хангамж жоохон хэцүү талтай	1
	Мэргэжлийн ур чадвар дунд	1
	Цагдаа болон иргэд хамтарсан эргүүл хийх, иргэд болон цагдаа нар хамтарч ажиллах, урамшуулал олгох	1
	Эрхийг минь хамгаалж чаддаггүй	1

Дундговь аймаг	Байнгын эргүүлийг ажиллуулах нэн ялангуяа орой, шөнийн цагаар	8
	Орой үдэш явахад гэрэлтүүлэг муу учир гэмт хэрэг гарах аюултай гэрэлтүүлэг, камер нэмэх сайжруулах	8
	ЦАХ харилцааны ёс зүй муу	4
	Иргэдийн мэдлэгийг сайжруулах сургалт сурталчилгааг сайн хийх	3
	Замын тэмдэг тэмдэглэгээ санамж самбарыг засмал зам дагуу тодорхой замд байрлуулах	3
	Гудамж хороонд цагдааг ажиллуулах хэрэгтэй	2
	Цагдаагийн ёс зүй журмыг баримтлах	2
	Яаралтай дуудлага өгөхөд эхлээд олон асуулт асууж цаг алдалгүй, дараа нь асууж ч болно	1
	Цагдаагийн ажилтнуудын цаг баримтлал	1
	Орчны бохирдол маш их	1
	Архидан согтуурах явдалтай, эрс шуурхай тэмцэл явуулах	1
	Цагдаа нар өөрсдөө замын дүрмээ барьдаггүй	1
	Цагдаагийн орон тоог нэмэгдүүлэх, унаажуулах	1
Өмнөговь аймаг	Гэр хороололд камержуулалт, гэрэлтүүлэг муу	7
	ЦАХ харьцааны соёл, ёс зүй маш муу	5
	Цагдаагийн зарим дарга нар танил талаараа гэмт хэрэгтнийг хамгаалах талдаа хандах хандлага ажиллагддаг	4
	Тогтмол эргүүл хийж байх	3
	Дуудлага өгөхөд хугацаа алддаг, арга хэмжээ авсан тухай хариу мэдээлдэггүй	3
	Гэр хорооллын гудамжийг нарийсгасан иргэдтэй тэмцдэггүй	1
	ЦАХ-ын ахуйн амьдрал хангамжид анхаарах тусгайлан арга хэмжээ авах, нийгмийн асуудалд нь анхаарах, сургалт сурталчилгааг сайн явуулж байх	1
	Ард иргэдтэй ойрхон байх	1
	Цагдаа нар сайн ажиллаж байгаа	1
	Гэмт хэрэг гарахаас өмнө арга хэмжээ авах	1
Сэлэнгэ аймаг	Гудамжны гэрэлтүүлэг, хаягжуулалт, камержуулалт хэрэгтэй	5
	Өргөдөл гомдлыг хөнгөн шуурхай шийддэг болмоор байна	5
	Нарийн гудамжаар эргүүл хийх	4
	Иргэдээ мэдээллээр хангах сургалт сурталчилгаа хийх	4
	Сургууль, цэцэрлэгийн тарах, хүүхэд хүлээж авах цагаар цагдаагийн байгууллага эргэн тойронд нь хяналттай ажилладаг байх	1
	Хөдөлгөөнт эргүүлийг цагдаагийн жижүүрийн үйл ажиллагааг хооронд нь нягт холбоотой болгох	1
	Миний тавьсан гомдлыг маш сайн хүлээж авч богино хугацаанд шийдвэрлэсэн. Цагдаа нар маш сайн ажилласан	1

Төв аймаг	Иргэдийг ялгаварлаж харьцдаггүй байх	11
	Шөнөөр эргүүлийн цагдаа гаргах	7
	ЦБ-ын алба хаагчид ард иргэдтэйгээ ойртож тэмцээн уралдаан зохион байгуулах	5
	Замын гэрэлтүүлэг муу	4
	Хог хаягдал их байна	3
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг байнга зохион байгуулж байх. Ингэснээр гарч болзошгүй эрсдэлээс ард иргэдийг хамгаалах нэг нөхцөл бүрдэх юм	3
	Автын цагдаа нар том машинаас татвар нэрээр мөнгө их татдаг, эсвэл торгууль ноогдуулж хүндрэл учруулдаггүй баймаар байна	2
	Хүн хүчний хүрэлцээг нэмэгдүүлэх	2
	Гудамжны архичдыг зохицуулдаггүй	2
	Төрийн бус байгууллагуудтай хамтарч цагдаагийн байгууллагын ажлыг ил тод нээлттэй болмоор байна	1
	Баар, караокены үйлчилгээг тусгаарлах, хаах цагийг багасгах	1
	Хотын захиргаа сайн ажиллахгүй байна	1
	Техник хангамжийг нэмэгдүүлэх	1
	Цагдаа нарт ёс зүйн болон нийгмийн харилцааны чиглэлээр мэргэжлийн сургалт явуулах хэрэгтэй байна	1
	Цагдаа хэсгийн төлөөлөгчийн ар гэрийг ажилтай болгомоор байна	1
Зүүн бүс		
Дорнод аймаг	Орон сууцны орчинд камержуулж хяналт тавьж байх байртай болгох	8
	Цагдаагийн алба хаагчдын харьцаа хандлага, ёс зүйн тал дээр анхаарах	7
	Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчид ажил үүргээ зөв шударга шуурхай гүйцэтгэх ёстой	7
	Гэрэлтүүлэг сайжруулах	3
	Хөдөлгөөнт эргүүлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	2
	Шөнийн эргүүлүүдийг сайжруулах	2
	Манай цагдаагийн алба хаагчид нэг үеэ бодвол харьцангуй хуулийн хүрээнд ажилладаг болсон	2
	Цагдаагийн алба хаагчид дүрэмт хувцасгүй явах үедээ зөв үлгэр дуурайлал үзүүлдэггүй	1
	Шөнийн 01 цагт гэрэлтүүлэг унтраадгийг болиулах	1
	Сургуулийн ойр орчмын явган гарц дээр анхаарах	1
Зарим тэмдэг тэмдэглэгээг сайн хийх	1	
Сүхбаатар аймаг	Цагдаагийн ажилчдын харилцааг соёлтой боловсролтой болгох	8
	Эргүүлийн цагдаа нь 24 цагаас хойш шөнийн эргүүл явуулах	4
	Сургалт сурталчилгааг иргэдэд олгож байх, орон нутгийн цагдаагийн байгууллага мэдээлэл сайн хийх	4
	Гудамж талбайг камержуулах, гэрэлтүүлэх	4

	Хуулиа сурталчилсан ажиллагаа сайн хийх	3
	Танил тал хардаг	2
	Харааны бэрхшээлтэй иргэд баг орчин тойронд цагдаагийн газар тусламж үзүүлэх	1
	Гэрлэн дохио дуут дохиоллыг мөрдөх	1
	Орой үдэш гэрт байхад айдастай	1
	Багийн цагдаатай баймаар байна	1
	Гудамжны архичдыг хүмүүжүүлэх албан хөдөлмөр хийлгэх	1
Хэнтий аймаг	Цагдаагийн алба хаагчид ёс зүйн доголдолтой иргэдтэй зөв соёлтой харьцаж, иргэдийг ялгаварлахгүй хандах	4
	Хууль дүрэм танилцуулах өдөрлөг зохион байгуулах Сургалт сурталчилгаа сайн хийх хэрэгтэй	3
	Гэр хорооллыг бүрэн сайн гэрэлтүүлэг хийх камержуулах	2
	Гэр хороолол орчинд эргүүл сайн хийх	1
	Ард иргэд дундаас цагдаа шалгаруулан авах хүсэлт төсөв гаргаж өгнө үү	1
	Монгол улсад ажиллаж байгаа цагдаагийн үйл ажиллагаагаа сайн гэдгийг итгэдэг	1
Улаанбаатар хот		
Баянгол дүүрэг	Эргүүлийн цагдаа, машин цаг хугацааг нэмэгдүүлж, тогтмол эргүүл гаргах	5
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах	5
	Дуудлага хүлээн аваад түргэн шуурхай ирдэг болох	4
	Гэр хороололд хяналтыг сайжруулах хэрэгтэй	3
	Иргэдийг хүндэтгэх	3
	Шөнийн цагаар үйл ажиллагаа муу явуулдаг, гэмт хэрэг их гарч байдаг	2
	Иргэддээ шударга хандах	2
	Ард түмнээ гэсэн сэтгэлгээг төлөвшүүлэх	2
	Цагдаагийн пост байршуулах	1
	Цагдаагийн ажилтны хүний нөөцийг нэмэгдүүлэх	1
	Ур чадварыг дээшлүүлэх	1
Сонгинохайрхан дүүрэг	Цагдаа нар иргэдтэй хамтын ажиллагааг сайжруулах	3
	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг сайн явуулах	3
	Архидан согтуурсан хүмүүст арга хэмжээ авах	2
	Камержуулалт болон гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	2
	Гэмт хэрэг зөрчил гарч болзошгүй газар камержуулалт, гэрэлтүүлэг болон эргүүлийн цагдаа нарыг тавих	2
	Дуудлага өгөхөд цаг хугацаандаа ирэх	1
	Үргэлж сонор сэрэмжтэй байж хаяг байршлаа сайн мэддэг байхаас гадна хүнийг ялгаварлан харьцахгүй байвал зохино	1

Сүхбаатар дүүрэг	Эргүүлийн ажиллагааг сайжруулах	2
	Дүүрэг дүүргийн цагдаа нар хороо нь дээрээ жижүүрт суудаг байвал маш сайн байна	1
	Гэрэлтүүлэг бүрэн тавих шаардлагатай байна	1
	Асуудалд шуурхай хандах	1
	Ард иргэдтэй хамтарсан үйл ажиллагаа зохион байгуулах	1
	Камерын хяналтыг сайжруулах	1
	Эргүүл шалгалт болон алба хаагчдын тоог нэмэгдүүлж техник хэрэгслийн чадамжийг дээшлүүлж ажиллах	1
Чингэлтэй дүүрэг	Харанхуй орчныг гэрэлтүүлэх камержуулах	4
	Оройн цагаар эргүүлийг сайн гаргах	2
	Хулгайд алдсан юм илрүүлэлт сайн байх хэрэгтэй байна	2
	Цагдаагаас хүн хүч байхгүй бол ард иргэдийн дунд нууц постыг өдөх тутамд гаргаж баймаар байна	1
	Гэмт хэрэг илрүүлэхэд шаардагдах багаж хэрэгсэл машин техник сайтай мөн эргүүлийн машин нэмэх хэрэгтэй	1
Хулгайг сайн илрүүлэх	1	
Хан-Уул дүүрэг	Иргэн болгоны хүсэлт гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж байх	2
	Цагдаа нар харилцааны соёлтой байх	2
	Камер, гэрэлтүүлгээр бүрэн хангах	2
	Сургалт зохион байгуулах, гадаадад мэргэжил дээшлүүлэх	2
	Эргүүл хийж байгаа цагдаагийн ажилтан гудамж нэг бүрээр шалгаж байх	2
	Ажилгүй тэнэмэл архичдыг байхгүй болгох	1
	Том тэргийг явуулахыг хориглох	1
	Агаарын бохирдолтой тэмцэх	1
	Цагдаагийн байгууллагын ур чадвар сайжирсаар байгаа	1
Цагдаагийн ажилчид гайгүй боломжийн ажилладаг	1	
Баянзүрх дүүрэг	Байр, машины зогсоол, гэр хорооллыг бүрэн камержуулах	4
	Иргэдийн гомдол саналыг хурдан шийдэх	2
	Цагдаа нар эрх үүргийнхээ дагуу зөв боловсон харьцах	2
	Гэмт хэргийн талаарх мэдээллийг хохирогчдод мэдээлж байх	1
	Цагдаагийн байгууллагын салбар нэгжийн байршлыг дэлгэрэнгүй танилцуулах хэрэгтэй	1
	Ард иргэдтэй илүү ойрхон байж илүү тод ажиллах	1
	Үүргээ сайн биелүүлдэг	1
Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа	1	



АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

II

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	125
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	126
СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	128
НЭГ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ	130
1.1 Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	130
1.1.1 Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	131
1.1.2 Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	132
1.1.3 Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	133
1.1.4 Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	134
1.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	135
ХОЁР. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БА АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ	136
2.1 Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	136
2.1.1 Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	138
2.1.2 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	139
2.1.3 Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	140
2.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	141
2.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	142
ГУРАВ. ХУУЛЬ ЁСНЫ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТЭД АЛБА ХААГЧДЫН ӨГСӨН ҮНЭЛГЭЭ	143
3.1 Улсын хэмжээнд хууль ёсны зарчмын хэрэгжилтэд алба хаагчдын өгсөн үнэлгээ	143
3.1.1 Төвийн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ	145
3.1.2 Баруун бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ	146
3.1.3 Хангайн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ	147
3.1.4 Зүүн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ	148
3.1.5 Улаанбаатар хотын алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ	148

ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ТАЛААРХ АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ	150
4.1 Улсын хэмжээнд хүний нөөцийн бодлогын талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	150
4.1.1 Төвийн бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	153
4.1.2 Баруун бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	155
4.1.3 Хангайн бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	157
4.1.4 Зүүн бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	159
4.1.5 Улаанбаатар хотын алба хаагчдийн хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	160
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙ	162
5.1 Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ	162
5.1.1 Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ	164
5.1.2 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ	165
5.1.3 Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ	166
5.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ	167
5.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ	168
ЗУРГАА. УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ	170
6.1 Улсын хэмжээнд цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ	170
6.1.1 Төвийн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ	172
6.1.2 Баруун бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ	173
6.1.3 Хангайн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ	174
6.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ	174
6.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ	175
ДОЛОО. АЛБА ХААГЧИЙН БАТАЛГАА	177
7.1 Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	177
7.1.1 Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	179
7.1.2 Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	180

7.1.3	Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	181
7.1.4	Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	182
7.1.5	Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	183
НАЙМ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН АЛБАНДАА ХАНДАХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН НЭГДСЭН ДҮН		
8.1	Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ	185
ЕС. НЭЭЛТТЭЙ АСУУЛТЫН ХАРИУЛТ		
9.1	Цагдаагийн алба хаагчийн албандаа сэтгэл ханамжтай байхад нөлөөлөх хүчин зүйлс	188
9.2	Цагдаагийн алба хаагчийн албандаа сэтгэл ханамжгүй байхад нөлөөлөх хүчин зүйлс	189
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ		
ЗӨВЛӨМЖ		
ХАВСРАЛТ-II.1		
ХАВСРАЛТ-II.2		

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт II.1.	Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын ерөнхий мэдээлэл	128
Хүснэгт II.2.	Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	131
Хүснэгт II.3.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ	137
Хүснэгт II.4.	Улсын хэмжээнд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	144
Хүснэгт II.5.	Улсын хэмжээнд хүний нөөцийн бодлогын үнэлгээ	151
Хүснэгт II.6.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, бүсээр	163
Хүснэгт II.7.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ, бүсээр	171
Хүснэгт II.8.	Улсын хэмжээнд алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, бүсээр	178
Хүснэгт II.9.	Цагдаагийн алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийн нэгдсэн дүн (аймаг, дүүргээр)	186
Хүснэгт II.10.	Цагдаагийн алба хаагчдын албандаа сэтгэл ханамжтай байхад нөлөөлөх хүчин зүйлс, давталтаар	188
Хүснэгт II.11.	Цагдаагийн алба хаагчдын албандаа сэтгэл ханамжгүй байхад нөлөөлөх хүчин зүйлс, давталтаар	190

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График II.1.	Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, бүсээр	131
График II.2.	Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээг улсын дундажтай харьцуулсан байдал	132
График II.3.	Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	133
График II.4.	Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	133
График II.5.	Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	134
График II.6.	Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, дүүргээр	135
График II.7.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ	137
График II.8.	Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ, аймгаар	138
График II.9.	Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ, аймгаар	139
График II.10.	Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ, аймгаар	140
График II.11.	Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ, аймгаар	141
График II.12.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ, дүүргээр	142
График II.13.	Улсын хэмжээнд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	144
График II.14.	Төвийн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар	145
График II.15.	Баруун бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар	146
График II.16.	Хангайн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар	147
График II.17.	Зүүн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар	148
График II.18.	Улаанбаатар хотын алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, дүүргээр	149
График II.19.	Улсын хэмжээнд хүний нөөцийн бодлогын үнэлгээ, бүсээр	152
График II.20.	Төвийн бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын үнэлгээ, аймгаар	154
График II.21.	Баруун бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын үнэлгээ	156
График II.22.	Хангайн бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын үнэлгээ	158
График II.23.	Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын үнэлгээ, аймгаар	159
График II.24.	Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын үнэлгээ, дүүргээр	161
График II.25.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, бүсээр	164

График II.26.	Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, аймгаар	165
График II.27.	Баруун бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, аймгаар	166
График II.28.	Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, аймгаар	167
График II.29.	Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, аймгаар	168
График II.30.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, дүүргээр	169
График II.31.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ, бүсээр	171
График II.32.	Төвийн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ, аймгаар	172
График II.33.	Баруун бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ	173
График II.34.	Хангайн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ	174
График II.35.	Зүүн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ, аймгаар	175
График II.36.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ, дүүргээр	176
График II.37.	Улсын хэмжээнд алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, бүсээр	179
График II.38.	Төвийн бүсийн алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, аймгаар	180
График II.39.	Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, аймгаар	181
График II.40.	Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, аймгаар	182
График II.41.	Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	183
График II.42.	Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, дүүргээр	184
График II.43.	Цагдаагийн алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийн нэгдсэн үнэлгээ	187
График II.44.	Цагдаагийн алба хаагчдын албандаа сэтгэл хангалуун байхад нөлөөлөх хүчин зүйлс, хувиар	189
График II.45.	Цагдаагийн алба хаагчдын албандаа сэтгэл ханамжгүй байхад нөлөөлөх хүчин зүйлс, хувь	191

СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд оролцсон нийт 402 албан хаагчийн 81.1 хувь нь эрэгтэй, 18.9 хувь нь эмэгтэй, насны бүлгээр нь авч үзвэл 30-39 насныхан хамгийн өндөр буюу 44 хувийг эзэлж байв.

Хүснэгт II.1. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын ерөнхий мэдээлэл

Үзүүлэлт	Шинж байдал	Судалгаанд хамрагдсан алба хаагчдын тоо, бүсээр					Бүгд	
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар хот		
Хүйс	Эрэгтэй	58	70	85	42	71	326	81.1
	Эмэгтэй	11	17	22	9	17	76	18.9
	Нийт	69	87	107	51	88	402	100
Нас	20-29	33	30	38	24	27	152	37.8
	30-39	28	44	50	17	38	177	44
	40-49	8	13	18	10	21	70	17.4
	50 ба түүнээс дээш	-	-	1	-	2	3	0.8
	Нийт	69	87	107	51	88	402	100
Ажилладаг алба	Мөрдөх алба	8	11	10	4	11	44	10.9
	Эрүүгийн мөрдөх алба	18	20	30	9	24	101	25.1
	Нийтийн хэв журам хамгаалах алба	21	26	40	26	33	146	36.3
	Замын цагдаагийн алба	11	9	11	4	2	37	9.2
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба	11	2	2	2	4	10	2.5
	Захиргаа, хүний нөөц	8	13	11	4	8	47	11.7
	Бусад	18	6	3	2	6	17	4.2
	Нийт	95	87	107	51	88	402	100

Ажил эрхэлж буй нэгж	Цагдаагийн ерөнхий газар	1	1	-	1	-	3	0.7
	Нийслэлийн цагдаагийн газар	-	-	-	-	6	6	1.5
	Аймаг, дүүргийн цагдаагийн газар хэлтэс	64	80	102	47	81	374	93
	Сум, хорооны цагдаагийн нэгж	4	6	5	3	1	19	4.7
	Нийт	69	87	107	51	88	402	100
Цагдаагийн цол	Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүн	29	33	44	22	27	155	38.6
	Цагдаагийн дунд офицер	37	39	46	27	44	193	48
	Цагдаагийн ахлах офицер	3	15	17	2	16	53	13.2
	Цагдаагийн дээд офицер	-	-	-	-	1	1	0.2
	Нийт	69	87	107	51	88	402	100
Ажлын чиг үүрэг	Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй	66	83	95	44	75	363	90.3
	Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэггүй	3	4	12	7	13	39	9.7
	Нийт	69	87	107	51	88	402	100
Ажилласан жил	5 хүртэлх	25	21	36	20	16	118	29.4
	5-10	15	25	15	12	25	92	22.9
	10-15	17	20	24	10	20	91	22.6
	15-20	9	11	19	4	16	59	14.6
	20 ба түүнээс дээш	3	10	13	5	11	42	10.4
	Нийт	69	87	107	51	88	402	100

Эх үүсвэр: судлаачийн spss21 програм дээр боловсруулсан үр дүн

НЭГ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

Цагдаагийн байгууллагад хийгдэж байгаа шинэтгэл оновчтой байгаа эсэхийг тодорхойлох нэг шалгуур үзүүлэлт нь алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамж юм. Алба хаагчдын сэтгэл ханамжид цагдаагийн байгууллагын бодлого, алба хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж буй байдал, хүний нөөцийн бодлого, шийдвэр, удирдлагын манлайлал, алба хаагчийн баталгаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Энэ хэсэгт цагдаагийн алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийг тодорхойлох дараах ерөнхий 3 асуултыг судалгаанд оролцогчдод тавьж, үр дүнг боловсруулав. Үүнд:

- Би цагдаагийн алба хаагч гэж өөрөөрөө үргэлж бахархдаг
- Миний гэр бүлийн гишүүд намайг цагдаагийн алба хаагч гэдгээр бахархдаг
- Би одоогийн ажлын байр, үүрэгт ажилдаа сэтгэл хангалуун байдаг.

Эдгээр асуултын хариултуудад дүн шинжилгээ хийж үр дүнг улс болон бүсүүдээр гаргав.

1.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Судалгаанаас харахад цагдаагийн алба хаагчийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ улсын хэмжээнд 4.35 байгаа нь тэд ажилдаа **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулж байна. Баруун болон Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамж улсын дунджаас дээгүүр, Улаанбаатар болон Төв, Зүүн бүсүүдийн алба хаагчид тус бүр улсын дунджаас доогуур үнэлгээ өгчээ. “Би одоогийн ажлын байр, үүрэгт ажилдаа сэтгэл хангалуун байдаг” гэсэн асуултад Улаанбаатар хотын алба хаагчид хамгийн бага (3.76) үнэлгээ өгчээ. Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээг Хүснэгт II.2-т харуулав.

Гурван асуултын ерөнхий дундаж үнэлгээ нь 4.22-4.47 байгаа бөгөөд асуулт тус бүрээр улсын хэмжээнд алба хаагчид


ямар үнэлгээ өгснийг бүсээр ангилан График II.1-д нэгтгэн харуулав.

Хүснэгт II.2. Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ

Бүсээр	Улсын дундаж үнэлгээ	Үнэлгээний утга	Төвийн бүс	Баруун бүс	Хангайн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Би цагдаагийн алба хаагч гэж өөрөөрөө үргэлж бахархдаг	4.47	Сэтгэл ханамж өндөр	4.48	4.58	4.43	4.44	4.23
Миний гэр бүлийн гишүүд намайг цагдаагийн алба хаагч гэдгээр бахархдаг	4.35	Сэтгэл ханамж өндөр	4.31	4.45	4.37	4.16	4.05
Би одоогийн ажлын байр, үүрэгт ажилдаа сэтгэл хангалуун байдаг	4.22	Сэтгэл ханамж өндөр	4.24	4.43	4.24	4.3	3.76
Дундаж	4.35		4.34	4.49	4.35	4.33	4.01

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График II.1. Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, бүсээр



1.1.1 Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ


Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамж бусад бүстэй харьцуулахад өндөр (ерөнхий үнэлгээ

нь 4.34) байгаа хэдий ч улсын дунджаас 0.01 пунктээр доогуур байна. Төвийн бүсийн хувьд нийт 3 асуултын дундаж үнэлгээ 4.22-4.48 байгаа бөгөөд асуулт тус бүрээр аймгуудын үнэлгээг График II.2-т нэгтгэн харуулав.

Уг графикаас харахад Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудын алба хаагчид улсын дунджаас дээгүүр, Өмнөговь, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудынх улсын дунджаас доогуур үнэлгээ өгчээ. “Би

одоогийн ажлын байр, үүрэгт ажилдаа сэтгэл хангалуун байдаг” гэсэн асуултад Говь-Сүмбэр аймгийн алба хаагчид **сэтгэл ханамж дунд зэрэг** гэсэн нь хамгийн бага үнэлгээ (3.67) байв.

График II.2. Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээг улсын дундажтай харьцуулсан байдал




1.1.2 Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ

Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ нь 4.49 буюу тэд ажилдаа **сэтгэл ханамж өндөр** байгааг илэрхийлж байна. Энэ нь улсын дунджаас 0.14 пунктээр дээгүүр байна. Нийт 3 асуултын дундаж үнэлгээ нь 4.42-4.59 байгаа ба асуулт тус бүрээр аймгуудыг үнэлгээг нэгтгэн График II.3-т харуулав.

Уг графикаас харахад Говь-Алтай, Увс, Завхан, Баян-Өлгий аймгууд улсын

дунджаас дээгүүр, Ховд аймаг улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн цагдаагийн алба хаагчид “Би цагдаагийн алба хаагч гэж өөрөөрөө бахархдаг” гэсэн асуултад хамгийн өндөр (4.93) үнэлгээтэй байна. Энэ нь алба хаагчид ажилдаа бараг 100 хувь **сэтгэл ханамжтай** байгааг харуулж байгаа бол Ховд аймгийн алба хаагчид энэ асуултад хамгийн бага үнэлгээ өгсөн байна. Бүсийн хэмжээнд авч үзвэл, алба хаагчид ерөнхийдөө ажилдаа сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлжээ.

График II.3. Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар




1.1.3 Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ

Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын ажилдаа хандах сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ нь 4.35 байгаа бөгөөд **сэтгэл ханамж өндөр** байгааг илэрхийлж байна. Энэ нь улсын дундажтай харьцуулахад ижил түвшинд байна. Нийт 3 асуултын дундаж үнэлгээ

нь 4.27-4.42 байгаа бөгөөд асуулт тус бүрээр аймгуудын үнэлгээг нэгтгэн График II.4-т харуулав.

График II.4-өөс үзэхэд Хөвсгөл, Баянхонгор, Архангай аймгууд нь улсын дунджаас дээгүүр, Булган, Өвөрхангай, Орхон аймгийн алба хаагчид улсын дунджаас доогуур үнэлгээ өгчээ.

График II.4. Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар




Дээрх судалгаанаас үзэхэд Архангай аймаг 2 үзүүлэлтээр хамгийн өндөр үнэлгээ авсан бол Хөвсгөл, Булган аймгийн цагдаагийн алба хаагчид “Миний гэр бүлийн гишүүд намайг цагдаагийн алба хаагч гэдгээр бахархдаг” гэсэн асуултад хамгийн доогуур үнэлгээ өгчээ.

1.1.4 Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ

Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ 4.34 буюу **сэтгэл ханамж өндөр** байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 0.01 пунктээр доогуур үзүүлэлт юм. Нийт 3 асуултын дундаж үнэлгээ нь 4.16-4.50 хооронд гарчээ. Асуулт тус бүрээр аймгуудын дүнг нэгтгэн График II.5-д харуулав.

График II.5-аас харахад Дорнод, Сүхбаатар аймгууд улсын дунджаас дээгүүр, Хэнтий аймаг улсын дунджаас доогуур үнэлгээ өгчээ. “Би одоогийн ажлын байр, үүрэгт ажилдаа сэтгэл хангалуун байдаг” гэсэн асуултад Хэнтий аймгийн цагдаагийн алба хаагчдын өгсөн үнэлгээ 3.74 байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Энэ нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Хэнтий аймгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ нь зүүн бүсийн бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй өндөр байсан бол эсрэгээрээ алба хаагчид албандаа хандах сэтгэл ханамж доогуур байгаа нь сонирхол татаж байна.

График II.5. Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар




1.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ

Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ нь 4.01 бөгөөд ажилдаа **сэтгэл ханамж өндөр** байгааг илэрхийлэх дүн боловч улсын дунджаас 0.34 пунктээр доогуур байна. Улсын дундажтай харьцуулахад Сүхбаатар дүүрэг 3, Баянгол дүүрэг 1 үзүүлэлтээр дээгүүр, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх, Хан-Уул дүүргийн алба хаагчид бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ өгчээ. Нийт 3 асуултад Сонгинохайрхан дүүргийн алба

хаагчид хамгийн бага үнэлгээ өгсөн байв. Цагдаагийн алба хаагчдын өгсөн үнэлгээг дүүрэг тус бүрээр График II.6-д харуулав.

Доорх судалгаанаас дүгнэхэд хотын төвийн дүүргүүдтэй харьцуулахад захын хорооллын буюу гэр хороолол ихтэй, хүн ам төвлөрсөн дүүргүүдэд ажилладаг цагдаагийн алба хаагчид сэтгэл ханамж харьцангуй доогуур байна. Энэ нь ажлын орчин нөхцөл, ачаалал, техник хэрэгслийн хангамжаас шалтгаалдаг байх магадлалтай. Тухайлбал Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх, Хан-Уул дүүргийг дурдаж болно.

График II.6. Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, дүүргээр



ХОЁР. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БА АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн”¹, мөн хуулийн 10, 11, 12 дугаар зүйлд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэгт гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн. Тиймээс цагдаагийн байгууллага хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрхэн биелүүлж байгаа, тэдгээрийг биелүүлэх боломж нөхцөл бүрдсэн эсэх, мэргэжлийн ур чадвараа өөрсдөө хэрхэн үнэлж байгаагаар алба хаагчдын сэтгэл ханамжийн түвшин тодорхойлогддог. Энэ хэсэгт цагдаагийн байгууллага үндсэн чиг үүргээ хэрхэн биелүүлж байгаа байдалд алба хаагчдын сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор дараах 4 асуултын хүрээнд судалгаа авч

¹ Цагдаагийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 2017, №8.

дүнг боловсруулав. Үүнд: (i) Цагдаагийн байгууллага жил бүр тодорхой зорилт дэвшүүлж, түүнийгээ үр дүнтэй биелүүлж ажилладаг, (ii) Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг, (iii) Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж чаддаг, (iv) Цагдаагийн байгууллага нь хэв журам сахиулах, нийтийг хамарсан жагсаал цуглааны үед мэргэжлийн түвшинд ажиллаж чаддаг гэсэн асуултууд багтсан.

2.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААРХ АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Цагдаагийн байгууллагын бодлого, үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамж улсын хэмжээнд **дунд зэрэг** (3.48) байна. Төв, Баруун, Хангайн бүсүүдийн алба хаагчид улсын дунджаас дээгүүр, Зүүн бүс болон Улаанбаатар хотын алба хаагчид улсын дунджаас доогуур үнэлжээ.

“Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг” гэсэн асуултад Төвийн бүсийн алба хаагчид хамгийн бага (2.15) үнэлгээ өгсөн нь анхаарал татаж

байна (Хүснэгт II.3).


Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 2.44-3.86 хооронд байгаа бөгөөд асуулт тус бүрээр алба хаагчид ямар үнэлгээ өгснийг График II.7-д харуулав.

Хүснэгт II.3. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ

Асуултууд	Дундаж үнэлгээ					
	Улс	Төвийн бүс	Баруун бүс	Хангайн бүс үнэлгээ	Зүүн бүс	Улаанбаатар хот үнэлгээ
Цагдаагийн байгууллага жил бүр тодорхой зорилт дэвшүүлж, түүнийг үр дүнтэй биелүүлж ажилладаг	3.86	3.93	3.87	3.98	4.0	3.51
Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг	2.44	2.15	2.77	2.71	2.25	2.32
Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж чаддаг	3.88	3.96	4.13	3.97	3.88	3.44
Цагдаагийн байгууллага нь хэв журам сахиулах, нийтийг хамарсан жагсаал цуглааны үед мэргэжлийн түвшинд ажиллаж чаддаг	3.74	3.93	3.78	3.86	3.63	3.51
Дундаж	3.48	3.49	3.64	3.63	3.44	3.2

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График II.7. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ



Дээрх графикаас харахад “Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг” гэсэн асуултад Улаанбаатар хотоос гадна 4 бүсийн цагдаагийн алба хаагчид **сэтгэл ханамжгүй** байдаг гэдгээ илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл, алба хаагчдын ажилдаа сэтгэл ханамжтай байхад нөлөөлөх хамгийн гол хүчин зүйл нь ажлын ачаалал гэж дүгнэж болохоор байна.

2.1.1 Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ


Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ 3.49 байгаа нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг илэрхийлэх бөгөөд энэ нь улсын дунджаас 0.01 пунктээр

дээгүүр үзүүлэлт юм.

“Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг” гэсэн асуултад Говьсүмбэр аймгийн алба хаагчид хамгийн бага буюу 1.73 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамж маш муу** байгааг илэрхийлнэ. Төвийн бүсийн бүх аймаг улсын дунджаас доогуур үнэлгээтэй гарчээ. Нийт 4 асуултын дундаж үнэлгээ нь 2.15-3.96 хооронд байгаа ба асуулт тус бүрээр төвийн бүсийн үнэлгээг График II.8-д нэгтгэн харуулав.

Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх сэтгэл ханамжийг тодорхойлох 4 асуултад Өмнөговь, Дундговь, Дархан-Уул аймгууд гурван үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр, Говьсүмбэр, Сэлэнгэ, Төв аймгууд хоёр үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлэгдсэн байна.

График II.8. Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ, аймгаар




2.1.2 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ

Баруун бүсийн цагдаагийн байгууллагын бодлого, үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамж 3.66 буюу **дунд зэрэг** гарсан нь улсын дунджаас 0.18 пунктээр дээгүүр байна. Тодруулбал Говь-Алтай, Увс, Завхан аймгууд улсын дунджаас дээгүүр, Ховд, Баян-Өлгий аймгуудын алба хаагчид улсын дунджаас доогуур тус тус үнэлжээ. “Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг” гэсэн асуултад Баян-Өлгий аймгийн алба хаагчид бүсийн хэмжээнд хамгийн бага буюу 2.57 үнэлгээ авсан нь **сэтгэл ханамж муу** байгааг илэрхийлнэ. Гэсэн хэдий ч энэ асуултын хувьд баруун бүсийн

алба хаагчдын өгсөн үнэлгээ улсын дундажтай харьцуулахад харьцангуй дээгүүр байна. Харин Завхан аймгийн цагдаагийн алба хаагчид дээрх асуултад хамгийн өндөр буюу 3.4 үнэлгээ өгсөн нь бусад аймагтай харьцуулахад **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулж байна. Мөн “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж чаддаг” гэсэн асуултад Завхан аймаг хамгийн өндөр үнэлгээ өгчээ. Бүсийн ерөнхий дундаж үнэлгээ 2.81-4.15 хооронд байгаа бөгөөд асуулт тус бүрээр аймгуудын үнэлгээг График II.9-д нэгтгэн харуулав.

Баруун бүсийн хувьд цагдаагийн байгууллагын бодлого, үндсэн чиг үүргийн талаарх сэтгэл ханамжийг тодорхойлох 4 асуултад Говь-Алтай, Завхан, Увс аймгууд улсын дунджаас дээгүүр, Ховд, Баян-Өлгий аймгууд 3 асуултад улсын дунджаас доогуур үнэлэгджээ.

График II.9. Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ, аймгаар



2.1.3 Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ


Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын бодлого, үндсэн чиг үүргийн талаарх сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ 3.63 байгаа нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байна. Энэ нь улсын дунджаас 0.15 пунктээр дээгүүр үзүүлэлт юм.

Хөвсгөл, Баянхонгор, Архангай, Булган, Өвөрхангай аймгууд улсын дунджаас дээгүүр, Орхон аймгийн алба хаагчид улсын дунджаас доогуур үнэлгээ өгчээ. Хангайн бүсийн хувьд 4 асуултын дундаж үнэлгээ нь 2.72-4.0 хооронд байгаа

бөгөөд асуулт тус бүрээр аймгуудын дүнг График II.10-г нэгтгэн харуулав.

“Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг” гэсэн асуултад Булган аймгийн алба хаагчид хамгийн бага буюу 2.47 үнэлгээ өгчээ. Харин “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж чаддаг”, “Цагдаагийн байгууллага нь хэв журам сахиулах, нийтийг хамарсан жагсаал цуглааны үед мэргэжлийн түвшинд ажиллаж чаддаг” гэсэн асуултуудад Булган аймаг хамгийн өндөр (4.27) үнэлгээ өгсөн нь улсын дунджаас 0.39-0.53 пунктээр дээгүүр үзүүлэлт юм.

График II.10. Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ, аймгаар



2.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ


Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын бодлого, үндсэн чиг үүргийн талаарх сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ 3.45 байгаа нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг илэрхийлэх бөгөөд энэ нь улсын дунджаас 0.03 пунктээр доогуур үзүүлэлт юм.

Сүхбаатар аймаг гурав, Хэнтий аймаг хоёр, Дорнод аймаг нэг үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Дорнод аймаг гурав, Хэнтий аймаг хоёр үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас доогуур байна. Зүүн бүсийн хувьд нийт

4 асуултын дундаж үнэлгээ нь 2.27-4.01 хооронд байгаа бөгөөд асуулт тус бүрээр аймгуудын үнэлгээг График II.11-д нэгтгэн харуулав.

“Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг” гэсэн асуултад Хэнтий аймгийн алба хаагчид 2.0 гэсэн үнэлгээ өгсөн нь бүсийнхээ хувьд хамгийн бага үзүүлэлт болов. “Цагдаагийн байгууллага жил бүр тодорхой зорилт дэвшүүлж, түүнийг үр дүнтэй биелүүлж ажилладаг” гэсэн асуултад Сүхбаатар аймгийн алба хаагчид 4.19 гэсэн үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт ба улсын дунджаас 0.33 пунктээр дээгүүр байна.

График II.11. Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ, аймгаар



2.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ


Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчид байгууллагынхаа бодлого, үндсэн чиг үүргээ гүйцэтгэж буй байдалд **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.19) байгаа нь улсын дунджаас 0.29 пунктээр доогуур үзүүлэлт юм.

Баянгол дүүрэг гурав, Хан-Уул дүүрэг нэг үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй байгаа бол Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, дүүргүүд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлэгджээ. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотод ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид орон нутагт ажиллаж буй алба хаагчидтай харьцуулахад **сэтгэл ханамж харьцангуй доогуур** байна. Улаанбаатар хотын хувьд нийт 4 асуултын дундаж

үнэлгээ 2.31-3.51 хооронд байгаа бөгөөд асуулт тус бүрээр дүүргүүдийн үнэлгээг График II.12-т нэгтгэн харуулав.

“Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг” гэсэн асуултад Сонгинохайрхан дүүргийн алба хаагчид хамгийн бага буюу 2.07 үнэлгээ өгсөн нь улсын дунджаас 0.37 пунктээр доогуур үзүүлэлт юм. Доорх графикаас харахад хүн ам төвлөрсөн, ажлын ачаалал ихтэй дүүргийн цагдаагийн алба хаагчид ажилдаа хандах **сэтгэл ханамж доогуур** байна. Харин “Цагдаагийн байгууллага жил бүр тодорхой зорилт дэвшүүлж, түүнийг үр дүнтэй биелүүлж ажилладаг” гэсэн асуултад Баянгол дүүргийн алба хаагчид 4.00 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.14 пунктээр дээгүүр үзүүлэлт юм.

График II.12. Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх алба хаагчдын үнэлгээ, дүүргээр



ГУРАВ. ХУУЛЬ ЁСНЫ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТЭД АЛБА ХААГЧДЫН ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Үндсэн хуульд хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заажээ. Цагдаагийн албаны тухай хуулийн Цагдаагийн төв байгууллагын бүрэн эрх гэсэн 21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх хэсэгт “Цагдаагийн байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” үүргийг заасан. Тиймээс цагдаагийн алба хаагчийн сэтгэл ханамжийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь байгууллагын доторх хууль, тогтоомжийн хэрэгжилт, алба хаагчийн хууль ёсны эрх ашиг, сонирхол хангагдаж байгаагаар илэрдэг. Цагдаагийн байгууллага нь хагас цэргийн зохион байгуулалттай, тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг, удирдлагын босоо тогтолцоотой байдгаас шалтгаалан алба хаагчдын эрх ашиг зөрчигдөж болзошгүй байдаг. Тиймээс улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсны зарчим хэрхэн мөрдөгдөж буй өнөөгийн байдлыг дараах 3 асуултаар шалган дүнг улс, Улаанбаатар хот болон дөрвөн бүсээр нэгтгэн дүгнэлээ. Үүнд: (i) Цагдаагийн

алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр баримтлан ажилладаг, (ii) Байгууллагын хэмжээнд алба хаагчтай холбоотой гаргаж байгаа шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомжид ихэвчлэн нийцсэн байдаг, (iii) Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг гэсэн асуултууд багтсан.

3.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУУЛЬ ЁСНЫ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТЭД АЛБА ХААГЧДЫН ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Улсын хэмжээнд хууль ёсны хэрэгжилтэд алба хаагчдын сэтгэл ханамж **дунд зэрэг** (3.61) үнэлгээтэй гарлаа. Төв, Баруун болон Хангайн бүсүүд улсын дунджаас дээгүүр, Зүүн бүс болон Улаанбаатар хотын алба хаагчид улсын дунджаас доогуур тус тус үнэлжээ.

Нийт 3 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.12-4.06 хооронд байгаа бөгөөд асуулт тус бүрээр өгсөн дундаж үнэлгээг Хүснэгт II.4-т харуулав.

“Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг” гэсэн асуултад Улаанбаатар хотын алба хаагчид хамгийн бага (2.75) үнэлгээ өгсөн нь улсын дунджаас 0.37 пунктээр доогуур


буюу **сэтгэл ханамжгүй** байдлыг илэрхийлж байна. Хүснэгтээс II.4-өөс харахад Улаанбаатар хотод ажиллаж буй алба хаагчид өөрсдийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргадаг гэдэгтэй алба хаагчид санал нэгдэж байна. Судалгааны үр дүнг График II.13-т нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт II.4. Улсын хэмжээнд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ

Асуултууд	Улсын хэмжээнд	Төвийн бүс	Баруун бүс	Хангайн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр баримтлан ажилладаг	4.06	4.1	4.28	4.14	4.0	3.77
Байгууллагын хэмжээнд алба хаагчтай холбоотой гаргаж байгаа шийдвэр нь Монгол улсын хууль тогтоомжид ихэвчлэн нийцсэн байдаг	3.65	3.69	3.8	3.77	3.53	3.44
Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг	3.12	3.04	3.25	3.33	3.24	2.75
Дундаж үнэлгээ	3.61	3.61	3.78	3.75	3.59	3.32

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График II.13. Улсын хэмжээнд хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ



“Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр баримтлан ажилладаг, үйл ажиллагаагаа хуулийн дагуу явуулдаг” гэдэгтэй алба хаагчдын дийлэнх нь санал нэгдсэн бол “Байгууллагын хэмжээнд алба хаагчтай холбоотой гаргаж байгаа шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомжид ихэвчлэн нийцсэн байдаг” гэдэг асуултад алба хаагчдын сэтгэл ханамж **дунд зэрэг** байна.


3.1.1 Төвийн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ

Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчид байгууллагынхаа хууль ёсны зарчмын хэрэгжилтийг **дунд зэрэг** (3.61) гэж үнэлсэн нь улсын дунджаас 0.01 пунктээр доогуур байна. Өмнөговь,

Дархан-Уул, Дундговь аймгууд улсын дунджаас дээгүүр, Говьсүмбэр, Төв, Сэлэнгэ, Дорноговь аймгууд тус тус улсын дунджаас доогуур үнэлжээ. Төвийн бүсийн хувьд нийт 3 асуултын дундаж үнэлгээ 3.03-4.10 хооронд байгаа бөгөөд асуулт тус бүрээр төвийн бүсийн үнэлгээг улсын дундажтай харьцуулан График II.14-т нэгтгэн харуулав.

“Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг” гэсэн асуултад Төв аймаг 2.47, Говьсүмбэр аймаг 2.87 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлэх үзүүлэлт юм. Харин Өмнөговь аймаг дээрх асуултад 3.5 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт боллоо.

График II.14. Төвийн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар



“Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр баримтлан ажилладаг” гэсэн асуултад Өмнөговь аймаг 4.5, Дархан-Уул аймаг 4.19, Дундговь аймаг 4.33 гэсэн үнэлгээтэй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд **сэтгэл ханамжтайг** илэрхийлж байна. “Байгууллагын хэмжээнд алба хаагчтай холбоотой гаргаж байгаа шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомжид ихэвчлэн нийцсэн байдаг”, “Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг” гэсэн асуултуудад Өмнөговь аймаг хамгийн өндөр үнэлгээтэй гарчээ.

3.1.2 Баруун бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ


Баруун бүсийн цагдаагийн байгууллагын алба хаагчид байгууллагынхаа хууль ёсны зарчмын хэрэгжилтэд **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.78) байна. Баруун бүсийн

хувьд нийт 3 асуултын ерөнхий дундаж үнэлгээ нь 3.28-4.28 хооронд байгаа бөгөөд аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр График II.15-д нэгтгэн харуулав.

Ховд аймгийн алба хаагчид “Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг” гэсэн асуултад 2.8 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 0.32 пунктээр доогуур үзүүлэлт юм. Харин Увс аймгийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр баримтлан ажилладаг” гэсэн асуултад 4.5 үнэлгээ өгсөн нь сэтгэл ханамж өндөр байгааг харуулж байна.

Доорх графикаас харахад “Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр баримтлан ажилладаг” гэсэн асуултад бүх аймгууд 4.0-өөс дээш үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулж байна. Энэ нь бусад бүсүүдтэй харьцуулахад онцлог үзүүлэлт байна.

График II.15. Баруун бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар



3.1.3 Хангайн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ


Хангайн бүсийн алба хаагчид байгууллагынхаа хууль ёсны хэрэгжилтийг 3.78 гэж үнэлсэн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Баянхонгор, Архангай аймгууд тус бүр гурав, Хөвсгөл аймаг хоёр үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Орхон, Булган, Өвөрхангай аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Хангайн бүсийн хувьд нийт 3 асуултын ерөнхий дундаж үнэлгээ нь 3.38-4.14 байна. Хангайн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр График II.16-д нэгтгэн харуулав.

Архангай аймгийн цагдаагийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр

баримтлан ажилладаг” гэсэн асуултад хамгийн өндөр үнэлгээ (4.67) авсан нь улсын дунджаас 0.61 пунктээр дээгүүр байна. Харин Орхон аймгийн алба хаагчид “Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг” гэсэн асуултад 2.94 үнэлгээ өгсөн нь Хангайн бүсийн аймгуудаас хамгийн бага үзүүлэлт боловч улсын дунджаас 0.18 пунктээр дээгүүр байна.

График II.16-аас харахад “Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг” гэсэн асуултад Баянхонгор аймаг 4.0 буюу **сэтгэл ханамжтай** гэж хариулсан нь энэ асуултын хувьд бусад аймагтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм.

График II.16. Хангайн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар




3.1.4 Зүүн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ

Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчид байгууллагынхаа хууль ёсны хэрэгжилтийн байдлыг 3.59 гэж үнэлсэн бөгөөд энэ нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Хэнтий аймаг гурав, Дорнод аймаг хоёр үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй байгаа бол Сүхбаатар аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Зүүн бүсийн хувьд нийт

3 асуултын ерөнхий дундаж үнэлгээг асуулт тус бүрээр авч үзвэл 3.23-4.00 үнэлгээтэй гарч байна. Зүүн бүсийн аймгуудын үнэлгээг График II.17-д нэгтгэн харуулав.

“Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг” гэсэн асуултад Зүүн бүсийн аймгуудын алба хаагчид 3.0 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамж дундуур** байгааг харуулна.

График II.17. Зүүн бүсийн алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар



3.1.5 Улаанбаатар хотын алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ

Улаанбаатар хотын алба хаагчдаас ажиллаж буй байгууллагынхаа хууль ёсны зарчмын хэрэгжилтийг 3.32 гэсэн үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд энэ нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Улаанбаатар

хотын цагдаагийн алба хаагчид байгууллагынхаа хууль ёсны зарчмын хэрэгжилтийг 3 асуултаар тодорхойлсон ба Чингэлтэй, Баянгол дүүрэг хоёр үзүүлэлтээр, Хан-Уул, Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүд тус бүр нэг үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан байна. Улаанбаатар хотын хувьд нийт 3


асуултын ерөнхий дундаж үнэлгээ 2.75-3.77 хооронд байсан бөгөөд асуулт тус бүрийн дундаж үнэлгээг дүүргүүдээр ангилан График II.18-д нэгтгэн харуулав.

Судалгааны дүнгээс харахад “Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр баримтлан ажилладаг” гэсэн асуултад бүх дүүрэг улсын дунджаас доогуур, эсрэгээрээ “Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг” гэсэн асуултад бүх дүүрэг улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан байна. Харин Улаанбаатар хот бусад бүсүүдтэй харьцуулахад ачаалал ихтэй, үйл ажиллагаа нь өргөн хүрээнд явагддаг, алба хаагчдын тоо олон, тэдэнд тавих хяналт сул байдагтай холбоотойгоор хуулийг нэг

мөр хэрэгжүүлэн ажиллах боломжгүй байх магадлалтай. Нөгөө талаар алба хаагчид эрх ашгаа хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээлгүүлэхээр шүүхэд хандах тохиолдол Улаанбаатар хотод түгээмэл байдагтай холбоотойгоор хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлдэг гэж алба хаагчид үзсэн байх боломжтой.

Баянзүрх дүүргийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр баримтлан ажилладаг” гэсэн асуултад хамгийн бага буюу 2.87 гэсэн үнэлгээ авсан нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлж байна. Баянгол дүүргийн алба хаагчид “Байгууллагын хэмжээнд алба хаагчтай холбоотой гаргаж байгаа шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомжид ихэвчлэн нийцсэн байдаг” гэсэн асуултад хамгийн өндөр үнэлгээ (3.93) үнэлгээ өгсөн байна.

График II.18. Улаанбаатар хотын алба хаагчдын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, дүүргээр



ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ТАЛААРХ АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Цагдаагийн алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийг тодорхойлох гол үзүүлэлт нь хүний нөөцийн бодлого гэж үзэж болно. Хүний нөөцийн бодлого гэдэг нь байгууллагаас ажилтан, нийт ажиллагсдаа удирдах, дадлагажуулах, урамшуулахад чиглэсэн хөтөлбөр, бодлогуудын нэгдсэн цогц үйл ажиллагаа юм. Ямар ч байгууллагын үйл ажиллагааны үндэс, чиг үүргээ хэрэгжүүлэх гол субъект нь алба хаагчид байдаг. Тиймээс байгууллага бүр алба хаагчдынхаа ажлын байран дахь сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд хүний нөөцийн бодлого хэрэгжүүлдэг. Тухайлбал, хөдөлмөрийн нарийвчилсан хуваарь, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, урамшуулах, хариуцлага хүлээлгэх, албан тушаал дэвшүүлэх, нийгмийн баталгаа, цалин хөлс зэрэг олон асуудал багтдаг. Цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор судалгаанд оролцогчдод дараах 7 асуулт тавьж үр дүнг улс, бүс, Улаанбаатар хотын хэмжээнд нэгтгэн дүгнэв. Үүнд,

(i) Цагдаагийн байгууллагын өнөөгийн бодлого, түүний хэрэгжилт нь алба хаагч бүрийг албан тушаал дэвших бололцоог жигд хангасан байдаг, (ii) Цагдаагийн алба хаагчдыг томилогдсон ажилд нь тогтвор суурьшилтай ажиллуулах бодлоготой, (iii) Албан тушаал дэвшүүлэх, цол олгох ажил хууль, журамд заасны дагуу явагддаг, (iv) Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт нь бодитой бөгөөд шударга байдаг, (v) Алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой, шударга байдаг, (vi) Алба хаагчид хариуцлага тооцох тогтолцоо оновчтой, шударга байдаг, (vii) Алба хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар хангалттай дэмжлэг үзүүлдэг гэсэн асуултууд багтсан.

4.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ТАЛААРХ АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Дээрх 7 асуултын дундаж үзүүлэлтээр

хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийг тодорхойлоход 3.33 гэсэн үзүүлэлттэй байгаа нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Улаанбаатар хот, Төвийн бүсийн хувьд улсын дунджаас доогуур, Баруун, Хангайн болон Зүүн бүсүүд улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна. Үзүүлэлтийг Хүснэгт II.5-д нэгтгэн харуулав.

Уг хүснэгтээс харахад “Цагдаагийн


байгууллагын өнөөгийн бодлого, түүний хэрэгжилт нь алба хаагч бүрийг албан тушаал дэвших бололцоог жигд хангасан байдаг”, “Алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой, шударга байдаг” гэсэн асуултуудад алба хаагчид хамгийн бага үнэлгээ өгсөн нь цаашид анхаарах шаардлагатайг харуулж байна. Үр дүнг График II.19-д дэлгэрүүлэн харуулав.

Хүснэгт II.5. Улсын хэмжээнд хүний нөөцийн бодлогын үнэлгээ

Асуултууд	Улсын дундаж	Төвийн бүс	Баруун бүс	Хангайн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Цагдаагийн байгууллагын өнөөгийн бодлого, түүний хэрэгжилт нь алба хаагч бүрийг албан тушаал дэвших бололцоог жигд хангасан байдаг	3.17	3.05	3.35	3.53	3.25	2.67
Цагдаагийн алба хаагчдыг томилогдсон ажилд нь тогтвор суурьшилтай ажиллуулах бодлоготой	3.40	3.31	3.42	3.68	3.59	3.01
Албан тушаал дэвшүүлэх, цол олгох ажил хууль, журамд заасны дагуу явагддаг	3.57	3.5	3.94	3.78	3.53	3.1
Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт нь бодитой бөгөөд шударга байдаг	3.34	3.32	3.46	3.75	3.25	2.91
Алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой, шударга байдаг	3.19	3.14	3.26	3.52	3.22	2.8
Алба хаагчид хариуцлага тооцох тогтолцоо оновчтой, шударга байдаг	3.32	3.26	3.45	3.53	3.31	3.07
Алба хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар хангалттай дэмжлэг үзүүлдэг	3.33	3.37	3.64	3.56	3.27	2.81
Дундаж	3.33	3.28	3.5	3.62	3.35	2.91

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График II.19. Улсын хэмжээнд хүний нөөцийн бодлогын үнэлгээ, бүсээр



Улаанбаатар хотын хувьд алба хаагчид бүх үзүүлэлтэд улсын дунджаас доогуур үнэлгээ өгсөн нь анхаарал татаж байна. Ялангуяа “Цагдаагийн байгууллагын өнөөгийн бодлого, түүний хэрэгжилт нь алба хаагч бүрийг албан тушаал дэвших бололцоог жигд хангасан байдаг” “Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт нь бодитой бөгөөд шударга байдаг”, “Алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой, шударга байдаг”, “Алба хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар хангалттай дэмжлэг үзүүлдэг” гэсэн асуултуудад алба хаагчид **сэтгэл ханамжгүй** байгаагаа илэрхийлжээ. Харин “Албан тушаал дэвшүүлэх, цол олгох ажил хууль, журамд заасны дагуу явагддаг” гэсэн асуултад Баруун бүсийн алба хаагчид хамгийн өндөр үнэлгээ (3.94) өгсөн нь улсын дунджаас 0.37 пунктээр дээгүүр үзүүлэлт юм.


4.1.1 Төвийн бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Төвийн бүсийн алба хаагчид цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогод

сэтгэл ханамж дунд зэрэг (3.31) байгаа нь харагдлаа. Нийт 7 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.11-3.59 хооронд байна. Төвийн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр График II.20-д нэгтгэн харуулав.

Графикаас харахад хэд хэдэн аймаг улсын дунджаас доогуур үнэлэгдсэнээс Төв аймаг долоо, Говьсүмбэр аймаг зургаа, Сэлэнгэ аймаг таван үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас доогуур үнэлэгдсэн нь анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна. Түүнчлэн “Алба хаагчид хариуцлага тооцох тогтолцоо оновчтой, шударга байдаг” гэсэн асуултад Дархан-Уул аймгийн алба хаагчид хамгийн өндөр үнэлгээ (3.81) өгчээ. Харин төв аймгийн хувьд “Цагдаагийн байгууллагын өнөөгийн бодлого, түүний хэрэгжилт нь алба хаагч бүрийг албан тушаал дэвших бололцоог жигд хангасан байдаг”, “Алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой, шударга байдаг” гэсэн асуултад **сэтгэл ханамжгүй** (2.73) байгаагаа илэрхийлжээ.

График II.20. Төвийн бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын үнэлгээ, аймгаар




4.1.2 Баруун бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар

Баруун бүсийн аймгуудын хэмжээнд хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамж **дунд зэрэг** буюу 3.52 байгаа нь улсын дунджаас 0.17 пунктээр дээгүүр үзүүлэлт юм. Нийт 7 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.28-3.95 байна. Судалгаанаас үзэхэд **сэтгэл ханамж дунд зэрэг** гэсэн ерөнхий дүгнэлт гарсан нь бусад бүсүүдтэй нийтлэг боловч хариултын тоон үзүүлэлт харьцангуй өндөр үзүүлэлттэй байв. Тухайлбал, Завхан аймгийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт нь бодитой бөгөөд шударга

байдаг” гэсэн асуултад 3.07 өгсөн нь хамгийн бага үзүүлэлтэд тооцогдож байна. Харин Говь-Алтай, Увс, Завхан аймгуудын алба хаагчид “Албан тушаал дэвшүүлэх, цол олгох ажиллагаа хууль, журамд заасны дагуу явагддаг” гэсэн асуултад 4.0, Увс аймгийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт нь бодитой бөгөөд шударга байдаг”, “Алба хаагчид хариуцлага тооцох тогтолцоо оновчтой, шударга байдаг” гэсэн асуултад тус бүр 4.0-өөс дээш үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулж байна. Баруун бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр График II.21-д нэгтгэн харуулав.

График II.21. Баруун бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын үнэлгээ




4.1.3 Хангайн бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Хангайн бүсийн хэмжээнд хүний нөөцийн бодлогын талаарх алба хаагчдын сэтгэл ханамж **дунд зэрэг** (3.62) байна. Нийт 7 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 2.94-4.5 хооронд байгаа бөгөөд Булган аймаг зургаа, Орхон аймаг тав, Өвөрхангай аймаг гурван үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь анхаарал татаж байна. Харин Архангай, Хөвсгөл, Баянхонгор аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй гарчээ.

Хангайн бүсийн аймгуудын асуулт тус бүр дээр өгсөн үнэлгээг График II.22-т дэлгэрүүлэн харуулав. “Алба хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар хангалттай дэмжлэг үзүүлдэг” гэсэн асуултад Баянхонгор аймгийн алба хаагчид хамгийн өндөр үнэлгээ (4.5) өгсөн нь **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулж байна. Харин Орхон аймгийн хувьд “Алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой, шударга байдаг” гэсэн асуултад хамгийн бага үнэлгээ (2.94) өгсөн нь алба хаагчид энэ үзүүлэлтэд **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлж байна.

График II.22. Хангайн бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын үнэлгээ




4.1.4 Зүүн бүсийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Зүүн бүсийн хэмжээнд хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамж **дунд зэрэг** буюу 3.35 үзүүлэлттэй гарчээ. Нийт 7 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.27-3.53 хооронд байгаа бөгөөд Дорнод аймаг зургаа, Хэнтий аймаг хоёр үзүүлэлтээр тус тус улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй байсан бол Сүхбаатар аймаг 6 үзүүлэлтээр улсын дунджаас доогуур байгаа нь анхаарал татаж байна. Зүүн бүсийн аймгуудын

асуулт тус бүр дээр өгсөн үнэлгээг дэлгэрүүлэн График II.23-д үзүүлэв.

Графикаас харахад “Цагдаагийн алба хаагчдыг томилогдсон ажилд нь тогтвор суурьшилтай ажиллуулах бодлоготой” гэсэн асуултад Дорнод аймгийн алба хаагчид хамгийн өндөр үнэлгээ өгсөн нь (4.13) **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулж байна. Харин Хэнтий аймгийн алба хаагчид “Алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой, шударга байдаг” гэсэн асуултад 2.84 үнэлгээ өгч **сэтгэл ханамжгүй** байгаагаа илэрхийлжээ.

График II.23. Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын үнэлгээ, аймгаар




4.1.5 Улаанбаатар хотын алба хаагчийн хүний нөөцийн бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчид хүний нөөцийн бодлогодоо *сэтгэл ханамжгүй* буюу 2.91 гэсэн үнэлгээ өгчээ. Хотын хувьд нийт 7 асуултын ерөнхий дундаж үнэлгээ нь 2.67-3.07 байгаа бөгөөд Баянгол дүүргээс бусад нь бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлэгдсэн нь анхаарал татаж байна. Дүүрэг тус бүр асуултад хэрхэн хариулсныг График П.24-г дэлгэрүүлэн харуулав. Графикаас харахад “Цагдаагийн байгууллагын

өнөөгийн бодлого, түүний хэрэгжилт нь алба хаагч бүрийг албан тушаал дэвших бололцоог жигд хангасан байдаг” гэсэн асуултад Чингэлтэй дүүргийн алба хаагчид 2.33 үнэлгээ өгсөн нь хамгийн бага буюу *сэтгэл ханамжгүй* байгааг харуулж байна. Харин Баянгол дүүргийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагчдыг томилогдсон ажилд нь тогтвор суурьшилтай ажиллуулах бодлоготой”, “Алба хаагчид хариуцлага тооцох тогтолцоо оновчтой, шударга байдаг” гэсэн асуултаудад 3.4-өөс дээш үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт болжээ.

График II.24. Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын хүний нөөцийн бодлогын үнэлгээ, дүүргээр



ТАВ. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙ

Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан Хууль хэрэгжүүлэх албан тушаалтны зан үйлийн тухай хууль болон Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмээр тодорхойлогддог. Энэ нь зөвхөн иргэдтэй харилцахдаа баримтлах зарчим төдийгүй алба хаагчид ч хоорондоо харилцахад мөрдөгддөг. Цагдаагийн байгууллагын дотоод соёл, алба хаагч үйл ажиллагаандаа ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажилладаг эсэхийг тодорхойлох оновчтой аргачлалын нэг нь тэднийг өөрсдөөр нь үнэлүүлэх явдал байдаг. Тиймээс судалгааны ажлын хүрээнд цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн төлөв байдлыг дараах 3 асуултаар тодорхойлж, улс, бүс, Улаанбаатар хотын хэмжээнд харьцуулан дүгнэлт хийв. Үүнд, (i) Цагдаагийн байгууллагын орчинд

авлига, хүнд суртлын асуудал байдаггүй, (ii) Алба хаагч бүр цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг удирдлага болгон бие биедээ хүндэтгэлтэй хандаж ажилладаг, (iii) Цагдаагийн байгууллагын төвлөрсөн нэгдмэл тогтолцоо, хагас цэргийн зохион байгуулалт нь ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ гүйцэтгэхэд хүндрэл учруулдаггүй зэрэг асуулт болно.

5.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчид байгууллагынхаа соёл, алба хаагчийн ёс зүйн байдлыг **дунд** гэж (3.65) үнэлжээ. Энэ асуулгад алба хаагчдаас өгсөн үнэлгээг улс, бүс болон Улаанбаатар хотын хэмжээнд асуулт бүрээр харьцуулан Хүснэгт II.6-д үзүүлэв.

Хүснэгт II.6. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын соёл,
алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, бүсээр


Асуултууд	Дундаж үнэлгээ					
	Улс	Төвийн бүс	Баруун бүс	Хангайн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Цагдаагийн байгууллагын орчинд авлига, хүнд суртлын асуудал байдаггүй	3.6	3.58	3.83	3.68	3.61	3.32
Алба хаагч бүр цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг удирдлага болгон бие биедээ хүндэтгэлтэй хандаж ажилладаг	3.63	3.56	3.67	3.85	3.65	3.41
Цагдаагийн байгууллагын төвлөрсөн нэгдмэл тогтолцоо, хагас цэргийн зохион байгуулалт нь ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ гүйцэтгэхэд хүндрэл учруулдаггүй	3.73	3.62	3.87	3.93	3.8	3.41
Дундаж	3.65	3.59	3.79	3.82	3.69	3.38

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Судалгааны дүнгээс харахад Улаанбаатар хот бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур байгаа бол Зүүн болон Төвийн бүс бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй гарчээ. Хангайн бүсийн алба хаагчид “Цагдаагийн байгууллагын төвлөрсөн нэгдмэл тогтолцоо, хагас цэргийн зохион байгуулалт нь ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ

гүйцэтгэхэд хүндрэл учруулдаггүй” гэсэн асуултад 3.96 гэсэн үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт байгаа бол Улаанбаатар хотын алба хаагчид “Цагдаагийн байгууллагын орчинд авлига, хүнд суртлын асуудал байдаггүй” гэсэн асуултад хамгийн доогуур үнэлгээ (3.32) өгчээ. Бүсүүдийн алба хаагчдын асуулт тус бүрт өгсөн үнэлгээг График II.25-д дэлгэрүүлэн харуулав.

График II.25. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, бүсээр




“Цагдаагийн байгууллагын төвлөрсөн нэгдмэл тогтолцоо, хагас цэргийн зохион байгуулалт нь ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ гүйцэтгэхэд хүндрэл учруулдаггүй” гэсэн асуултад Улаанбаатар хотын алба хаагчид хамгийн бага үнэлгээ (2.75) өгсөн нь улсын дунджаас 0.98 пунктээр доогуур үзүүлэлт юм. Харин энэ асуултад Хангайн бүсийн алба хаагчид хамгийн өндөр үнэлгээ (3.93) өгчээ. Эндээс харахад Улаанбаатар хот, орон нутгийн алба хаагчид харилцан адилгүй саналтай байна.

5.1.1 Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ

Төвийн бүсийн хэмжээнд цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний төлөв байдалд алба хаагчдын сэтгэл ханамж **дунд зэрэг** (3.59) байна. Нийт 3 асуултын ерөнхий дундаж үнэлгээ нь 3.56-3.62 хооронд байгаа бөгөөд Өмнөговь, Дундговь аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй байгаа бол Төв, Сэлэнгэ аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээтэй байгаа нь анхаарал татаж байна. Асуулт тус бүрээр аймгуудын алба хаагчдын өгсөн үнэлгээг нэгтгэн График II.26-д харуулав.

График II.26. Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, аймгаар




“Цагдаагийн байгууллагын төвлөрсөн нэгдмэл тогтолцоо, хагас цэргийн зохион байгуулалт нь ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ гүйцэтгэхэд хүндрэл учруулдаггүй” гэсэн асуултад Өмнөговь аймгийн алба хаагчид 4.0 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулж байна. Харин энэ асуултад төв аймгийн алба хаагчид 3.0 үзүүлэлт өгсөн нь бусад аймгуудтай харьцуулахад хамгийн доогуур үнэлгээ юм. Говьсүмбэр аймгийн алба хаагчид “Цагдаагийн байгууллагын орчинд авлига, хүнд суртлын асуудал байдаггүй” гэсэн асуултад 4.0 гэсэн үнэлгээ өгсөн нь байгууллагын хэмжээнд авлигын хурц асуудал байхгүйг харуулж байна.

5.1.2 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ

Баруун бүсийн хэмжээнд цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн байдал **дунд зэрэг** (3.79) үнэлгээтэй гарчээ. Нийт 3 асуултын ерөнхий дундаж үнэлгээ нь 3.67-3.87 хооронд байгаа бөгөөд Увс, Говь-Алтай аймгууд гурав, Баян-Өлгий, Завхан аймгууд хоёр, Ховд аймаг нэг үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн бол Ховд аймаг хоёр, Завхан Баян-Өлгий аймаг тус бүр нэг үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь анхаарал татаж байна. Баруун бүсийн аймгуудын алба хаагчид асуулт бүрт өгсөн үнэлгээг дундажлан График II.27-д нэгтгэн харуулав.

График II.27. Баруун бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, аймгаар



“Алба хаагч бүр цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг удирдлага болгон бие биедээ хүндэтгэлтэй хандаж ажилладаг” гэсэн асуултад Увс аймгийн алба хаагчид 4.3 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулна. Харин Ховд аймгийн алба хаагчид энэ асуултад хамгийн бага буюу 3.47 гэсэн үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна.


5.1.3 Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ

Хангайн бүсийн хэмжээнд алба хаагчид байгууллагынхаа соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг 3.83 гэж үнэлсэн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Нийт 3 асуултын ерөнхий дундаж үнэлгээ нь 3.69-3.95

хооронд байгаа бөгөөд Өвөрхангай, Булган аймгууд хоёр, Орхон аймаг нэг үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь цаашид энэ асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна. Хангайн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр нэгтгэн График II.28-д дэлгэрүүлэн харуулав.

Судалгааны дүнгээр “Цагдаагийн байгууллагын орчинд авлига, хүнд суртлын асуудал байдаггүй” гэсэн асуултад Булган аймгийн алба хаагчид 3.35 гэсэн үнэлгээ өгсөн нь хамгийн бага бөгөөд **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Харин Архангай аймаг 3 асуултад 4.3-аас дээш үнэлгээтэй гарсан нь **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулж байна. Мөн энэ асуултад Баянхонгор, Хөвсгөл аймгууд 4.0-өөс дээш үнэлгээтэй байгаа нь **сэтгэл ханамж өндөр** байгааг илэрхийлнэ.

График II.28. Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, аймгаар




5.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ

Зүүн бүсийн хэмжээнд байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг 3.69 гэж үнэлсэн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Нийт 3 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.61-3.80 хооронд байна. Судалгааны дүнгээр Сүхбаатар аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлэгдсэн нь анхаарал татаж байна. Асуулт бүрийн хариултыг дэлгэрүүлэн График II.29-д үзүүлэв.

“Цагдаагийн байгууллагын орчинд авлига, хүнд суртлын асуудал байдаггүй”

гэсэн асуултад Сүхбаатар аймгийн алба хаагчид 3.31 гэж үнэлсэн нь бүс дотроо хамгийн доогуур үзүүлэлт байсан бөгөөд **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Харин “Цагдаагийн байгууллагын төвлөрсөн нэгдмэл тогтолцоо, хагас цэргийн зохион байгуулалт нь ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ гүйцэтгэхэд хүндрэл учруулдаггүй” гэсэн асуултад Дорнод аймаг 3.94 үнэлгээтэй байгаа нь бүс дотроо хамгийн өндөр нь болжээ. Гэхдээ 4.0-өөс дээш үзүүлэлттэй гарч **сэтгэл ханамжтай** гэсэн үнэлгээ авсан аймаг байхгүй нь энэ асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

График II.29. Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, аймгаар




5.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ

Улаанбаатар хотын хэмжээнд цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ 3.38 гэж үнэлсэн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Нийт 3 асуултын ерөнхий дундаж нь 3.32-3.41 хооронд байгаа бөгөөд Чингэлтэй дүүрэг хоёр, Баянгол дүүрэг нэг үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Харин Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээтэй гарсан нь анхаарал татаж байна. Улаанбаатар хотын үнэлгээг асуулт тус бүрээр График II.30-д дэлгэрүүлэн харуулав.

“Алба хаагч бүр цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг удирдлага болгон бие биедээ хүндэтгэлтэй хандаж ажилладаг” гэсэн асуултад Баянгол дүүргийн алба хаагчид 3.93 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт хэдий ч **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулна. Харин Баянзүрх дүүргийн алба хаагчид “Цагдаагийн байгууллагын орчинд авлига, хүнд суртлын асуудал байдаггүй” гэсэн асуултад 2.87 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, Баянзүрх дүүргийн алба хаагчид ажиллаж байгаа байгууллагынхаа хэмжээнд авлига, хүнд суртлын асуудал байдаг гэж үзжээ.

График II.30. Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээний үнэлгээ, дүүргээр



ЗУРГАА. УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ

Манлайлагч нь байгууллагаас албан ёсоор эрх мэдэл өгч, менежер, захирал, эсвэл эрхлэгч зэрэг тодорхой албан тушаал эрхэлсэн удирдах ажилтанд хамаарна. Алба хаагчид араас нь дагахад бэлэн байгаа нөхцөлд удирдагч манлайлагч болдог. Алба хаагчдын хүсэл сонирхол, хэрэгцээг нь хангаж, эрх ашгийг нь хамгаалж чадах нь алба хаагчдын сэтгэл ханамжид шууд нөлөөлдөг. Цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаа, түүний үр дүн, алба хаагчдын эрх ашгийг хамгаалах, алба хаагчийг урамшуулах болон хариуцлага хүлээлгэхэд удирдах дарга нарын үүрэг чухал. Тиймээс удирдах алба хаагч ажилтандаа хүлээн зөвшөөрөгдсөн байх нь удирдлагын манлайллыг илэрхийлнэ.

Энэ судалгаанд цагдаагийн алба хаагчийн удирдлагын манлайллыг тодорхойлох зорилгоор дараах 4 асуултыг тавьж дүнг улс, бүс, Улаанбаатар хотын хэмжээнд нэгтгэн гаргалаа. Үүнд, (i) Манай дээд шатны дарга нар мэргэжлийн ур чадвар, ажлын

туршлага, ёс зүйн төлөвшилтийн хувьд алба хаагчдадаа хүлээн зөвшөөрөгдөж чадсан, (ii) Цагдаагийн удирдах ажилтны шийдвэр нь алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцдэг, (iii) Манай удирдах албан тушаалтан бидний санал хүсэлтийг сонсож, асуудлыг хамтран шийддэг, (iv) Зөрчил дутагдал гаргасан алба хаагчдын шалтгаан нөхцөлийг зөв тогтоож, шийдвэр гаргадаг зэрэг асуулт багтсан.

6.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫН ҮНЭЛГЭЭ


Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчийн удирдлагын манлайллын талаарх сэтгэл ханамж **дунд зэрэг** (3.47) гэж үнэлэгджээ. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ нь 3.43-3.58 хооронд байгаа бөгөөд асуулт тус бүрээр бүсүүдийн алба хаагчдын өгсөн үнэлгээг Хүснэгт II.7-д нэгтгэн харуулав.

Хүснэгт II.7. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ, бүсээр

Асуултууд	Дундаж үнэлгээ					
	Улс	Төвийн бүс	Баруун бүс	Хангайн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Манай дээд шатны дарга нар мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага, ёс зүйн төлөвшилтийн хувьд алба хаагчдадаа хүлээн зөвшөөрөгдөж чадсан	3.58	3.44	3.77	3.74	3.73	3.2
Цагдаагийн удирдах ажилтны шийдвэр нь алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцдэг	3.44	3.47	3.68	3.67	3.25	3.15
Манай удирдах албан тушаалтан бидний санал хүсэлтийг сонсож, асуудлыг хамтран шийддэг	3.43	3.47	3.65	3.59	3.22	3.2
Зөрчил, дутагдал гаргасан алба хаагчдын шалтгаан нөхцөлийг зөв тогтоож, шийдвэр гаргадаг	3.43	3.42	3.62	3.67	3.31	3.14
Дундаж	3.47	3.45	3.68	3.67	3.38	3.17

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График II.31. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ, бүсээр



Улаанбаатар хотын алба хаагчдын удирдах албан тушаалтнаа үнэлсэн үнэлгээ бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур гарчээ. Төвийн бүс хоёр,

Баруун бүс дөрөв, Хангайн бүс дөрөв, Зүүн бүс нэг үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй байгаа бол бүсүүдээс Зүүн бүс харьцангуй

доогуур үзүүлэлттэй байгааг анхаарах шаардлагатай. Алба хаагчдын өгсөн үнэлгээг дундажлан асуулт бүрээр дэлгэрүүлэн График II.31-д үзүүлэв.

“Манай дээд шатны дарга нар мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага, ёс зүйн төлөвшилтийн хувьд алба хаагчдадаа хүлээн зөвшөөрөгдөж чадсан” гэсэн асуултад Баруун бүсийн алба хаагчид 3.77 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.19 пунктээр дээгүүр байна. Харин Улаанбаатар хотын алба хаагчид “Зөрчил, дутагдал гаргасан алба хаагчдын шалтгаан нөхцөлийг зөв тогтоож, шийдвэр гаргадаг” гэсэн асуултад 3.14 үнэлгээ өгсөн нь хамгийн бага үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.29 пунктээр доогуур байна.


6.1.1 Төвийн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ

Төвийн бүсийн хэмжээнд цагдаагийн байгууллагын удирдлагын манлайллын

талаарх алба хаагчдын **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.45) байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.42-3.47 хооронд байгаа бөгөөд Төв, Өмнөговь аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол эсрэгээрээ Дорноговь, Сэлэнгэ аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь анхаарал татаж байна. Бусад бүсүүдтэй харьцуулахад тухайн бүсэд хамаарах аймгуудын алба хаагчид удирдах албан тушаалтныхаа манлайлалд сэтгэл ханамж доогуур гэсэн үг юм. Төвийн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр дэлгэрүүлэн График II.32-т үзүүлэв.

Графикаас харахад “Манай дээд шатны дарга нар мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага, ёс зүйн төлөвшилтийн хувьд алба хаагчдадаа хүлээн зөвшөөрөгдөж чадсан” гэсэн асуултад Төв аймгийн алба хаагчид 3.87 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт хэдий ч **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Сэлэнгэ аймгийн алба хаагчид “Манай удирдах

График 32. Төвийн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ, аймгаар



албан тушаалтан бидний санал хүсэлтийг сонсож, асуудлыг хамтран шийддэг” гэсэн асуултад 3.0 үнэлгээ өгсөн нь хамгийн бага үзүүлэлт бөгөөд мөн л **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна.


6.1.2 Баруун бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ

Баруун бүсийн хэмжээнд алба хаагчдын удирдлагын манлайллын талаарх сэтгэл ханамж **дунд зэрэг** (3.68) байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.62-3.77 хооронд байгаа бөгөөд Увс аймаг дөрөв, Говь-Алтай аймаг гурав, Баян-Өлгий аймаг хоср, Завхан аймаг нэг үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Ховд аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь анхаарал татаж байна. Баруун бүсийн аймгуудын үнэлгээг

асуулт бүрээр бүрээр График II.33-т үзүүлэв.

“Зөрчил дутагдал гаргасан алба хаагчдын шалтгаан нөхцөлийг зөв тогтоож, шийдвэр гаргадаг” гэсэн асуултад Завхан аймгийн алба хаагчид 3.0 үнэлгээ өгсөн нь хамгийн бага үзүүлэлт бөгөөд **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг илтгэнэ. Харин Говь-Алтай, Увс, Завхан аймгийн алба хаагчид “Манай удирдах албан тушаалтан бидний санал хүсэлтийг сонсож, асуудлыг хамтран шийддэг” гэсэн асуултад 4.0-өөс дээш үнэлгээ өгсөн нь удирдах албан тушаалтандаа хандах **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулж байна. Мөн Увс аймгийн алба хаагчид удирдах албан тушаалтан “Зөрчил дутагдал гаргасан алба хаагчдын шалтгаан нөхцөлийг зөв тогтоож, шийдвэр гаргадаг” гэдэг асуултад 4.2 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулжээ.

График II.33. Баруун бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ




6.1.3 Хангайн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ

Хангайн бүсийн хэмжээнд алба хаагчид цагдаагийн байгууллагын удирдлагын манлайлалд **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.67) гэжээ. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.59-3.74 хооронд байгаа бөгөөд Булган аймаг гурав, Орхон аймаг гурав, Өвөрхангай аймаг хоёр үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь анхаарал татаж байна. Харин Архангай, Баянхонгор, Хөвсгөл аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Хангайн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт бүрээр дэлгэрүүлэн

График II.34-т үзүүлэв.

“Манай дээд шатны дарга нар мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага, ёс зүйн төлөвшилтийн хувьд алба хаагчдадаа хүлээн зөвшөөрөгдөж чадсан” гэсэн асуултад Завхан аймгийн алба хаагчид 4.6 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд **сэтгэл ханамж өндөр** байгааг харуулж байна. Харин Булган аймгийн алба хаагчид “Манай удирдах албан тушаалтан бидний санал хүсэлтийг сонсож, асуудлыг хамтран шийддэг” гэсэн асуултад хамгийн бага (3.05) үнэлгээ өгчээ.

График II.34. Хангайн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ



6.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ

Зүүн бүсийн хэмжээнд цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлай-


лалд алба хаагчид **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.38) байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.22-3.73 хооронд байгаа бөгөөд Сүхбаатар аймаг дөрөв, Хэнтий аймаг гурав үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас доогуур үнэлгээ

авсан бол Дорнод аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Эндээс харахад зүүн бүсээс Дорнод аймгийн алба хаагчид удирдах албан тушаалтандаа илүү **сэтгэл ханамжтай** байна. Зүүн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт бүрээр дэлгэрүүлэн График II.35-д харуулав.

“Манай удирдах албан тушаалтан бидний санал хүсэлтийг сонсож,

асуудлыг хамтран шийддэг” гэсэн асуултад Сүхбаатар аймгийн алба хаагчид **сэтгэл ханамжгүй** (2.5) байгаагаа илэрхийлжээ. Дорнод аймгийн алба хаагчид “Манай дээд шатны дарга нар мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага, ёс зүйн төлөвшилтийн хувьд алба хаагчдадаа хүлээн зөвшөөрөгдөж чадсан” гэсэн асуултад 3.91 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт байлаа.

График II.35. Зүүн бүсийн цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ, аймгаар




6.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ

Улаанбаатар хотын хэмжээнд цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайлалд алба хаагчдын **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.17) байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.1-3.15 хооронд байгаа бөгөөд Хан-Уул дүүрэг нэг үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн бол бусад дүүрэг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур

үнэлэгджээ. Ерөнхий байдлаар дүгнэж үзвэл Улаанбаатар хотод ажиллаж байгаа алба хаагчид бусад бүстэй харьцуулахад удирдах албан тушаалтандаа **сэтгэл ханамж доогуур** байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын цагдаагийн удирдах албан тушаалтан алба хаагчдадаа хүлээн зөвшөөрөгдөхгүй байгаа ба үүний шалтгааныг нарийвчлан судлах шаардлагатай. Алба хаагчдын өгсөн хариултыг асуулт тус бүрээр нэгтгэн График II.36-д дэлгэрүүлэн харуулав.

График II.36. Улаанбаатар хотын цагдаагийн байгууллага дахь удирдлагын манлайллын үнэлгээ, дүүргээр



“Цагдаагийн удирдах ажилтны шийдвэр нь алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцдэг” гэсэн асуултад Баянгол, Хан-Уул дүүргүүдийн алба хаагчид 3.27 үнэлгээ өгсөн нь дүүргүүдээс хамгийн өндөр үзүүлэлт боловч улсын дунджаас 0.17 пунктээр доогуур бөгөөд **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг илэрхийлнэ. Харин Сонгинохайрхан дүүргийн алба хаагчид “Манай дээд шатны дарганаар мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага, ёс зүйн төлөвшилтийн хувьд алба хаагчдадаа хүлээн зөвшөөрөгдөж чадсан” гэсэн асуултад 2.86, Баянзүрх

дүүргийн алба хаагчид “Цагдаагийн удирдах ажилтны шийдвэр нь алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцдэг” гэсэн асуултад 2.87, “Зөрчил дутагдал гаргасан алба хаагчдын шалтгаан нөхцөлийг зөв тогтоож, шийдвэр гаргадаг” гэсэн асуултад 2.93 гэсэн оноо тус тус өгсөн нь хамгийн бага үзүүлэлт байсан бөгөөд **сэтгэл ханамжгүй** гэсэн утгыг илэрхийлж байна. Цаашид Улаанбаатар хот, ялангуяа **сэтгэл ханамжгүй** үнэлгээ авсан дүүргүүдэд анхаарал хандуулж ажиллах шаардлагатай.

ДОЛОО. АЛБА ХААГЧИЙН БАТАЛГАА

Цагдаагийн алба хаагчийн албандаа хандах сэтгэл ханамжийн гол шалгуур үзүүлэлт нь алба хаагчдын баталгаа болдог. Цагдаагийн албаны тухай хуулийн 83 дугаар зүйлд “Алба хаагчийн баталгаа”, 84 дүгээр зүйлд “Улс төрийн баталгаа”, 85 дугаар зүйлд “Хууль зүйн баталгаа”, 86 дугаар зүйлд “Нийгмийн баталгаа”, 87 дугаар зүйлд “Эдийн засгийн баталгаа”-г тус тус хуульчилсан. Тиймээс хуульд заасан алба хаагчийн баталгаа хэрхэн хангагдаж байгааг тодруулах зорилгоор доорх 4 асуултыг тавьж дүнг улс, бүс, Улаанбаатар хотын хэмжээнд нэгтгэн гаргав. Үүнд, (i) Цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь ахуй амьдралд хүрэлцэхүйц байдаг, (ii) Шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль биднийг ажил үүргээ гүйцэтгэх нийгэм, улс төр, эрх зүйн баталгааг бүрэн хангаж өгсөн, (iii) Цагдаагийн алба

хаагч бүр хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бие даан шийдвэр гаргаж, хараат бусаар ажиллаж чаддаг, (iv) Цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай эдийн засгийн болон техник хэрэгслийн хангалт хэвийн байдаг гэсэн асуултууд багтсан.

7.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН АЛБА ХААХ БАТАЛГААНЫ ТАЛААРХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Улсын хэмжээнд алба хаагчид ажиллах нөхцөл, баталгаагаа 2.83 гэж үнэлсэн нь *сэтгэл ханамжгүй* байгааг илэрхийлж байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 2.39-3.17 хооронд байгаа бөгөөд 4 асуулт тус бүрээр алба хаагчдын өгсөн үнэлгээг Хүснэгт II.8-д нэгтгэн харуулав.

Хүснэгт II.8. Улсын хэмжээнд алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, бүсээр


Асуултууд	Дундаж үнэлгээ					
	Улс	Төвийн бүс	Баруун бүс	Хангайн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь ахуй амьдралд хүрэлцэхүйц байдаг	2.39	2.18	2.67	2.44	2.31	2.33
Шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль биднийг ажил үүргээ гүйцэтгэх нийгэм, улс төр, эрх зүйн баталгааг бүрэн хангаж өгсөн	3.16	3.21	3.33	3.23	3.12	2.93
Цагдаагийн алба хаагч бүр хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бие даан шийдвэр гаргаж, хараат бусаар ажиллаж чаддаг	3.17	3.21	3.51	3.09	3.14	2.89
Цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай эдийн засгийн болон техник хэрэгслийн хангалт хэвийн байдаг	2.62	2.58	2.83	2.57	2.55	2.56
Дундаж	2.83	2.8	3.09	2.83	2.78	2.68

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Улаанбаатар хот болон Зүүн бүс тус бүр дөрөв, Хангайн бүс хоёр үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлэгдсэн нь анхаарал татаж байна. Харин Баруун бүс бүх үзүүлэлтээр, Төвийн бүс хоёр үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн байна. Бүх үзүүлэлтийн ерөнхий дунжийг авч үзвэл Баруун бүсээс бусад нь цагдаагийн алба хаагчийн баталгаанд **сэтгэл ханамжгүй** байгаагаа илэрхийлжээ. Бүс тус бүрээр хариултыг дэлгэрүүлэн График II.37-д харуулав.

“Цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь ахуй амьдралд хүрэлцэхүйц байдаг” гэсэн асуултад Төвийн бүсийн алба хаагчид хамгийн бага буюу 2.18 үнэлгээ өгсөн нь улсын дунджаас 0.21 пунктээр доогуур байгаа юм. Харин баруун бүсийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагч бүр хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бие даан шийдвэр гаргаж, хараат бусаар ажиллаж чаддаг” гэсэн асуултад 3.51 оноо өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт байлаа.

График II.37. Улсын хэмжээнд алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, бүсээр




7.1.1 Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Төвийн бүсийн хэмжээнд алба хаагчид алба хаах баталгаагаа 2.8 гэж үнэлсэн нь **сэтгэл ханамжгүй** байгааг харуулж байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 2.18-3.58 хооронд байгаа бөгөөд Төв аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь анхаарал татаж байна. Харин Сэлэнгэ, Өмнөговь аймаг тус бүр 3 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Төвийн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр дэлгэрүүлэн График II.38-д үзүүлэв.

“Шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль биднийг ажил үүргээ гүйцэтгэх нийгэм, улс төр, эрх зүйн баталгааг бүрэн хангаж өгсөн” гэсэн асуултад Өмнөговь аймгийн алба хаагчид 3.56 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Харин эсрэгээр “Цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь ахуй амьдралд хүрэлцэхүйц байдаг” гэсэн асуултад Төв аймгийн алба хаагчид 1.87, Өмнөговь аймгийн алба хаагчид 1.94 гэж тус тус үнэлгээ өгсөн нь цалин хөлсний асуудалд дээрх аймгуудын алба хаагчид **огт сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлж байна.

График II.38. Төвийн бүсийн алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, аймгаар




7.1.2 Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Баруун бүсийн цагдаагийн алба хаагчид алба хаах баталгаагаа 3.09 гэж үнэлсэн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 2.67-3.83 хооронд байгаа бөгөөд Увс, Баян-Өлгий, Ховд аймгууд тус бүр дөрөв, Говь-Алтай аймаг гурав үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байгаа бол Завхан хоёр үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Судалгааны дүнгээс харахад Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамж улсын дундажтай харьцуулахад өндөр үзүүлэлттэй байна. Баруун бүсийн аймгуудын үнэлгээг асуулт тус бүрээр нэгтгэн График II.39-д харуулав.

“Цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь ахуй амьдралд хүрэлцэхүйц байдаг” гэсэн асуултад Завхан аймгийн алба хаагчид 1.86 үнэлгээ өгсөн нь хамгийн бага буюу **сэтгэл ханамжгүй** байгааг харуулж байна. Говь-Алтай аймгийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагч бүр хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бие даан шийдвэр гаргаж, хараат бусаар ажиллаж чаддаг” гэсэн асуултад 3.81 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг илэрхийлнэ. Алба хаагчдын цалин хөлс, алба хаагч үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай эдийн засгийн баталгааны талаар хэд хэдэн аймаг 2.9-өөс доош үнэлгээ авсан нь анхаарал татаж байна.

График II.39. Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, аймгаар




7.1.3 Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчид алба хаах баталгаагаа 2.83 гэж үнэлсэн нь **сэтгэл ханамжгүй** байгааг харуулж байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 2.44-3.23 хооронд байгаа бөгөөд Баянхонгор аймаг дөрөв, Хөвсгөл, Өвөрхангай аймгууд тус бүр хоёр үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Орхон аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Хангайн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт бүрээр дэлгэрүүлэн График II.40-д нэгтгэн харуулав.

“Цагдаагийн алба хаагч бүр хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бие

даан шийдвэр гаргаж, хараат бусаар ажиллаж чаддаг” гэсэн асуултад Баянхонгор аймгийн алба хаагчид 3.6 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Архангай аймгийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь ахуй амьдралд хүрэлцэхүйц байдаг” гэсэн асуултыг 1.93 үнэлгээ өгсөн нь бүс дотроо хамгийн доогуур үзүүлэлтэд хамаарч байна. Энэ нь алба хаагчид алба хаах баталгаандаа **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлнэ. Түүнчлэн дээрх судалгааны дүнгээр 2.9-өөс доош үнэлгээ авсан аймгуудын алба хаагчид тухайн асуудалд **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлэх тул цаашид анхаарах шаардлагатай.

График II.40. Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, аймгаар




7.1.4 Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчид алба хаах баталгаагаа 2.78 гэж үнэлсэн нь **сэтгэл ханамжгүй** байгааг харуулж байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 2.31-3.14 хооронд байгаа бөгөөд Дорнод аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй байгаа бол Хэнтий, Сүхбаатар аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь анхаарал татаж байна. Зүүн бүсийн аймгуудын үнэлгээг

асуулт бүрээр нэгтгэн График II.41-д дэлгэрүүлэн харуулав.

Сүхбаатар аймгийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь ахуй амьдралд хүрэлцэхүйц байдаг” гэсэн асуултад 2.13, “Цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай эдийн засгийн болон техник хэрэгслийн хангалт хэвийн байдаг” гэсэн асуултад 2.38 үнэлгээ өгсөн нь хамгийн бага үзүүлэлт байсан ба тухайн асуудалд **сэтгэл ханамжгүй** байгааг харуулж байна.

График II.41. Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар




7.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Улаанбаатар хотын 6 дүүргийн цагдаагийн алба хаагчид алба хаах баталгаагаа 2.68 гэж үнэлсэн нь **сэтгэл ханамжгүй** дүн байгааг илэрхийлж байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 2.33-2.93 хооронд байгаа бөгөөд Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байгаа бол Баянгол дүүрэг 3 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр байна. Улаанбаатар хотын үнэлгээг асуулт бүрээр нэгтгэн График II.42-т дэлгэрэнгүй харуулав.

“Шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль биднийг ажил үүргээ

гүйцэтгэх нийгэм, улс төр, эрх зүйн баталгааг бүрэн хангаж өгсөн” гэсэн асуултад Баянгол дүүргийн алба хаагчид 3.33 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Хан-Уул дүүргийн алба хаагчид “Цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь ахуй амьдралд хүрэлцэхүйц байдаг” гэсэн асуултад 1.73 үнэлгээ өгсөн нь Улаанбаатар хотын дүүргүүдээс хамгийн бага үзүүлэлт бөгөөд **огт сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлж байна. Түүнчлэн зарим асуултад 2.9-өөс доош үнэлгээ авсан дүүргүүд цөөнгүй байгаа нь анхаарал татаж байгаа бөгөөд энэ нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлнэ. Цаашид эдгээр дүүрэг дэх нөхцөл байдлыг нарийвчлан судлах шаардлагатай.

График II.42. Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын алба хаах баталгааны үнэлгээ, дүүргээр



НАЙМ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН АЛБАНДАА ХАНДАХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН НЭГДСЭН ДҮН

8.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН АЛБАНДАА ХАНДАХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Улсын хэмжээнд Баруун бүсийн 69, Хангайн бүсийн 87, Төвийн бүсийн 107, Зүүн бүсийн 51, Улаанбаатар хотоос 6 дүүргийн 88, нийт 402 алба хаагч судалгаанд оролцсон. Асуулгыг 8 бүлгийн 30 асуултаар авсан бөгөөд сэтгэл ханамжийг илэрхийлэх 7 бүлгийн 28 асуултаар сэтгэл ханамжийн нэгдсэн үнэлгээг гаргаж, дундаж үзүүлэлтээр эрэмбэлэв.

Хүснэгт II.9-өөс харахад улсын дүнгээр нийт 21 аймаг, 6 дүүргийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ 3.52 байгаа

нь *сэтгэл ханамж дунд зэрэг* байгааг илэрхийлнэ. Авсан үнэлгээгээр жагсаахад: нэгдүгээрт Архангай, хоёрдугаарт Баянхонгор, гуравдугаарт Увс аймгууд эрэмбэлэгдэж байна.


Дунджаас дээгүүр үнэлгээтэйд Архангай, Баянхонгор, Увс, Говь-Алтай, Хөвсгөл, Баян-Өлгий, Өмнөговь, Дорнод, Завхан, Дундговь, Дархан-Уул аймгууд байгаа бол дунджаас доогуур үнэлгээтэйд Өвөрхангай, Говьсүмбэр, Хэнтий, Булган, Баянгол, Дорноговь, Ховд, Сэлэнгэ, Орхон, Сүхбаатар, Төв аймгууд болон Чингэлтэй Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд орсон байна. Хот, аймаг, дүүргүүдийн ерөнхий үнэлгээг График II.43-т нэгтгэн харуулав.

**Хүснэгт II.9. Цагдаагийн алба хаагчдын албандаа хандах
сэтгэл ханамжийн нэгдсэн дүн (аймаг, дүүргээр)**

Аймаг/дүүрэг	Цагдаагийн байгууллагын алба хаагчдаас авсан санал асуулгын үнэлгээ							Ерөнхий дундаж	Байр
	Цагдаагийн алба хаагчийн сэтгэл ханамжийн ерөнхий байдал	цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг үнэлэх алба хаагчдын сэтгэл ханамж	Хууль ёсны зарчмын хэрэгжилтэд алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ	Хүний нөөцийн боллогын талаарх алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ	Цагдаагийн байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүй	Удирдлагын манлайлал	Алба хаагчийн баталгаа		
Архангай	4.84	3.55	4.27	4.13	4.44	4.47	2.7	4.06	I
Баянхонгор	4.4	3.95	4.27	4.2	3.93	4.03	3.3	4	II
Увс	4.43	3.9	3.95	3.89	4.1	3.95	3.3	3.93	III
Говь-Алтай	4.63	3.75	3.94	3.69	3.85	3.77	3.1	3.82	IV
Хөвсгөл	4.36	3.5	3.76	3.78	3.87	3.72	3	3.71	V
Баян-Өлгий	4.74	3.41	3.48	3.42	3.83	3.54	3.4	3.69	VI
Өмнөговь	4.25	3.63	4.08	3.47	3.81	3.52	3.1	3.69	VI
Дорнод	4.42	3.3	3.65	3.62	3.79	3.8	3.1	3.66	VII
Завхан	4.38	3.95	4.13	3.34	3.67	3.36	2.8	3.65	VIII
Дундговь	4.33	3.75	3.75	3.41	3.82	3.67	2.6	3.62	IX
Дархан-Уул	4.56	3.56	3.71	3.35	3.69	3.49	2.8	3.59	X
Өвөрхангай	4.06	3.66	3.43	3.41	3.54	3.43	2.9	3.49	XI
Говьсүмбэр	4.15	3.42	3.45	3.22	3.73	3.45	2.8	3.46	XII
Хэнтий	4.07	3.36	3.65	3.26	3.79	3.41	2.7	3.46	XII
Булган	4.12	3.82	3.55	3.24	3.57	3.2	2.7	3.46	XII
Баянгол дүүрэг	4.2	3.53	3.49	3.07	3.64	3.32	2.9	3.45	XIII
Дорноговь	4.22	3.47	3.46	3.45	3.44	3.29	2.8	3.45	XIII
Ховд	4.24	3.29	3.47	3.28	3.58	3.22	2.9	3.43	XIV
Сэлэнгэ	4.4	3.34	3.45	3.31	3.4	3.04	3.0	3.42	XV
Орхон	4.31	3.32	3.4	3.17	3.63	3.38	2.7	3.41	XVI
Сүхбаатар	4.54	3.69	3.46	3.19	3.46	2.92	2.6	3.41	XVI
Сүхбаатар дүүрэг	4.45	3.14	3.36	2.99	3.29	3.18	2.8	3.32	XVII
Төв	4.46	3.28	3.33	2.94	3.0	3.68	2.5	3.31	XVIII
Чингэлтэй дүүрэг	4.11	3.18	3.47	2.67	3.67	3.17	2.4	3.24	XIX
Хан-Уул дүүрэг	3.96	3.25	3.34	2.99	3.22	3.37	2.4	3.22	XX
Баянзүрх дүүрэг	3.93	3.17	3.2	2.84	3.22	3	2.9	3.19	XXI
Сонгинохайрхан дүүрэг	3.4	2.88	3.07	2.76	3.21	3	2.6	2.98	XXII

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График II.43. Цагдаагийн алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийн нэгдсэн үнэлгээ



ЕС. НЭЭЛТТЭЙ АСУУЛТЫН ХАРИУЛТ

Цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжид эерэг болон сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор судалгаанд оролцогчдод нээлттэй асуулт тавьж, үр дүнг нэгтгэн дүгнэлээ.

9.1 ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЛБАНДАА СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙХАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгаанд оролцогчид албандаа сэтгэл ханамжтай байх хүчин зүйлсэд 139

хариулт бүхий 224 саналыг нэрлэжээ. Дэлгэрэнгүй саналыг Улаанбаатар хот, дүүрэг, бүс, аймгаар нэгтгэн Хавсралт II.10-т үзүүлэв. Эдгээр саналаас хамгийн олон давтагдаж байгаа 6 бүлэг хүчин зүйлийг сонгож дүн шинжилгээ хийв.

Судалгаанд оролцсон алба хаагчид ажилдаа сэтгэл ханамжтай байхад нөлөөлдөг 224 хүчин зүйлийг нэрлэсэн бөгөөд тэдгээрийн 159 буюу нийт саналын 71 хувь нь дээр дурдсан 6 бүлэгт хамаарч байна.

Хүснэгт II.10. Цагдаагийн алба хаагчийн албандаа сэтгэл ханамжтай байхад нөлөөлөх хүчин зүйлс, давталтаар

№	Сэтгэл хангалуун хүчин зүйлс	Давталт	Эзлэх хувь
1	Иргэдийн дунд нэр хүндтэй, бахархалтай алба	75	47.2
2	Ард иргэдийг амгалан тайван байлгах, тэднийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах	30	18.9
3	Гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, үүргээ биелүүлэх үед төрийн албаараа бахархдаг	25	15.7
5	Баталгаатай, тохилог ажлын байр	12	7.5
4	Хувцас хэрэгсэл хангамж	9	5.7
6	Хамт олны уур амьсгал, хамт олноороо бахархдаг	8	5
	Дүн	159	100

Хамгийн олон давталттай байгаа хүчин зүйлс нь иргэдийн дунд нэр хүндтэй, бахархалтай алба гэсэн агуулгатай 75 хариулт (47.2 хувь), ард иргэдийг амгалан тайван байлгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах гэсэн агуулгатай 30 хариулт (18.9 хувь), гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, үүргээ биелүүлэх үед төрийн албаараа

бахархдаг гэсэн хариулт 25 (15.7 хувь), баталгаатай тохилог ажлын байр гэсэн агуулгатай хариулт 12 (7.5 хувь), хувцас хэрэгсэл хангамж гэсэн агуулгатай хариулт 9 (5.7 хувь), хамт олны уур амьсгал, хамт олноороо бахархдаг гэсэн агуулгатай хариулт 8 (5.0 хувь) тус тус байв. Хариултуудын эзлэх хувь хэмжээг График II.44-т харуулав.

График II.44. Цагдаагийн алба хаагчдын албандаа сэтгэл хангалуун байхад нөлөөлөх хүчин зүйлс, хувиар



9.2 ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЛБАНДАА СЭТГЭЛ ХАНАМЖГҮЙ БАЙХАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгаанд оролцогчид сэтгэл ханамжгүй байхад нөлөөлөх 289 хариулт бүхий 688 хүчин зүйлийг нэрлэсэн байна (Дэлгэрэнгүй хариултыг аймаг, бүсээр Хавсралт II.2-оос харна уу). Эдгээр саналаас хамгийн олон давтагдаж байгаа 6 бүлэг хүчин зүйлийг сонгон Хүснэгт II.11-д үзүүлэв.

Судалгаанаас үзэхэд хамгийн их хувийг эзэлж байгаа хүчин зүйл нь цалин хөлс бага, нийгмийн баталгаа хангалтгүй гэсэн агуулгатай 151 (28.9 хувь), ажлын ачаалал, стресс ихтэй, орон тоо хүрэлцээгүй гэсэн агуулгатай 116 (22.2 хувь), илүү цагаар, цалин хөлсгүй их ажилладаг, ар гэртээ цаг зарцуулах боломжгүй гэсэн агуулгатай 99 (19.0 хувь), машин, техник, хэрэгсэл дутагдалтай, чанаргүй


хувцас, хэрэгсэлтэй, хангамж муу гэсэн агуулгатай 79 (15.1 хувь), улс төрийн нөлөө их, хууль бус шийдвэр гаргуулах тохиолдол байдаг, чиг үүргийн дагуу ажиллуулахгүй байх гэсэн агуулгатай 46 (8.8 хувь), торгуулийн хуудсаар шахах,

удирдлагын зарим үүрэг тодорхойгүй, шаардлагагүй бичиг цаасны ажил их гэсэн агуулгатай 31 (5.9 хувь) байна. Дээрх хүчин зүйлсийн эзлэх хувь хэмжээг График II.45-д нэгтгэн харуулав.

Хүснэгт II.11. Цагдаагийн алба хаагчийн албандаа сэтгэл ханамжгүй байхад нөлөөлөх хүчин зүйлс, давталтаар

№	Сэтгэл хангалуун бус хүчин зүйлс	Хүчин зүйлийн тоо	Эзлэх хувь
1	Цалин хөлс бага, нийгмийн баталгаа хангалтгүй	151	28.9
2	Ажлын ачаалал, стресс ихтэй, орон тоо хүрэлцээгүй	116	22.2
3	Илүү цагаар, цалин хөлсгүй их ажилладаг, ар гэртээ цаг зарцуулах боломж байхгүй	99	19
4	Машин, техник, хэрэгсэл дутагдалтай, чанаргүй хувцас, хэрэгсэлтэй, хангамж муу	79	15.1
5	Улс төрийн нөлөө их, хууль бус шийдвэр гаргуулах тохиолдол байдаг, хуулийн дагуу ажиллах боломжгүй байдаг	46	8.8
6	Торгуулийн хуудсаар шахах, удирдлагын зарим үүрэг тодорхойгүй, шаардлагагүй бичиг цаасны ажил их	31	5.9
Дүн		522	100

График II.45. Цагдаагийн алба хаагчдын албандаа сэтгэл ханамжгүй байхад нөлөөлөх хүчин зүйлс, хувиар



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

1. Цагдаагийн алба хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийг 7 бүлгийн 28 асуултаар үнэлж үзэхэд ерөнхий дундаж 5 байхаас 3.52 үнэлгээ авсан нь алба хаагчдын сэтгэл ханамж **дунд зэрэг** байгааг харуулж байгаа ба 2016 оны хэрэглэгчийн үнэлгээний дүнтэй (3.01) харьцуулахад 0.42 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд 21 аймаг, 6 дүүргийн 402 алба хаагч судалгаанд оролцсон бөгөөд улсын дунджаас дээгүүр үнэлгээг 11 аймаг, доогуур үнэлгээг 10 аймаг, 6 дүүрэг авчээ. Өөрөөр хэлбэл, нийт алба хаагчдын 36 хувь нь албандаа сэтгэл ханамжгүй, 64 хувь сэтгэл ханамжтай байгааг харуулж байна. Сэтгэл ханамжийн дундаж үнэлгээгээр жагсааж үзэхэд нэгдүгээрт Архангай аймаг, хоёрдугаарт Баянхонгор аймаг, гуравдугаарт Увс аймаг тус тус орсон байна.
2. Цагдаагийн алба хаагчид цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэгт **46.0** хувь, хууль ёсны байдалд **55.9** хувь, хүний нөөцийн бодлогод **58.9** хувь, байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйд **52.4** хувь, удирдлагын манлайлалд **56.0** хувь, алба хаагчийн баталгаанд **39.1** хувь нь сэтгэл ханамжтай байна. Өөрөөр хэлбэл, алба хаагчид хүний нөөцийн бодлогын талаар **сэтгэл ханамж өндөр** байгаа бол алба хаагчийн баталгааны талаар **сэтгэл ханамж** хамгийн доогуур байна. Дээрх 6 хүчин зүйлийн ерөнхий сэтгэл ханамж нь дунджаар 63.1 хувьтай байгаа нь цагдаагийн алба хаагч нь хэдийгээр **алба хаагчийн баталгаанд сэтгэл ханамжгүй** байгаа хэдий ч **ажилдаа сэтгэл ханамжтайг** харуулж байна.
3. Цагдаагийн алба хаагчдын ажлын байрандаа сэтгэл ханамжгүй байх гол хүчин зүйлс нь цагдаагийн байгууллагын орон тоо дутмаг, ажлын ачаалал их (2.44), цалин хөлс хангалтгүй (2.39), үүрэг гүйцэтгэх эдийн засгийн баталгаа хангагдаагүй байдал (2.62) гэдэгтэй 4 бүс, Улаанбаатар хотын алба хаагчид санал нэгдэж байна.

4. Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлого, удирдлагын манлайллын талаарх сэтгэл ханамж улсын хэмжээнд дундаж үзүүлэлттэй гарсан хэдий ч бүсээр нь авч үзвэл Улаанбаатар хотод ажиллаж байгаа алба хаагчид хөдөө орон нутгийнхантай харьцуулахад сэтгэл ханамж доогуур байна. Хүний нөөцийн бодлогын чиглэлээр нийт 7 асуулт тавьсан бөгөөд Улаанбаатар хотын алба хаагчид нийт 7 асуултаас 4-т нь 2.67-2.91 үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлж байна.
5. Цагдаагийн алба хаагч ажилдаа яавал сэтгэл хангалуун байх талаар нээлттэй асуулгаар санал авахад нэр хүндтэй, албаараа бахархдаг гэсэн агуулгатай хариулт 47 хувь, ард иргэдийг амгалан тайван байлгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах гэсэн агуулгатай хариулт 18.9 хувь, гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, үүргээ биелүүлэх үед төрийн албаараа бахархдаг гэх хариулт 15.7 хувь, баталгаатай тохилог ажлын байр гэсэн агуулгатай хариулт 7.5 хувь, хувцас хэрэгсэл хангамж гэх хариулт 5.7 хувь, хамт олны уур амьсгал, хамт олноороо бахархдаг гэсэн хариулт 5.0 хувийг тус тус эзэлж байна.
6. Цагдаагийн алба хаагчдаас албандаа сэтгэл хангалуун бус байх хүчин зүйлсийг тодорхойлуулах зорилгоор нээлттэй асуултад хариулт авахад цалин хөлс бага, нийгмийн баталгаа хангалтгүй гэсэн агуулгатай хариулт 28.9 хувь, ажлын ачаалал, стресс ихтэй, орон тоо хүрэлцээгүй гэсэн агуулгатай хариулт 22.2 хувь, илүү цагаар, цалин хөлсгүй их ажилладаг, ар гэртээ цаг зарцуулах боломжгүй гэсэн агуулгатай хариулт 19.0 хувь, машин, техник, хэрэгсэл дутагдалтай, чанаргүй хувцас, хэрэгсэлтэй, хангамж муу гэсэн агуулгатай хариулт 15.1 хувь, улс төрийн нөлөө их, хууль бус шийдвэр гаргуулах тохиолдол байдаг гэсэн агуулгатай хариулт 8.8 хувь, торгуулийн хуудсаар шахах, шаардлагагүй бичиг цаасны ажил их гэсэн агуулгатай хариулт 5.9 хувийг тус тус эзэлж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамж дунджаас доогуур үнэлгээ авсан бүс, аймаг, дүүрэг тус бүр ямар үзүүлэлт дээр анхаарч ажиллах талаар зөвлөмж боловсруулж алба хаагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх; дунджаас дээгүүр үнэлгээ авсан бүс, аймаг тус бүр үйл ажиллагаагаа улам сайжруулах шаардлагатай. Судалгааны тайланд дурдагдсан үзүүлэлт тус бүрт дүн шинжилгээ хийж улсын хэмжээнд алба хаагчдын ажлын байрандаа хандах сэтгэл ханамжийн түвшнийг 4.0 ба түүнээс дээш түвшинд гаргах чиглэлээр ажиллах;
2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох хүний нөөцийн хангалтыг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалтай уялдуулан нэмэх шаардлагатай. Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоол, Цагдаагийн Ерөнхий Газрын 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 3/63 дугаар албан бичгээр “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг баталсан ба уг тогтоолоор “1 хэсгийн байцаагч 4000 хүн ам тутамд, хэв журмын эргүүл нийслэлд 15000 хүн ам тутамд хоёроос доошгүй, аймгийн төвд 5000 хүн ам тутамд нэгээс доошгүй, эргүүлийн нэг чиглэлд хоёр алба хаагч үүрэг гүйцэтгэх” гэж жишиг норматив тогтоосныг харгалзан нэг алба хаагчид оногдох хүн амын тоо, ажлын ачааллыг багасгах, тэнцвэржүүлэх, ажил дүгнэх үзүүлэлтийг оновчтой болгох талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
3. Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.9 дэх хэсэгт заасан цагдаагийн алба хаагчийн үндсэн цалин, цолны цалин болон бусад нэмэгдлийн хувь хэмжээг нэмэх замаар шүүх, прокурор, авлигатай тэмцэх байгууллага зэрэг ижил чиг үүрэгтэй байгууллагын

алба хаагчдын жишигт ойртуулан нэмэгдүүлэх, холбогдох байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх;

4. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын стресс, сэтгэл гутралын түвшнийг тогтоож, түүнийг даван туулах арга зам, ач холбогдол, урьдчилан сэргийлэх талаар сургалт, зөвлөх үйлчилгээг сэтгэл зүйчдээр тогтмол явуулах, алба хаагчдаас гэр бүлдээ зарцуулах болон өөрийгөө хөгжүүлэх цаг, бололцоогоор хангах бодлого боловсруулж, хөтөлбөр хэрэгжүүлэх;
5. Цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай цагдаагийн албаны тухай хуульд заасан эдийн засгийн болон техник хэрэгслээр хангах баталгааг эдлүүлэх. Тухайлбал нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод түүнчлэн аймаг, хотын дотор цагдаагийн байгууллагад ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш,

зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгож байх, цагдаагийн алба хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, албаны орон сууц, уналга, холбооны хэрэгслээр хангах үүргийг цагдаагийн байгууллага хүлээнэ гэсэн заалтыг нэг мөр хэрэгжүүлэх;

6. Цагдаагийн алба хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийн судалгааг жил бүр тогтмол явуулах төсвийн зардлыг нэмэгдүүлэх, судалгааны асуулгыг боловсронгуй болгож олон улсын жишигт нийцүүлэх, судалгаа явуулах хугацааг тогтмолжуулж, оролцогчдын тоог нэмэгдүүлэх, судалгааны үр дүнг бодлого боловсруулах, шийдвэр гаргахад харгалзаж байх зэрэг болно.

ХАВСРАЛТ-II.1

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЛБАНДАА СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙХАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Баруун бүс		
Баян-Өлгий	Ажилдаа сэтгэл хангалуун байдаг	1
	Халуун дулаан уур амьсгалтай	1
	Нэг нэгнээ хүндлэх хүндлэл	1
	ЦБ-ын үйл ажиллагаа болон түүний алба хаагч нарын нийгмийн хамгааллын асуудалд анхаарч байгаа байдалд сэтгэл хангалуун байна	1
	Ажиллах орчин нь сайн	1
	Нэр төртэй алба	1
	Дэг журамтай алба	1
Говь-Алтай	Албаараа бахархдаг	6
	Шударга, журамтай, зорилготой байх, хариуцлагатай байдаг.	4
	Хуулийн хэрэгжилтийг хангахад	1
	Хууль бус үйл ажиллагаатай тэмцэх	1
	Цэргийн албаны тухай хуульд зааснаар тэтгэвэр тэтгэмжид эрт гардаг	1
	1 жилийг 1 жил 3 сараар тооцдог. Цаг хугацаандаа олгодог	1
Эрт тэтгэвэрт гаргадаг	1	
Завхан	Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж иргэдийн гомдол, хохирлыг бүрэн барагдуулах гомдол санал шийдвэрлэж өгдөг	4
	Албаны нэр хүнд өндөр	4
	Тэтгэвэрт арай эрт гарч тэтгэмж авах хууль эрх зүйн хувьд баталгаа хангасан	2
	Цол, албан тушаал ахих боломжтой	2
	Хууль хэрэгжүүлэх	1
	Албаараа бахархдаг	1
	Цагдаад ажиллах сэтгэл хангалуун байх нь тэсвэр тэвчээртэй байлгах хатуужилтай хүн болгоход оршино.	1
Ард иргэдийн цагдаадаа хүндэтгэлтэй хандаж ойлгодог болсон	1	
Увс	Цагдаагийн газрын удирдлага хамт олны уур амьсгал харилцаа	4
	Нийгмийн үзэгдэл болох гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх үед төрийн албаараа бахархдаг	4
	Ажиллах нөхцөлөөр бүрэн хангасан	2
	ЦБ-ын эрх зүйн дээшилж байгаа учир сэтгэл хангалуун байна.	1
	Төрийн төлөө тангараг өргөж ажилладаг	1
	Хувцсаа өмсөөд явахад сайхан	1
Төрөөс үзүүлж буй нийгмийн баталгаа	1	
Ховд	Хамт олны уур амьсгал сайн	1
	Хувь хүний зохион байгуулалт	1
	Ажил үүргээ хэвийн гүйцэтгэж байх	1

	Төрийн тусгай байгууллагын алба хаагчдаас ЦБ-ын алба хаагч зарим талаар энгийн иргэдээс илүү эрх эдэлдэг бахархал болж өгдөг	1
	Албаа гэсэн сэтгэл	1
	Албаны хувцас	1
	Ард түмний итгэл найдвар	1
Хангайн бүс		
Архангай	Ард иргэдийг амгалан тайван байлгах, гэмт хэрэг урьдчилан сэргийлэх	7
	Цагдаагийн алба хаагч нь эх орныхоо төлөө тангараг өргөж явдагтай байнга хангалуун байдаг.	4
	Албаараа бахархдаг	3
	Дарга удирдлагын манлайлал	1
	Албаны төлөө байх сэтгэл	1
Баянхонгор	Ажлын байр тохилог, хангамж сайн	4
	Нэр төр, албаны нэр хүнд	4
Булган	Алба хаагчийн эдийн засгийн баталгаа	1
Орхон	Албаараа бахархах	3
	Өрөө тасалгаа, компьютер ангилах нөхцөлөөр хангагдсан	1
	ЦАХ гэдгээрээ бахархдаг	1
	Ажиллах нөхцөл орчин	1
	Төрийн өмнөөс үүрэг гүйцэтгэн ядарсан, хохирсон иргэд тусалж үйлчлээд хариу талархлын үг сонсох	1
	Хийж байгаа ажлаараа бахархаж хамт олон уур амьсгал таатай байх нь олж ажил үүргээ, хэвийн гүйцэтгэх тохиромжийг бүрдүүлэх	1
Өвөрхангай	Сэтгэл хангалуун байх хүчин зүйлс	1
	Хийж буй ажил үүрэг	1
	Хууль эрх зүйн алба хаагчдад зориулсан	1
Хөвсгөл	Эх орныхоо өмнө үүрэг хүлээж ажилладгаараа үргэлж бахархаж ажилладаг	2
	ЦБ-ын үйлчилгээ	2
	Хувцас хангалттай сайн	2
	Албан үүрэг гүйцэтгэж явахад	2
	Өглөө эрт босоод хувцсаа өмсөөд гарах үед	2
Төвийн бүс		
Говьсүмбэр	Төрийн алба хаагч	2
	Найрсаг хамт олон ачаалал даах чадвартай	1
	Албаны нэр төр	1
	Ард иргэд олон нийтийн аюулгүй амьдрах нөхцөлийг хангаж ажиллах	1
Дархан-Уул	Өөрийн хийж буй ажилдаа сэтгэл хангалуун байдаг.	4
	Хамт олон уур амьсгалтай	1
Дорноговь	Гэр бүлтэйгээ байхад ажил албан тушаалаа хийхэд сэтгэл хангалуун байдаг.	1
	Ажлын байрны ажиллах нөхцөл	1
	Бичиг хэрэгслийн ашиглалт	1
	Хууль сахиулах иргэдийн амар амгалан байдлын төлөө	1
	Шөнийн цагаар эргүүлийн үүрэг гүйцэтгэхэд ард иргэд сэтгэл ханамжтай үг хэлэх	1

Дундговь	Энэ ажил хийхэд иргэдэд нэр хүндтэй. Иргэд хүндэтгэж харьцдаг	4
	Албандаа дуртай	3
	Төрийн хувцсаараа бахархдаг	1
	Албан тушаал дэвших боломжтой	1
Өмнөговь	Ажиллах нөхцөл, орчин сайн	1
	Өөрийн эзэмшсэн мэргэжлээрээ ажилладаг	1
	Нэгдсэн баг болж ажилладаг	1
	Албан ажлаараа бахархдаг	1
	Хуулиар нийгмийн баталгаа харьцангуй хангагдсан	1
	Залуу боловсон хүчнээр хангагдаж мэдлэг боловсролтой боловсон хүчин ихтэй	1
	Албаны нэр төр	1
	Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа буруу зөвийг ялгах гэх мэт олон зүйлүүд байдаг. Албандаа дуртай хайртай хүн уг ажлыг нягт нямбай сайн хийдэг.	1
Сэлэнгэ	Нийгэмд эзлэх байр суурь	1
	Иргэдийн аюулгүй байдлыг хангах	1
	Ажилдаа сонирхолтой төрийн тусгай албанд ажиллаж байгаа байдал	1
	Албан тушаал, албаны хувцас хэрэгсэл	1
	Албан үүргээ гүйцэтгэхэд төр болон ард иргэдээс хүлээн авч буй хандлага, үзүүлж буй дэмжлэг	1
Төв	Ажлын байр мэргэжилдээ дуртай	2
	Ажлын нөхцөл, хэрэгсэл сайн	2
	Өөрийн ажил мэргэжлээрээ бахархдаг	1
	Нэр хүнд, сонирхол	1
	Цагдаагийн алба хаагч залуу боловсон олон	1
	Хамтран ажиллахад эрч хүч сайтай	1
	Багаар ажиллах чадвар сайн	1
	Бие бялдрын хөгжил сайн	1
	Тогтмол цалинтай	1
	Хувцас формын хэрэглээ	1
Тогтмол ажилтай	1	
Зүүн бүс		
Дорнод	Иргэдийн амар тайван байдлын төлөө ажилладаг	4
	Нэр төртэй сайхан алба, хэрэг шийдэж түүнээсээ урам зориг авдаг	3
	Албаараа өөрөө бахархаж ажиллах	2
	Хууль дүрмийн дагуу ажилладаг	1
	Иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгийг гадны хандлагаас урьдчилан сэргийлж, эрүүл чийрэг нийгэм бүрдүүлэхийн төлөө үйл ажиллагаа хэрэгжүүлдэг	1
Сүхбаатар	Энэ албанд орж ажилласнаараа бахархаж явдаг	4
	Ажиллаж байгаа орчин нөхцөл	2
	Ажилдаа хүсэл сонирхолтой	2
	Гэмт хэрэгтнийг илрүүлэхэд ихэд урамшдаг	2

Хэнтий	Төрийн нэр хүндтэй алба	2
	Гэмт хэрэгтэй тэмцэх	1
	Нийгмийн хэв журам сахиулах	1
	Олон нийтийн аюулгүй байдлыг нэр төртэй хамгаалах үед	1
	Иргэний төлөө ажиллах	1
	Хүн бүртэй тэгш харьцахыг эрмэлздэг	1
	Бурууг дарж, зөвийг дэмждэг	1
	Ард иргэдийн төлөө амар тайван байдлын төлөө	1
	Төрийн өмнөөс иргэдэд үйлчилдэг учраас	1
Цагдаа гэдэг сайхан алдар нэр хүндийг ямагт өндөрт өргөхийг хичээдэг	1	
Улаанбаатар хот		
Баянгол дүүрэг	Бусдын төлөө ажиллаж байдаг	1
	Шударга байх	1
	Дэмжиж урам хайрладаг	1
Сонгино-хайрхан дүүрэг	Удам залган ажиллаж байгаадаа баяртай байдаг	3
	Гаргасан алдаа дутагдлын шалтгаан нөхцөлийг бүрэн гүйцэд судалсан байх	1
	Гаргасан зөрчилд нийцсэн байх	1
	Орон байр	1
	Техник хангамж	1
	Албаны дүрэмт хувцас	1
	Ажил мэргэжил	1
Төрийн өмнөөс ажил үүрэг гүйцэтгэдэг	1	
Сүхбаатар дүүрэг	Нэр хүнд	3
	Хийсэн ажлаа үнэн зөвөөр үнэлүүлэх	3
	Тогтолцоо	1
	Эрх зүйн орчин	1
Чингэлтэй дүүрэг	Цагдаагийн албанд орж ажилласандаа сэтгэл хангалуун	3
	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд өөрийн хувь нэмрээ оруулж байгаа тул сэтгэл ханамжтай	1
	Амар тайван амьдралын төлөө ажилладаг	1
	ЦБ-д ажиллаж байгаадаа тэр тусмаа мөрдөн байцаах албанд ажиллаж байгаа нь албандаа дур сонирхолтой учраас сэтгэл хангалуун байдаг	1
	Шударга байх	1
	Төрийн алба хаагч гэдгээрээ бахархдаг	1
	Өөрийн шийдвэр хүсэл зорилгоор орсон тул албандаа сэтгэл хангалуун ажилладаг	1
	Сэтгэл хангалуун байх хүчин зүйлс	1
Баянзүрх дүүрэг	Нийгмийн баталгаатай	1
	Ажиллах орчин, техник тоног төхөөрөмж, хангамж сайтай	1
	Хамт олонтой мөр зэрэгцэн ажиллах	1
	Цагдаагийн алба хаагч, байгууллагын нэр хүндийг хуваалцаж яваа байдал	1
	Алба хаагч бүр ажилдаа дур сонирхолтой байх	1
Хан-Уул дүүрэг	Одоо эрхэлж буй ажил мэргэжлийн бөгөөд сонирхолтой байдаг.	1

ХАВСРАЛТ-II.2

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЛБАНДАА СЭТГЭЛ ХАНАМЖГҮЙ БАЙХАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Баруун бүс		
Баян-Өлгий	Алба хаагчийн эрх, үүрэг нь иргэний эрх, үүргээс доор байдаг	2
	Албан тушаал солих	2
	Ар гэрийн асуудал	2
	ЦАХ-ыг хамгаалсан эрх зүйн зохицуулалт маш сул учраас өөрсдөө эргээд гэмт хэрэгтэн болох гээд байдаг	1
	Алба хаагчаа хамгаалах систем суль асуудал гаргахаар ЦБ-ын алба хаагчийн гаргасан алдаа дутагдлыг хамгийн түрүүнд тогтоодог	1
	Техникийн хэрэгсэл, парк шинэчлэлт, нууцлал хадгалах, хараат бус ажиллах зэрэг ажлуудад ач холбогдол өгч улам сайжруулах шаардлагатай гэж боддог.	1
	Ээлжийн амралт бүрэн эдэлж чадахгүй байна.	1
	Хөдөө орон нутагт томилолтоор ажиллахад хууль журамд заасан томилолтоо авч чадахгүй	1
	Баяр ёслолоор байнга ажилтай	1
	Сургалтад хамруулж байгаа байдал	1
	Шагнал урамшуулал	1
Говь-Алтай	Цалин хөлс бага	8
	Илүү цагаар ажилладаг	4
	Хувцасны хангалт чанар муу, сонголтгүй	4
	Машин техник асуудал актлах болсон автомашинуудтай	3
	Ажлын ачаалал их	3
	Нийгмийн асуудлыг шийддэггүй	3
	Эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй үзүүлдэггүй	3
	Гэр бүлдээ цаг зав гаргах нь ховор	3
	Улс төр эвслээс ангид байх хараат бус, дарга нар албандаа сэтгэлтэй байх	2
	Алба хаагчдын хооронд харилцаа, бие биедээ хүндэтгэлгүй хандах	2
Үйл ажиллагааны зардал	1	
Завхан	Цалин бага	9
	Ахуй хангамж муу хувцас чанар муу, техник хэрэгсэл, тусгай хэрэгсэл байхгүй	5
	Цагдаагийн алба хаагчдад олгох цалин, урамшуулал прокурор, шүүхийн ажилтнуудын цалин урамшууллаас бага	3
	Ажлын байрны нөхцөл бололцоог бүрэн хангах	3
	Үндсэн ажил хийлгэх өөр ажил даалгахгүй байх	3
	30 сарын тэтгэмж олгохгүй байна	1

	Алба хаагчдын ар гэрийн баталгаа хангалтгүй	1
	Албандаа шударга бус хандах тохиолдол бий	1
	Сахилга ёс зүйгүй байх	1
	Удирдлагын үүрэг даалгавар ажлын байрны ялгаатай ханддаг	1
Увс	Цалин бага	5
	Машин тэрэг дутагдалтай	3
	Үүрэг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц техник хэрэгсэлтэй байх	2
	Үүрэг гүйцэтгэх орчин өрөө тасалгаа дутмаг	2
	Ажлын ачаалал тэнцвэргүй	1
	Удирдлагын манлайлал, алба хаагчдын ажлыг үнэлэх	1
	Ар гэрийн баталгаа ямар нэгэн халдлагад өртөж болзошгүй	1
	Нийгмийн болж бүтэхгүй үргэлж сүүдэртэй талд ажилладаг	1
	Стресс	1
	Ажил үүргээ гүйцэтгэхэд нь нөлөөлөхөөр завдах	1
	Увс аймаг хүйтэн учир хангалттай дулаахан хувцас хэрэгтэй байна.	1
	Цагдаагийн албанд төрөөс оролцох, дарга удирдлагын намын харьяаллаар томилох	1
	Тоног төхөөрөмж дутмаг	1
	Тусгай хэрэгсэл	1
Ховд	Цалин хөлс нэмэгдүүлэх	7
	Цаг хугацаагүй байдал илүү цагаар ажиллах	4
	Ажлын ачаалал тэнцвэржүүлэх	4
	Техник хэрэгсэл хүрэлцдэггүй	3
	Орчин сайн байх	3
	Хуульд заасан эрх үүргийн дагуу хараат бусаар үүргээ гүйцэтгэх	3
	Мэдлэг чадвар дутмаг	1
	Хууль бус тушаал шийдвэр	1
	Шаардлагатай чөлөө зөвшөөрөл олгох	1
	Дарга нарын дарамт шахалт	1
Ажлын стресс их	1	
Хангайн бүс		
Архангай	Ажлын ачаалал ихтэй	7
	Хүний нөөц, орон тоо хүрэлцээ муу	3
	Ахуй хангамж, цалин хөлс тааруу	3
	Ажиллах орчин нөхцөл	2
	Гэр бүл үр хүүхдэдээ анхаарал бага хандуулдаг	2
	Мөрдөгч нарыг эргүүл, харуулд ажиллуулдаг	2
Баянхонгор	Ажлын ачаалал ихтэй	4
	Чөлөөт цаг бага	4
	Ар гэртээ цаг зав зарцуулах боломжгүй	4
	Цаг завгүй	4
	Ачаалал ихтэй үүнийг ойлгож мэдэх хүн байхгүй	4
	Илүү цагаар ажиллах нь их боловч илүү цагийн мөнгө цалин болдоггүй	3
Дүрэмт хувцасны хугацаа эдэлгээний урт, сүүлийн үед чанар нь муудсан	3	
Ар гэр, хувийн амьдралдаа зарцуулах цаг бага тул цагийг нэмэгдүүлэх	3	

	Зөрчлийн тухай хууль 2017 оны 7 сараас хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан зөрчлийн гэмт хэрэгт олон шаардлагагүй баримт бүрдүүлэх болсонтой холбогдуулан хуулийн нэг мөр ойлгож ажиллахад хүндрэл бэрхшээлтэй ар гэртээ цаг зав бага зарцуулдаг, цалингүй, нойр хоолгүй ажилладаг	3
	7 хоногийн хугацаанд маш олон цугларалт болдог	3
	Цалин нь алба хаагчдад хангалттай хүрэлцдэггүй	3
	Цалин хөлс бага	3
	Дэвшилтэд техник хэрэгсэл дутагдалтай	3
	Иргэдээс цагдааг хүн гэдэг талаас нь үздэггүй	1
Булган	Цалин хөлс бага	5
	Ар гэр хол байдаг байдал	3
	Орон байр	3
	Алба хаагчийн саналыг авахгүй	1
	Байнгын дарамт шахалт	1
	Техник хэрэгсэл, ахуй хангамж	1
	Нийгмийн асуудал шийддэг байх	1
	ЦАХ-ын шилжилт хөдөлгөөн хийхэд ар гэрт хүндрэл учирдаг	1
	Төсөв санхүү хүндрэлтэй	1
	Ажлын байрны орчноо сайжруулах	1
	Аймаг орон нутгаас ЦБ-ын үйл ажиллагаа хэвийн явагдахад дэмжихгүй байна маш муу	1
	Орхон	Ажлын ачаалал их
Цалин хангамж муу		3
Алба хаагч нар хувийн техник, гар утсаар төрийн ажлыг хийж байна.		2
Удирдлагын дарамт		1
Хууль бус шийдвэр гаргуулах тохиолдол байдаг		1
Орон тоо хангалтгүй		1
Ажиллах нөхцөл хангагдаагүй		1
Хуулийн орчин бүрдээгүй		1
ЦБ-ын томилгоонд улс төр оролцдог		1
Ажлын цаг амралт тохируулж байх		1
Ээлжийн амралтыг бүрэн эдлүүлдэггүй		1
Иргэдээс ЦАХ-ын харьцах харьцаа, хандах хандлага муу		1
Өвөрхангай	Тусгай хэрэгсэл хангамж муу	3
	Цалин хөлс бага	3
	Ажлын ачаалал багасгах илүү цагийн мөнгө олгох	3
	Ээлжийн амралт 1 жил эдлээд авч байна илүү амралт олгодоггүй	1
	Унаа тэрэг албанд байхгүй машин муу ирдэг	1
	Бензин шатахуун хүрэлцдэггүй	1
	Суманд 2 хүн ажиллаж байна, ажиллах хүч хангалтгүй	1
	5 жил тасралтгүй хөдөө орон нутаг 30 сартай тэнцэх хэвээрээ байвал сайн байна	1
	Чанаргүй хувцас хэрэглэл	1
	Цол олголт хуулиасаа гадна дагаж мөрдөх гээд хугацааг нэмдэг нь буруу	1
Ажилд хөндлөнгөөс нөлөөлөх гэсэн оролдлого	1	

	Залуу боловсон хүнийг дэмжих бодлого муу	1
	Алба хаагчийг аюулгүй байдал хангах	1
	Ажиллах хүч нэмэгдүүлэх шаардлагатай	1
	Орон тоо хангалтгүй ажлын ачаалал их	6
	Тухайн хороо нутаг дэвсгэрт аливаа дуудлага өгсөн тохиолдолд техник хэрэгсэл машин тэрэгний хүрэлцээ хангамжаас болж тэр болгон очиж чаддаггүй	2
	Ажиллах нөхцөл, ажлын байр дутагдалтай	2
Хөвсгөл	ЦБ-г үйлчилгээ албан байгууллага алба хаагчдыг иргэдээс дураараа янз бүрээр хэлж, доромжлох дээрэлхэх зүйлс их байдаг.	2
	Бусад, хууль сахиулах байгууллагын алба хаагчдын цалин болон хангалтын асуудал дутмаг байдаг тул сэтгэл хангалуун бус байдаг.	2
	Шинэ гарсан хууль амьдралд нийцэхгүй хүний эрх зөрчсөн, хулгай хийсэн хүнд дахин хийх боломж олгож байгаа	2
Төвийн бүс		
	Ажлын ачаалал их стресс ихтэй.	10
	Техник тоног төхөөрөмж дутагдалтай, шинэчлэх шаардлагатай	7
	Цалин хөлс муу хүрэлцээгүй	5
	Орон тоо хүн дутмаг илүү олон цагаар ажиллах	3
	Ажлын ачаалал зөв хуваарилалт дутмаг	2
	Давхардсан нэг чиглэлийн үүрэг ирдэг	2
	Шаардлагагүй бичиг хариу нэхдэг	2
Говьсүмбэр	Амралтгүй ажиллах	2
	Нийгэм эдийн засгийн баталгаа муу	2
	ЦЕГ-ын гаргасан тушаал, шийдвэр нь зарим тохиолдолд хууль тогтоомжийг зөрчсөн байдаг.	2
	Ажлын байр стандарт хангагдаагүй	2
	Ар гэрийн ажилгүйдэл	2
	Тухай албан тушаалд нь тогтвор суурьшилтай	2
	Удирдах албан тушаалтнуудын улс төрийн зорилгоор байнгын өөрийн, ашиглах нөхцөл бололцоо, боломжийг олгохгүй байна.	2
	Цалин хөлс хангалтгүй	11
	Ажлын ачаалал, стресс ихтэй, цаг наргүй ажилладаг	4
	Техник хэрэгсэл дутмаг, нөхцөл муу	4
	Улс төрийн шалтгаант нөлөөлөл ихтэй	3
Дархан-Уул	Дарга нар маань баг бүрэлдэхүүн сайн ойлгож, иргэний үгэнд шууд оролгүй ажиллаж байгаа алба хаагчийнхаа эрх ашгийг хамгаалах нь чухал байна.	2
	Техник хувцас форм хангалттай байхад болно.	2
	Хууль эрх зүйн орчинд сэтгэл хангалуун бус	2
	Ээлжийн амралт хугацаанд амраадаггүй	1

	Орон нутагт орон тоо хүрэлцээгүй	9
	Цалин хөлс хангамж муу	6
	Цэргийн алба хаагч нь нийгмийн асуудал хүнд	4
	Ажлын ачаалал тохируулж чадахгүй удирдлагыг сольж ажиллуулахгүй энэнээс болж халагдаж байна.	4
	Нөхөн хангалт маш муу ялангуяа хөдөө орон нутагт техник хэрэгсэл хангалтгүй байдаг	4
	Дүрэмт хувцасны чанар	4
Дорноговь	1 алба хаагчийг өөр өөр олон ажил хийлгэж хөдөлмөрийн хууль зөрчих	3
	Хөдөө орон нутагт томилогдон ажиллахад гэр бүлээсээ хол, хөлсний байранд эдийн засгийн дарамтад ордог.	3
	Илүү цагаар их ажилладаг, хөдөлмөрийн хуулийг зөрчдөг	3
	2 ажил давхар гүйцэтгэхэд хөдөлмөрийн хуулиар цалин нэмэгдүүлж байх	2
	Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүнтэй хувьд сурч боловсрох нөхцөл бүрдүүлэх сайн судалгаа хийх	2
	ЦБ-ын дарга нарын удирдах арга барил улс төрийн нөлөөнд орсон байдаг.	2
	Эрүүлжүүлэх, саатуулах байранд гарч байгаа эмч цагдаа нар хортой нөхцөлд ажилладаг тул хордлого тайлах сүү витамин зэрэг хангамж өгөх	2
	Цалин бага	9
	Ажлын цаг болон чөлөө зав (ар гэртээ) тааруу	7
	Албан хэрэгцээнд бичиг хэргийн хангалт, шатахуун хангалт байхгүй	3
	Чиг үүргийн дагуу ажил үүргийг гүйцэтгэх явцад нэгэн албан тушаалтан хөндлөнгөөс оролцож дарамт шахалт үзүүлж байна.	3
Дундговь	Техник хэрэгслээр дутмаг	3
	Иргэдийн хандлага муу	2
	Ажлын ачаалал их	2
	Амьдрах нөхцөл байдлаар бүрэн хангагдах	2
	Удирдлагын шийдвэр муу	2
	Цалин хөлс	3
	Бүтэц орон тоо дутуу байдаг иймээс ачаалал их. Жишээ нь: Тусгайлсан хэрэг бүртгэсэн байхгүй	2
	Ажлын байрны нөхцөл	2
	Хууль зорчсон хүний хариуцлагагүй хуулийн цоорхойгоос болж хариуцлага хүлээдэг	2
	Орон тоо	4
	Ажлын ачаалал их, үүрэгт ажлаас гадуур, илүү цагаар ажиллана	2
Өмнөговь	Шалтгаан нөхцөлийг дутуу үнэлж дүгнэж зөвхөн нэг талаас бүх асуудалд ханддаг	1
	Удирдах бүрэлдэхүүн би үлдэж байвал бусад нь хамаагүй гэсэн байдал гаргадаг	1
	Нийгмийн асуудал хүнд	1
	Техник хэрэгсэл	1
	Хууль чанаргүй байдал	1
	Эрүүл мэндийн чиглэлээр ажиллагсдыг хамруулах шаардлагатай	1

Төв	Ажлын ачаалал ихтэй, ачааллыг тэнцвэржүүлэх ээлжийн амралтын бүрэн дүүрэн тогтсон хугацаанд нь эдлүүлж байх шаардлагатай байна.	3
	Цалин хөлс бага	3
	Стресс, ачаалал их	2
	Бичиг цаас их байна. Цаас боловсруулалт маш их	2
	Нийгэм халамж	2
	Орон байр	2
	Хамт олондоо үнэлж муу дарга нарийн үйл ажиллагаа , тэдний харилцаа	1
	Иргэдийн болон зарим албан тушаалтнаас цагдаагийн байгууллага руу дарамт	1
	Дарга ахлах орон тоо их	1
	Гадаад хэлний мэдлэг дутмаг	1
	Орон тоо болон хүн хүч хүрдэггүй	1
	Ажлын цаггүй	1
	Ар гэрийн хүнийг ажлын байраар хангах	1
	Сэлэнгэ	Сарын цалин амьдралд хүрэлцдэггүй
Илүү цагаар ажиллах тохиолдол их боловч илүү цагийн мөнгө авдаггүй.		3
Алба хаагчдын ажлын байрны хүртээмж, орон тоо гэх зэрэг		3
Албан тушаал дэвших, шагнал урамшуулал		1
Дарга, албан тушаалтны байнга солигдох солигдмол, шударга бус томилгоо гэнэтийн байдаг нь тогтвортой, амжилттай ажиллахад саад болдог.		1
Нийгмийн ихэнх масс цагдаагийн онцлогийг ойлгодоггүй		1
Ажил үүрэг гүйцэтгэхэд хөндлөнгөөс нөлөөлөл оролцдог		1
Улс төрийн нөлөөллөөс хол байлгах		1
Ар гэрийн болон ахуй амьдралтай цаг зарцуулах цагийг гаргаж өгөх		1
Техник хэрэгслийн хангамж		1
Зүүн бүс		
Дорнод	Ажлын ачаалал их	10
	Цалин урамшуулал бага	5
	Хуульд заасан цагаар ажилладаг байх	3
	Ажил үүргийн тэгш хуваарилалт	3
	Ар гэртээ анхаарал хандуулах цаг байхгүй	3
	Амралт бага	1
	24 цаг жижүүрт гараад оройн дахиад ажилтай байдаг.	1
	Хотод 24 гараад 48 амрах ёстой хөдөө орон нутагт хэрэгждэггүй.	1
	Сурах боломжоор хангах	1
	Удирдлагын арга барил	1
	Хангалт муу, орон нутагт шинээр томилогдож байгаа алба хаагчдад байр орон сууц хангалттай үнээр хөлслөх нөхцөл бүрдүүлэх	1
	Ажлын үр дүн үнэн зөв үнэлэх нь дутмаг	1
	Гэмт хэрэгт тэмцэх мөрдөгчийн тоо хангалтгүй	1
	Төлөвлөгөө үр дүнд хүрэхийн тулд мөрдөгч нар бүх цаг хүчээ шавхдаг , байнга илүү цагаар ажилладаг	1
	Ээлжийн ажилтай алба хаагчид хөдөлмөрийн хуулийн дагуу ажиллуулдаггүй. ЦЕГ-аас орон тоог дутуу баталсан	1

Сүхбаатар	Цалин бага	10
	Хувцас хангалтгүй сонголтгүй	5
	Ээлжийн амралт хуваарийн дагуу олгож чаддаггүй	5
	Орон тоо бага	5
	Ажлын ачаалал их	4
	Материаллаг бааз буюу бусад хэрэгсэл зүйл дутмаг (принтер, цаас, хор)	4
	Ажил үүргээ гүйцэтгэж байхад том дарга нар танил хүмүүсээ авдаг, хүний эрхийн тал дээр тэгш бус танилтай хүн талын чинээ гэдэг байдлаар ханддаг.	4
	Ар гэртээ гаргах цаг хугацаа бага	3
	Зарим дарга нарын зан ааш	3
	Банк санхүүгийн байгууллагатай харьцахад дарааллын журам сахиж цаг алддаг.	2
	Ялагчидтай харьцах	2
5 жилийн тэтгэмж олгох хөдөө орон нутгаар ялгаж олгох	2	
Хэнтий	Цалин багатай	10
	Гэр бүлдээ гаргах цаг зав байхгүй	4
	Ажлын ачаалал их, стресс ихтэй	4
	Орон тоо хүрэлцээгүй	2
	Орон байр хомсдолтой	2
	Тоног төхөөрөмж	2
	Хангамж	2
	Хүмүүс цагдааг үргэлж муугаар ярьдаг	2
	Хуулийн дагуу үүрэг гүйцэтгэхэд эрх зүйн байдалд дордсон, хэтэрхий номхон хүлцэлгүй ЦАХ-ыг бий болгосон.	2
	Ажлын байрны дарамт их байна.	2
	Хэтэрхий хайрцаглагдсан, баригдмал байдаг	2
	ЦАХ-ын эрх ашиг хангах	2
	Шилжилт суурьшилтад гэрээ нэрээр хориг тавьдаг	2
Дарга удирдлага нарын харилцаа ёс зүйн хэм хэмжээ чухал	2	
Гэр бүлийн байдал, эдийн засаг нь хэн нэгнээс хараат бус байх	2	
Улаанбаатар хот		
Баянгол дүүрэг	Ажлын ачаалал тэнцвэржүүлэхгүй байна	1
	Хүний нөөцийн асуудал хангалтгүй ахлагч бүрэлдэхүүн офицер болгох асуудал байнга учир дутагдалтай байдаг	1
	Алба хаагч нарын гэр орон, амьдрал ахуйтай танилцдаггүй	1
	Шинээр батлагдсан хууль журмаар ахлагч бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулдаггүй. Дан ганц офицер бүрэлдэхүүнд заадаг.	1
	Цалин хөлс маш бага	1
	Ард иргэдэд нэр хүнд унасан	1
	Шударга бус ялгавартай харилцаа	1
	Дарга үнэлэхгүй байх	1

Сонгинохайрхан дүүрэг	Цалин бага	5
	Ажлын ачаалал их	5
	Иргэдийн дунд албаны нэр хүнд муу	3
	Хангалт муу	1
	Гаргасан алдаа зөрчлийн шалтгаан нөхцөлийг бүрэн тогтоодоггүй, шалгагч өөрийн үзэмжээр шийдвэр гаргадаг.	1
	Шагнал урамшил, төрийн одон медаль шударга бус олгодог	1
	Дарамттай	1
	Иргэдээс үзүүлж буй сөрөг харилцаа	1
	Цагдаагийн албаны бүтэц тодорхой бус, эрүүгийн мөрдөгч нарын дарамт өндөр	1
	Дарга нар авлигалд автагдаж ажилтнуудад хууль бус шаардлага тавих	1
	Улс төрийн нөлөө дэндүү их	1
Сүхбаатар дүүрэг	Цалин нэмэгдүүлэх	6
	Удирдлагын шийдвэр, ур чадвар муу	3
	Ажлын ачаалал	2
	Иргэдийн таагүй харилцаа, сөрөг хандлага	2
	Шударга бус байдал	2
	Хуучин арга барилтай байгаа нь алба хаагчаа гэсэн сэтгэл байхгүй	1
	Нийгмийн буруутай үзэгдлийн буруутай байдлыг алба хаагч арилгах ёстой мэт бодож байгаа	1
	Боловсрол	1
	Үнэлэмж	1
	Нийгмийн баталгааг сайжруулах	1
	Авлигагүй болж шударгаар хэргийг үнэн зөв шийдэх	1
	Дарга нарын зүгээс алба хаагч нарын хамгаалдаггүй, гомдол гаргасан хүн ирэх юм бол алба хаагч зөв ч бай буруутгадаг	1
	Ажил хаяж явдаг цалин муугаас болж	1
	Ажиллах нөхцөл байдал тогтворгүй	1
	Хуульд заасны дагуу ахиж дэвших асуудал нээлттэй байдаггүй	1
	Нэр хүндгүй, хийсэн ажил дүгнэгдэхгүй үр дүнгүй байх	1
	Хангамж муу	1
	Ажлын үр дүнгийн үнэлэмж тэгш бус	1
	Хүйсийн ялгаа гаргадаг	1
	Ажлын байрны стресс	1
Цаг зав ар гэртээ бага зарцуулдаг	1	

	Цагдаагийн алба хаагчдын торгуулийн хуудсаар шахах нь иргэдээс ЦБ-н үнэлэх үнэлэмж, хандлагыг бууруулах хандлагатай байдаг. Ихэвчлэн замын цагдаа жолооч нарын хооронд ийм асуудал гардаг.	10	
	Ажлын ачаалал ихтэй байна	4	
	Чанаргүй хувцас, хэрэгсэл болсон боловч үзэмж харагдах байдал	3	
	Цалин бага	1	
	Амралт чөлөөт цаг бага	1	
	Зөв зохион байгуулах бичиг хэрэг компьютер бусад техник хэрэгсэл дутмаг	1	
	Байнгын айдас түгшүүрт стресст орох магадлалтай	1	
	Удирдах албан тушаалтан алба хаагчийг ялгаж харьцаж байгаа хараад үүн дээр сэтгэл хангалуун бус явдаг	1	
	ЦАХ-дад урам зориг өгөх тэдний санаа бодлыг дэмжиж ажиллах	1	
	Зарим дарга нар удирдах чадваргүй хувиа бодсон ийм хүмүүсийг зайлуулах хэрэгтэй	1	
Чингэлтэй дүүрэг	Алба үүрэг гүйцэтгэх явцад аюулгүй байдлаа хамгаалахад тусгай хэрэгсэл муу хятад чанар муутай эд зүйл ашиглаж	1	
	Унаа техник шинэчлэл хийх шаардлагатай	1	
	Алба хаагчийн эрх ашгийг хамгаалах ажил үйлчилгээ	1	
	ЦБ-ын ажилд орж байгаа алба хаагчийг урамшуулан дэмжих сонгох энэ тогтолцоо алдагдсан	1	
	Алба хаагчийг доромжлох хараах	1	
	Амралт бага	1	
	Алба хаагчдын ажил дүгнэх үнэлгээ оновчгүй, мэдлэг боловсрол дээшлүүлэх мэргэшүүлэх сургалт дутмаг	1	
	Удирдах алба хаагчдын тогтворгүй томилгоо	1	
	Шударга бус байдал	1	
	Бүх зүйл прокуророос хамааралтай болсон нь үнэндээ бид нарыг хүчгүйдүүлж зүгээр л боол мэт болгож байна	1	
	Цагдаагийн байгууллага болон ЦАХ-ыг хүчтэй мэдээллийн нэгдсэн баазтай, эдийн засаг болон нийгмийн баталгаатай байлгах	1	
	Алба хаагчдын албандаа сэтгэл хангалуун байлгах гол хүчин зүйл нь тэдний нийгмийн асуудал шийдэх орон сууцжуулах хангалттай зээлээр хамрагдуулах мөн урамшуулал	1	
	Баянзүрх дүүрэг		
		Дарга нарын ёс зүйгүй шударга бус байдал	3
		Хүний нөөцийн томилгоо хууль ёсны байх	1
		Алба хаагчийг мэргэшсэн ажил албанд нь тогтвортой ажиллуулах	1
	1 ажилд тогтворгүй ажиллуулдаг	1	
	Алба хаагчийг ээлжийн амралттай байхад болон тухайн байгууллагын саналыг авахгүй ажлын байр өөрчилдөг	1	
	Алба хаагчдын хувьд ар гэрт зарцуулах цаг маш бага байдгаас амьдралд таагүй уур амьсгал үүсэж сэтгэлзүй хувьд сэтгэл хангалуун бус	1	
	7 хоногт нэг өдөр амарч байна.	1	
	Ажлын ачаалал	1	
	Шударга бус байдал хууль хэрэгжүүлэх	1	
	ЦАХ-ын амьдралын баталгааг нийгмийн асуудал бүрд шийдэж өгвөл сэтгэл хангалуун байх болно	1	

	Ажлын ачаалал их орон тоо бага	1
	Цалин бага	1
Хан-Уул дүүрэг	Дээд байгууллагад байгаа дарга нарын нүдээр харах биш доод нэгжид байгаа алба хаагчдын нүдээр харж асуудлыг шийдэж баймаар байна.	1
	Хангамж бага наад захын сард 70-90 хэрэг шалгаж байхад бичгийн цаас 200 ширхэг өгдөг хэрэг шалгах гэж өөрийн халааснаас мөнгө гаргаж байна.	1



ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

III

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	214
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	215
НЭГ. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУДЫН	
ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАДАГ ЧИГЛЭЛ	216
1.1 Улсын хэмжээнд бусад байгууллагын цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг чиглэл	216
ХОЁР. ХУУЛЬ ЁСНЫ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ	218
2.1 Улсын хэмжээнд хууль ёсны зарчмын хэрэгжилтэд хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээ	218
2.1.1 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	220
2.1.2 Хангайн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	220
2.1.3 Төвийн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	221
2.1.4 Зүүн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	222
2.1.5 Улаанбаатар хотын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ	223
ГУРАВ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ХАРИЛЦААНЫ	
СОЁЛ, ЁС ЗҮЙН ТӨЛӨВШИЛ	225
3.1 Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	225
3.1.1 Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	227
3.1.2 Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	228
3.1.3 Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	229
3.1.4 Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	230
3.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ	231
ДӨРӨВ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ	
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН БАЙДАЛ	233
4.1 Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ	233
4.1.1 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ	234
4.1.2 Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ	235

4.1.3 Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж	236
4.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж	237
4.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж	238
ТАВ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ	240
ЗУРГАА. НЭЭЛТТЭЙ АСУУЛТЫН ХАРИУЛТ	243
6.1 Цагдаагийн байгууллага, алба хаагчтай хамтран ажиллахад хялбар болон хүндрэлтэй байдаг асуудлын талаарх санал	243
6.2 Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, түүний үр нөлөөг сайжруулахад чиглэгдсэн санал, хүсэлт	244
ДҮГНЭЛТ	246
ЗӨВЛӨМЖ	248
ХАВСРАЛТ-III.1	249
ХАВСРАЛТ-III.2	257

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт III.1.	Цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг байгууллагуудын чиглэл, давхардсан тоогоор	217
Хүснэгт III.2.	Хууль ёсны зарчмын хэрэгжилтэд хамтран ажилладаг байгууллагын өгсөн үнэлгээ, улсын хэмжээнд, хувиар	219
Хүснэгт III.3.	Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, хувиар	226
Хүснэгт III.4.	Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, бүсээр	227
Хүснэгт III.5.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, улсын дүнгээр	233
Хүснэгт III.6.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, бүсээр	234
Хүснэгт III.7.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ	241
Хүснэгт III.8.	Цагдаагийн байгууллага, алба хаагчтай хамтран ажиллахын давуу болон сул тал	244
Хүснэгт III.9.	Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, түүний үр нөлөөг сайжруулахад чиглэгдсэн санал, хамгийн олон давталтаар	245

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График III.1.	Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, хувиар	217
График III.2.	Хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, бүсээр	219
График III.3.	Баруун бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар	220
График III.4.	Хангайн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар	221
График III.5.	Төвийн бүсийн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар	222
График III.6.	Зүүн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар	223
График III.7.	Улаанбаатар хотын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, дүүргээр	224
График III.8.	Цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, асуулгаар	226
График III.9.	Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар	228
График III.10.	Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар	229
График III.11.	Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар	230
График III.12.	Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар	231
График III.13.	Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, дүүргээр	232
График III.14.	Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	235
График III.15.	Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	236
График III.16.	Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	237
График III.17.	Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар	238
График III.18.	Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн үнэлгээ, дүүргээр	239
График III.19.	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ	242
График III.20.	Цагдаагийн байгууллага, алба хаагчтай хамтран ажиллахад гарсан санал, хувиар	244
График III.21.	Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, түүний үр нөлөөг сайжруулахад чиглэгдсэн санал, хувиар	245

НЭГ. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАДАГ ЧИГЛЭЛ

Энэхүү судалгаанд Монгол Улсын 4 бүсэд хамаарах 21 аймгийн 233 байгууллага, Улаанбаатар хотын 6 дүүргийн 58 байгууллага, нийтдээ улсын дүнгээр 291 байгууллага хамрагдсан. Эдгээр байгууллагаас цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг голлох 10 чиглэлээр асуулга авч үр дүнг улс, бүс, Улаанбаатар хотын хэмжээнд ангилан дүгнэлт хийв.

1.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД БУСАД БАЙГУУЛЛАГЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАДАГ ЧИГЛЭЛ

Судалгаанд оролцсон 291 байгууллага 678 чиглэлээр цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа ба тэргүүлэх 3 чиглэл нь:

- “Гэмт хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр” хамгийн олон буюу 147 байгууллага (21.6 хувь)
- “Хүний эрхийг хамгаалах, хангуулах чиглэлээр” 114 байгууллага (16.8 хувь)
- “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр (Сургууль)” 95 байгууллага (14.0 хувь) байна.

Хүснэгт III.1-д хамтран ажилладаг байгууллагуудыг үйл ажиллагааных нь чиглэл, бүсээр нь ангилан нэгтгэж харуулав. Мөн График III.1-д улсын хэмжээнд цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг байгууллагуудын хамтын ажиллагааны чиглэлээр нь эрэмбэлэн харуулав.

Хүснэгт III.1. Цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг
байгууллагуудын чиглэл, давхардсан тоогоор

д/д	Хамтран ажилладаг чиглэл	Нийт	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
1	Гэмт хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр	147	24	30	43	15	35
2	Хүний эрхийг хамгаалах, хангуулах чиглэлээр	114	16	33	32	11	22
3	Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр (сургууль)	95	20	19	26	9	21
4	Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн эргүүл зохион байгуулах чиглэлээр	84	17	17	17	11	22
5	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр	71	15	11	21	12	12
6	Хэрэг бүртгэл, мөрдөн байцаах ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлээр	58	8	7	22	4	16
7	Байгаль хамгаалах чиглэлээр	38	12	8	9	7	2
8	Боловсролын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр	35	11	8	10	3	3
9	Хувийн хэвшил	19	2	4	5	3	5
10	Аж ахуй, хувцас, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр	17	3	6	1	2	5
Судалгаанд хамрагдсан байгууллагын тоо		678	128	179	186	77	143

График III.1. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг
байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, хувиар



ХОЁР. ХУУЛЬ ЁСНЫ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хууль дээдлэн ажиллах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болохын хувьд цагдаагийн алба хаагч хууль, тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах үүрэгтэй. Улсын хэмжээнд хууль ёс, зарчмыг цагдаагийн байгууллага хэрхэн мөрдөж ажиллаж байгааг хамтран ажилладаг 291 байгууллагаар үнэлүүлж үр дүнг улсын хэмжээнд болон бүс, аймаг, дүүрэг тус бүрээр боловсруулан гаргав.

2.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУУЛЬ ЁСНЫ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны зарчмын хэрэгжилтийг хамтран ажилладаг байгууллагууд **дунд зэрэг** (3.42) гэж үнэлжээ. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны зарчмын хэрэгжилтийг нийт 4 асуултын хүрээнд авсан ба ерөнхий байдлаар Улаанбаатар хот болон Баруун бүс улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Хангайн болон Зүүн бүсүүд

улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Харин Төвийн бүсийн үнэлгээ улсын дундажтай ижилхэн түвшинд байна. Нийт 4 асуултын ерөнхий дундаж үнэлгээ 3.20-3.51 хооронд байгаа бөгөөд асуулт тус бүрийн дундаж үнэлгээг Хүснэгт III.2-т харуулав. Баруун бүс дөрөв, Улаанбаатар хот хоёр, Хангай, Төв болон Зүүн бүсүүд тус бүр нэг үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Нийт 4 асуудлаар хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээг бүс бүрээр улсын дундажтай харьцуулан График III.2-т үзүүлэв.


“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод бөгөөд эргэлзээгүй байдаг” гэсэн асуултад Хангайн бүсийн байгууллагууд 3.18 үнэлгээ өгсөн нь хамгийн бага үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.17 пунктээр бага байна. Харин “Цагдаагийн байгууллага нь танай байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг” гэсэн асуултад Баруун бүс 3.70 гэсэн үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт байлаа.

Хүснэгт III.2. Хууль ёсны зарчмын хэрэгжилтэд хамтран ажилладаг байгууллагын өгсөн үнэлгээ, улсын хэмжээнд, хувиар

Асуултууд	Улсын дундаж үнэлгээ	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Цагдаагийн байгууллага нь танай байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг	3.67	3.70	3.64	3.69	3.60	3.64
Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг баримтлан шударга ёсыг эрхэмлэн ажилладаг	3.57	3.65	3.58	3.57	3.33	3.58
Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод бөгөөд эргэлзээгүй байдаг	3.35	3.36	3.18	3.35	3.40	3.32
Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөг хангаж ажилладаг	3.42	3.44	3.22	3.42	3.20	3.51
Улсын дундаж	3.50	3.53	3.40	3.50	3.38	3.51

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График III.2. Хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, бүсээр




2.1.1 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ

Судалгааны дүнгээр баруун бүсээс Ховд аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Увс аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авсан нь анхаарал татаж байна. Аймаг бүрийн үнэлгээг График III.3-д дэлгэрэнгүй үзүүлэв.

Ховд аймгийн байгууллагууд “Цагдаагийн байгууллага нь танай

байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг” гэсэн асуултад 3.91 үнэлгээ өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 0.24 пунктээр дээгүүр байна. Харин “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод бөгөөд эргэлзээгүй байдаг” гэсэн асуултад Увс аймаг 3.20 үнэлгээ өгсөн нь бүсийнхээ хувьд хамгийн бага үзүүлэлт байлаа.

График III.3. Баруун бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар



2.1.2 Хангайн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ


Хангайн бүсийн хувьд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны зарчмын хэрэгжилтэд хамтран ажилладаг байгууллагууд **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.40) гэсэн үнэлгээ өгчээ. Нийт 4 асуулт тус бүрээр 3.18-3.64 хооронд үнэлгээ авсан нь улсын

дунджаас 0.17-0.03 пунктээр доогуур үзүүлэлттэй гарлаа. Хангайн бүсээс Орхон аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Өвөрхангай, Булган аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Хангайн бүсийн аймгуудын үнэлгээг улсын дундажтай харьцуулан График III.4-д үзүүлэлт тус бүрээр харуулав.

“Цагдаагийн байгууллага нь танай байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг” гэсэн асуултад Орхон аймгийн байгууллагууд 4.06 үнэлгээ өгсөн нь бүсийн хувьд хамгийн өндөр үзүүлэлт байсан ба улсын дунджаас 0.36 пунктээр дээгүүр байна. Энэ нь харилцагч байгууллагууд **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлж байна.

Харин Булган аймаг “Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг баримтлан шударга ёсыг эрхэмлэн ажилладаг” гэсэн асуултад 2.80, Өвөрхангай аймаг “Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөг хангаж ажилладаг” гэсэн асуултад 2.70 гэсэн үнэлгээг тус тус авсан нь хамгийн доогуур үзүүлэлтүүд байсан бөгөөд **сэтгэл ханамжгүй** байгааг харуулж байна.

График III.4. Хангайн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар



2.1.3 Төвийн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ

Төвийн бүсийн хувьд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны зарчмын хэрэгжилтийг хамтран ажилладаг байгууллагууд **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.5) гэж үнэлжээ. Төв, Дорноговь, Говьсүмбэр аймгууд бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Дундговь


аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Төвийн бүсийн аймгуудын үнэлгээг асуулт бүрээр нь дэлгэрүүлэн График III.5-д үзүүлэв.

Төвийн бүсээс Сэлэнгэ аймаг “Цагдаагийн байгууллага нь танай байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг” гэсэн асуултад

хамгийн өндөр үнэлгээ (4.0) авсан нь харилцагч байгууллагууд **сэтгэл ханамж сайн** байгааг илэрхийлж байна. Харин “Цагдаагийн байгууллагын үйл

ажиллагаа ил тод бөгөөд эргэлзээгүй байдаг” гэсэн асуултад Сэлэнгэ, Өмнөговь аймгууд харьцангуй бага үнэлгээ (3.20) авчээ.

График III.5. Төвийн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар




2.1.4 Зүүн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ

Зүүн бүсийн хувьд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны зарчмын хэрэгжилтийг хамтран ажилладаг байгууллагууд **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.38) гэж үнэлжээ. Нийт 4 асуулт тус бүрээр хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээ 3.2-3.6 хооронд байгаа бөгөөд энэ нь улсын дунджаас 0.15-0.07 пунктээр бага байна. Дорнод аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр (3.3-3.7) үнэлгээ авсан бол Сүхбаатар аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ (2.8-3.3) авчээ. Асуулт бүрийн үнэлгээг аймаг

бүрээр гаргаж График III.6-д үзүүлэв.

Графикаас харахад Сүхбаатар аймаг “Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөг хангаж ажилладаг” гэсэн асуултад **сэтгэл ханамжгүй** (2.80) байгаагаа илэрхийлж байна. Харин Хэнтий аймаг “Цагдаагийн байгууллага нь танай байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг” гэсэн асуултад 4.0 үнэлгээ авсан нь хамтран ажилладаг байгууллага энэ асуудалд **сэтгэл ханамжтай** байгааг харуулж байна.

График III.6. Зүүн бүсийн хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, аймгаар




2.1.5 Улаанбаатар хотын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ

Улаанбаатар хотын 6 дүүргийн хувьд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны зарчмын хэрэгжилтэд хамтран ажилладаг 58 байгууллага **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.51) байдгаа илэрхийлжээ. Нийт 4 асуулт тус бүрээр хамтран ажилладаг байгууллагууд 3.32-3.64 хооронд үнэлгээ өгсөн нь улсын дунджаас 0.03 пунктээр доогуур үзүүлэлттэй байна. Судалгааны дүнгээс үзэхэд Хан-Уул, Баянгол дүүргүүд бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр (3.45-3.91) үнэлгээ авсан бол Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүд улсын дунджаас доогуур үнэлгээ (2.9-3.45) авчээ. Улаанбаатар

хотын дүүргүүдийн үнэлгээний тоон үзүүлэлтийг График III.7-д үзүүлэв.

Сүхбаатар дүүрэг “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод бөгөөд эргэлзээгүй байдаг” гэсэн асуултад **сэтгэл ханамжгүй** (2.9) байгаа нь анхаарал татаж байна. Хан-Уул дүүрэг “Цагдаагийн байгууллага нь танай байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг”, “Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг баримтлан шударга ёсыг эрхэмлэн ажилладаг” гэсэн асуултуудад 3.90 гэсэн үнэлгээ авсан нь хотын дүүргүүдийн хувьд хамгийн өндөр үзүүлэлт юм.

График III.7. Улаанбаатар хотын хууль ёсны зарчмын хэрэгжилтийн үнэлгээ, дүүргээр



ГУРАВ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙН ТӨЛӨВШИЛ

3.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙН ТӨЛӨВШИЛ ИЙН ҮНЭЛГЭЭ

Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтөд хамтран ажилладаг байгууллагууд *сэтгэл ханамж дунд зэрэг* (3.45) байдаг гэжээ. Тухайлбал, үнэлгээ өгсөн байгууллагуудын 16.5 хувь нь “Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад *сэтгэл ханамжгүй* гэж хариулжээ.

Харин “Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг” гэсэн асуултад 59.8 хувь нь *сэтгэл ханамжтай* байгаагаа илэрхийлсэн байна (Хүснэгт III.3).

Улсын дунджаас дээгүүр болон доогуур авсан зарим үзүүлэлтүүдийг График III.8-д үзүүлэв.

Улаанбаатар хот дөрөв, Төвийн бүс гурав, Баруун бүс хоёр, Зүүн бүс нэг үзүүлэлтээр тус бүр улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй байсан бол Хангайн бүс бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлэгджээ.


Хүснэгт III.3. Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, хувиар

Асуултууд	Судалгаанд оролцсон байгууллагын тоо	Улсын дундаж үнэлгээ	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд зэрэг	Санал нийлнэ	Санал бүрэн нийлнэ
Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	291	3.19	5.5	11.0	48.8	28.5	6.2
Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбархан байдаг	291	3.5	2.1	8.9	37.1	40.9	11.0
Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг	291	3.65	1.0	6.2	33.0	46.4	13.4
Цагдаагийн байгууллагын алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай гэж үздэг	291	3.45	1.0	9.3	40.9	41.2	7.6
Ерөнхий дундаж үнэлгээ	291	3.45	2.4	8.9	40.0	39.3	9.6


Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График III.8. Цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, асуултаар

а. Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг.
(Дундаж үнэлгээ хамгийн өндөр 3.65)



б. Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг.
(Дундаж үнэлгээ хамгийн бага 3.19)



Хүснэгт III.4. Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, бүсээр

Асуултууд	Улсын дундаж үнэлгээ	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	3.19	3.02	3.06	3.19	3.23	3.42
Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбархан байдаг	3.5	3.56	3.35	3.55	3.43	3.57
Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг	3.65	3.70	3.56	3.67	3.43	3.81
Цагдаагийн байгууллагын алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай гэж үздэг	3.45	3.27	3.39	3.49	3.30	3.65
Ерөнхий дундаж үнэлгээ	3.45	3.38	3.34	3.47	3.34	3.61


Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

3.1.1 Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Баруун бүсийн хувьд цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтөд хамтран ажилладаг байгууллагууд **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.38) байдаг ажээ. Баруун бүсээс Говь-Алтай, Завхан, Ховд аймгууд тус бүр 2 үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Увс аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур (3.1-3.5) үнэлгээ авчээ. Баруун бүсээс Говь-Алтай аймаг “Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр

соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад улсын дунджаас доогуур үнэлгээ (2.9) авсан нь харилцагч байгууллагууд **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлнэ. Харин Ховд аймаг “Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг” гэсэн асуултад хамгийн өндөр үнэлгээ (4.0) авсан нь харилцагч байгууллагууд **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлэх бөгөөд энэ нь улсын дунджаас 0.37 пунктээр дээгүүр байна. Нийт 4 асуултаар баруун бүсийн хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээг График III.9-д задлан харуулав.

График III.9. Баруун бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар




3.1.2 Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Хангайн бүсийн хувьд цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийг хамтран ажилладаг байгууллагууд **дунд зэрэг** (3.34) гэж үнэлжээ. Нийт 4 асуултын дүнгээр Орхон аймаг улсын дунджаас дээгүүр үнэлгээ (3.28-4.06) авсан бол Архангай, Өвөрхангай, Булган зэрэг аймгууд тус бүр 3 үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үнэлгээ авчээ. Хангайн бүсээс Архангай, Өвөрхангай аймгууд “Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид

харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад улсын дунджаас доогуур үнэлгээ (2.5-2.9) авсан нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлж байна. Харин Орхон аймаг “Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг” гэсэн асуултад хамгийн өндөр үнэлгээ (4.06) авсан нь **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлнэ. Нийт 4 асуудлаар хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээг График III.10-д задлан харуулав.

График III.10. Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар




3.1.3 Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Төвийн бүсийн хувьд цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийг хамтран ажилладаг байгууллагууд **дунд зэрэг** (3.47) гэж үнэлжээ. Нийт 4 асуултын дүнгээр 3.19-3.67 хооронд үнэлгээ авсан нь улсын дунджаас 0.25 пунктээр дээгүүр үзүүлэлт юм. Энд Төв, Дорноговь аймгууд улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Дундговь аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур (2.7-3.5) үнэлэгджээ. Төвийн бүсээс Дундговь аймгийн байгууллагууд “Манай орон нутгийн

цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад улсын дунджаас доогуур үнэлгээ (2.7) өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлнэ. Харин Төв аймаг “Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг” гэсэн асуултад хамгийн өндөр үнэлгээ (4.0) өгсөн нь **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлэх бөгөөд энэ үнэлгээ нь улсын дунджаас 0.37 пунктээр дээгүүр байна. Нийт 4 асуудлаар хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээг График III.11-т задлан харуулав.

График III.11. Төвийн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар




3.1.4 Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Зүүн бүсийн хувьд цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийг хамтран ажилладаг байгууллагууд **дунд зэрэг** (3.34) гэж үнэлжээ. Зүүн бүсийн аймгууд нийт 4 асуултын дүнгээр 3.23-3.43 хооронд үнэлгээ авсан байна. Хэнтий аймаг улсын дунджаас 3 үзүүлэлтээр дээгүүр үнэлгээ авсан бол Сүхбаатар аймаг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур (2.5-3.1) үнэлгээ авчээ. Зүүн бүсээс Сүхбаатар аймгийн хамтран

ажилладаг байгууллагууд “Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад улсын дунджаас доогуур үнэлгээ (2.5) өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлнэ. Харин Хэнтий аймаг уг асуултад хамгийн өндөр үнэлгээ (4.0) авсан нь **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлэх бөгөөд энэ үнэлгээ нь улсын дунджаас 1.77 пунктээр дээгүүр байна. Нийт 4 асуудлаар хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээг График III.12-т задлан харуулав.

График III.12. Зүүн бүсийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, аймгаар




3.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ

Улаанбаатар хотын хувьд цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийг хамтран ажилладаг байгууллагууд нь **дунд зэрэг** (3.61) гэж үнэлжээ. Гэсэн хэдий ч энэ үнэлгээ нь бусад орон нутгийн үнэлгээнээс өндөр байна. Улаанбаатар хотын дүүргүүдийн цагдаагийн байгууллага нийт 4 асуултын дүнгээр 3.42-3.81 хооронд үнэлгээ авчээ. Сонгинохайрхан болон Баянзүрх дүүргүүд бүх үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Чингэлтэй дүүрэг бүх үзүүлэлтээр улсын дунджаас доогуур (3.0-3.5) үнэлгээ авчээ. Нийт 4 асуудлаар

хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээг График III.13-т задлан харуулав. Энэхүү графикаас харахад Чингэлтэй дүүргийн хамтран ажилладаг байгууллагууд “Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад улсын дунджаас доогуур үнэлгээ (3.0) өгсөн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг илэрхийлнэ. Харин Сонгинохайрхан дүүрэг “Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг” гэсэн асуултад хамгийн өндөр үнэлгээ (4.14) өгсөн нь **сэтгэл ханамж өндөр** байгааг илэрхийлэх бөгөөд энэ нь улсын дунджаас 0.54 пунктээр дээгүүр үнэлгээ юм.

График III.13. Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн үнэлгээ, дүүргээр



ДӨРӨВ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН БАЙДАЛ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн байдлыг бүрэн илэрхийлэх 2 асуултаар судалж үр дүнг улс, бүс, Улаанбаатар хотоор боловсруулан дүгнэв.

4.1 УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамтран ажилладаг

байгууллагууд нь **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.78) байдаг үнэлгээ гарав. Тухайлбал, тэдний 5.8 хувь нь “Бид цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд сэтгэл ханамж өндөр байдаг” гэсэн асуултад **сэтгэл ханамжгүй** гэж хариулсан бол 73.2 хувь нь “Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг” гэсэн асуултад **сэтгэл ханамжтай** байгаагаа илэрхийлсэн байна (Хүснэгт III.5). Бүсүүдийн нэгдсэн дүнг Хүснэгт III.6-д харуулав.

Хүснэгт III.5. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, улсын дүнгээр

Асуултууд	Судалгаанд оролцсон байгууллагын тоо	Улсын дундаж үнэлгээ	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд зэрэг	Санал нийлнэ	Санал бүрэн нийлнэ
Бид цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд сэтгэл ханамж өндөр байдаг	291	3.71	1	4.8	27.8	55	11.3
Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг	291	3.85	1.7	2.7	22.3	55.3	17.9

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

Хүснэгт III.6. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, бүсээр

Асуултууд	Улсын дундаж үнэлгээ	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Бид цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд сэтгэл ханамж өндөр байдаг	3.71	3.70	3.67	3.78	3.40	3.77
Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг	3.85	3.72	3.77	3.99	3.70	3.92
Дундаж	3.78	3.71	3.72	3.88	3.55	3.84

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.


Төвийн бүс болон Улаанбаатар хот 2 үзүүлэлтээрээ улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол Баруун, Зүүн, Хангайн бүс улсын дунджаас доогуур үнэлгээтэй байна.

4.1.1 Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ

Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамтран ажилладаг байгууллагууд нь **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.71) байгаагаар илэрхийлжээ. Хоёр асуулт тус бүрээр 3.7-3.73 үнэлгээ авсан нь улсын дунджаас 0.01-0.12 пунктээр

доогуур үзүүлэлт юм. Ховд аймаг нийт үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авч Баян-Өлгий, Завхан аймгууд тус тус доогуур үнэлгээтэй гарсан байна. Баруун бүсээс Ховд аймгийн хамтран ажилладаг байгууллагууд “Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг” гэсэн асуултад хамгийн өндөр үнэлгээ (4.0) өгсөн нь **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлэх бөгөөд энэ нь улсын дунджаас 0.15 пунктээр дээгүүр байна. Хоёр асуултаар хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээг График III.14-т нэгтгэн харуулав.

График III.14. Баруун бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар




4.1.2 Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ

Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамтран ажилладаг байгууллагууд нь **сэтгэл дунд зэрэг** (3.72) байгаагаар илэрхийлжээ. Үнэлгээний 2 асуултад харилцагч байгууллагууд 3.67-3.77 үнэлгээ өгчээ. Орхон аймаг хоёр үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлгээ авч Булган, Хөвсгөл, Өвөрхангай аймгууд тус

тус доогуур үнэлгээ авчээ. Хангайн бүсээс Орхон аймгийн хамтран ажилладаг байгууллагууд “Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг” гэсэн асуултад хамгийн өндөр үнэлгээ (4.17) өгсөн нь **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлэх бөгөөд улсын дунджаас 0.32 пунктээр дээгүүр байна. Хоёр асуудлаар хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээг График III.15-д харуулав.

График III.15. Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар




4.1.3 Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж

Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамтран ажилладаг байгууллагуудын **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.88) байна. Хоёр асуултын үнэлгээ нь 3.78-3.99 байгаа ба Төв, Сэлэнгэ, Дорноговь аймгууд нийт үзүүлэлтээрээ улсын дунджаас дээгүүр үнэлгээ авчээ. Харин Дундговь, Дархан-Уул аймгууд доогуур үнэлгээтэй байна. Төвийн бүсээс Дундговь аймгийн хамтран ажилладаг байгууллагууд “Бид цагдаагийн байгууллагатай хамтран

ажилласан тохиолдолд сэтгэл ханамж өндөр байдаг” гэсэн асуултад хамгийн бага үнэлгээ (3.4) өгсөн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг илэрхийлнэ. Харин Төв аймаг “Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг” гэсэн асуултад хамгийн өндөр (4.17) үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлэх бөгөөд энэ нь улсын дунджаас 0.32 пунктээр дээгүүр үнэлгээ юм. Хоёр асуудлаар хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээг График III.16-д харуулав.

График III.16. Төвийн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар




4.1.4 Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж

Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамтран ажилладаг байгууллагууд нь **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.55) байдгаа илэрхийлжээ. Зүүн бүс хоёр асуулт тус бүрээр 3.4-3.7 үнэлгээ авсан нь улсын дунджаас 0.31-0.15 пунктээр бага байна. Зүүн бүсээс Сүхбаатар аймгийн хамтран ажилладаг байгууллагууд “Бид цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд

сэтгэл ханамж өндөр байдаг” гэсэн асуултад хамгийн бага үнэлгээ (2.8) өгсөн нь **сэтгэл ханамжгүй** байгааг илэрхийлнэ. Харин Хэнтий аймаг “Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг” гэсэн асуултад хамгийн өндөр (4.2) үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлэх бөгөөд энэ нь улсын дунджаас 0.35 пунктээр дээгүүр үнэлгээ юм. Хоёр асуудлаар хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн үнэлгээг График III.17-д харуулав.

График III.17. Зүүн бүсийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ, аймгаар




4.1.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамтран ажилладаг байгууллагууд нь **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.84) байна. Хоёр асуулт тус бүрээр 3.77-3.92 үнэлгээ авсан нь улсын дунджаас 0.06-0.07 пунктээр дээгүүр үзүүлэлт юм. Хан-Уул дүүрэг бүх үзүүлэлтээрээ улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байсан бол Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүд улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотоос Сүхбаатар дүүргийн хамтран ажилладаг байгууллагууд “Бид цагдаагийн

байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд сэтгэл ханамж өндөр байдаг” гэсэн асуултад хамгийн бага үнэлгээ (3.5) өгсөн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг илэрхийлнэ. Харин Сонгинохайрхан дүүрэг “Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг” гэсэн асуултад хамгийн өндөр (4.29) үнэлгээ өгсөн нь **сэтгэл ханамжтай** байгааг илэрхийлэх бөгөөд улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт юм. Энэ нь улсын дунджаас 0.44 пунктээр дээгүүр үнэлгээ байв. Хамтран ажилладаг байгууллагуудын хоёр асуултын үнэлгээг График III.18-д харуулав.

График III.18. Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн үнэлгээ, дүүргээр



ТАВ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Хамтран ажилладаг байгууллагуудын сэтгэл ханамжийн судалгааны асуулгыг 5 бүлгийн 11 асуултаар авсан бөгөөд сэтгэл ханамжийг илэрхийлэх 10 асуулт бүхий 3 бүлгийн сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээг эрэмбэлэн Хүснэгт III.7-д харуулав. Хүснэгтээс харахад улсын дүнгээр нийт 21 аймаг, 6 дүүргийн цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг байгууллагуудын сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ **3.57** буюу **сэтгэл ханамж дунд зэрэг** гэж үнэлэгджээ. Үнэлгээгээр эрэмбэлбэл, **нэгдүгээрт** Хан-Уул дүүрэг, **хоёрдугаарт** Орхон аймаг, **гуравдугаарт** Төв болон Хэнтий аймгууд ижил үзүүлэлтээр жагсжээ.


Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар харилцагч байгууллагуудын өгсөн дундаж үнэлгээг График III.19-д харуулав. Уг графикаас харахад дундаж үзүүлэлтээс дээгүүр үнэлгээтэйд Орхон, Төв, Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр, Ховд, Сэлэнгэ, Өмнөговь, Говь-Алтай аймгууд болон Хан-Уул, Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүд, орсон бол дунджаас доогуур үнэлгээтэйд Завхан, Дорнод, Хөвсгөл, Дархан-Уул, Баян-Өлгий, Архангай, Баянхонгор, Увс, Дундговь, Өвөрхангай, Булган, Сүхбаатар аймгууд болон Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүд, орсон байна.

Хүснэгт III.7. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын
үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ

№	Улсын хэмжээнд	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны байдал	Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшил	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж	Нийт үнэлгээний дундаж	Байр
1	Хан-Уул дүүрэг	3.84	3.95	4.15	3.98	I
2	Орхон	3.86	3.68	4.09	3.88	II
3	Төв	3.60	3.63	4.13	3.78	III
4	Хэнтий	3.60	3.75	4.00	3.78	III
5	Дорноговь	3.63	3.65	3.95	3.74	IV
6	Баянгол дүүрэг	3.70	3.59	3.87	3.72	V
7	Сонгинохайрхан дүүрэг	3.43	3.72	4.00	3.71	VI
8	Говьсүмбэр	3.73	3.58	3.80	3.70	V
9	Ховд	3.64	3.55	3.91	3.70	V
10	Сэлэнгэ	3.53	3.38	4.05	3.65	VI
11	Баянзүрх дүүрэг	3.55	3.65	3.75	3.65	VI
12	Өмнөговь	3.45	3.45	3.95	3.62	VII
13	Говь-Алтай	3.63	3.40	3.70	3.58	VIII
14	Завхан	3.55	3.35	3.70	3.53	IX
15	Дорнод	3.48	3.48	3.65	3.53	IX
16	Хөвсгөл	3.45	3.39	3.69	3.51	X
17	Дархан-Уул	3.36	3.41	3.72	3.50	XI
18	Баян-Өлгий	3.48	3.40	3.60	3.49	XII
19	Архангай	3.45	3.24	3.70	3.46	XIII
20	Чингэлтэй дүүрэг	3.36	3.28	3.70	3.45	XIV
21	Баянхонгор	3.40	3.23	3.70	3.44	XV
22	Увс	3.40	3.25	3.65	3.43	XVI
23	Сүхбаатар дүүрэг	3.18	3.50	3.60	3.43	XVI
24	Дундговь	3.28	3.25	3.60	3.38	XVII
25	Өвөрхангай	3.15	3.23	3.65	3.34	XVIII
26	Булган	3.23	3.28	3.50	3.33	XIX
27	Сүхбаатар	3.08	2.83	3.00	2.97	XX
Улсын дундаж		3.48	3.45	3.77	3.57	

Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамжтайг илэрхийлнэ.

График III.19. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ



Дундаж үнэлгээ 5.0 руу ойртох тутам сэтгэл ханамж өндөр байх утга илэрхийлнэ

ЗУРГАА. НЭЭЛТТЭЙ АСУУЛТЫН ХАРИУЛТ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар харилцагч байгууллагуудын сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор судалгаанд оролцогчдод нээлттэй асуулт тавьж, үр дүнг нэгтгэн боловсруулав.

6.1 ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХАД ХЯЛБАР БОЛОН ХҮНДРЭЛТЭЙ БАЙДАГ АСУУДЛЫН ТАЛААРХ САНАЛ

Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахад хүндрэлтэй байдаг эсэхийг тодорхойлох зорилгоор харилцагч байгууллагуудаас нээлттэй санал/асуулт авсан бөгөөд тэднээс ирүүлсэн 205 төрлийн нийт 332 саналыг нэгтгэж боловсруулав. Дэлгэрэнгүй саналыг аймаг, бүсээр Хавсралт III.1-ээс харна уу. Эдгээр саналаас хамгийн олон давтагдаж


байгаа 6 бүлэг саналыг Хүснэгт 8-д үзүүлэв.

Хүснэгт III.8-аас харахад цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг нийт байгууллагаас хамтран ажиллахад хүндрэлтэй байдаг эсэх талаар 332 санал ирүүлсэн бөгөөд тэдгээрийн 269 (нийт саналын 83.4 хувь) нь хамгийн олон давтагдсан бөгөөд 6 бүлэг саналд багцалж болохоор байв. Үүнээс цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахад шуурхай, итгэлтэй, хариуцлагатай, хялбар байдаг гэсэн агуулгатай 108 санал (нийт саналын 35.6 хувь) хамгийн олон давталттай байв. Ёс зүй, харилцаа хандлага доголдолтой, дээрэнгүй, соёлгүй, албан тушаал ялгаж харьцдаг гэсэн агуулгатай 44 санал (14.5 хувь), асар их чирэгдэл учруулдаг, хүнд сурталтай гэсэн агуулгатай 39 санал (12.9 хувь) үүний дараа орно. Нийт саналын дэлгэрэнгүйг График III.20-д үзүүлэв.

Хүснэгт III.8. Цагдаагийн байгууллага, алба хаагчтай хамтран ажиллахын давуу болон сул тал

№	Санал	Давталт	Эзлэх хувь
1	Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахад шуурхай, итгэлтэй, хариуцлагатай, хялбар байдаг	108	40.1
2	Ёс зүй, харилцаа хандлага доголдолтой, дээрэнгүй, соёлгүй, ялгаж харьцдаг	44	16.4
3	Асар их чирэгдэл учруулдаг, хүнд сурталтай	39	14.5
4	Хэрэг шийдэхэд удаан, албан бичгийн хариуг хугацаанд өгдөггүй	36	13.4
5	Зарим цагдаагийн албан хаагчид нь хуулийн мэдлэг дутуу, ур чадвар муу, харилцан ойлголцож чаддаггүй, мэдээлэл солилцоход хүндрэлтэй	26	9.7
6	Ажлын ачаалал их, орон тоог нэмэх	16	5.9
Нийт санал		269	100

График III.20. Цагдаагийн байгууллага, алба хаагчтай хамтран ажиллахад гарсан санал, хувиар



6.2 ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭГДСЭН САНАЛ, ХҮСЭЛТ


Цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг бусад байгууллагаас санал

авах зорилгоор уг нээлттэй асуултыг авсан бөгөөд 258 төрлийн нийт 324 саналыг нэгтгэн харуулав (Дэлгэрэнгүй саналыг аймаг, бүсээр Хавсралт III.2-оос харна уу). Эдгээр саналаас хамгийн олон давтагдаж байгаа 6 бүлэг саналыг сонгон Хүснэгт III.9-д харуулав.

Хүснэгт III.9. Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, түүний үр нөлөөг сайжруулахад чиглэгдсэн санал, хамгийн олон давталтаар

№	Санал	Давталт	Эзлэх хувь
1	Цагдаагийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг байнга дээшлүүлж сургалт явуулж байх	52	34.7
2	Цагдаагийн байгууллагын ажилтан алба хаагчдын боловсролын түвшин, ёс зүйг сайжруулах тал дээр анхаарч өөрчлөлт гаргах	42	28.0
3	Хүн хүч хүрэлцдэггүй учир орон тоог нэмэгдүүлэх	20	13.3
4	Олон нийтэд нээлттэй ил тод болгох, хуулиа дээдэлдэг болгох	13	8.7
5	Байнгын эргүүлд гаргах, архидалттай тэмцэх	13	8.7
6	Иргэд рүү чиглэсэн нээлттэй хаалганы өдөрлөг удаа дараа зохион байгуулах, сурталчлах	10	6.7
Нийт санал		150	100

График III.21. Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, түүний үр нөлөөг сайжруулахад чиглэгдсэн санал, хувиар



Хүснэгт III.9-өөс харахад цагдаагийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг байнга дээшлүүлэх сургалт явуулж байх гэсэн агуулгатай 52 санал (34.7 хувь), цагдаагийн байгууллагын ажилтан алба хаагчдын боловсролын түвшин, ёс зүйг сайжруулах тал дээр дэвшилтэт өөрчлөлт

гаргах гэсэн агуулгатай 42 санал (28.0 хувь), хүн хүч хүрэлцдэггүй учир орон тоог нэмэгдүүлэх гэсэн агуулгатай 20 санал (13.3 хувь) хамгийн олон давталттай байлаа. Харилцагч байгууллагуудаас ирүүлсэн саналын дэлгэрэнгүйг График III.21-д харуулав.

ДҮГНЭЛТ

1. Цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг байгууллагуудын үнэлгээг 5 бүлгийн 11 асуултаар авлаа. Үр дүнг тооцож үзэхэд **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.57) байгаа нь харагдлаа. Нийт 3 бүлгийн 10 асуултын үнэлгээгээр эрэмбэлэхэд нэгдүгээрт Хан-Уул дүүрэг 3.98 буюу **сэтгэл ханамж дунд зэрэг**, хоёрдугаарт Орхон аймаг 3.88 буюу **сэтгэл ханамж дунд зэрэг**, гуравдугаарт Төв болон Хэнтий аймаг 3.78 буюу **сэтгэл ханамж дунд зэрэг** үнэлгээтэйгээр тус тус орсон байна. Хэдийгээр дунджаас доогуур үнэлгээтэй хэд хэдэн аймаг, дүүрэг байгаа боловч **сэтгэл ханамж дундаж** гэсэн үнэлгээнд хамаарч байгаа нь иргэдээс авсан санал асуулгын дүнтэй ойролцоо гарч байна.
2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны зарчмын хэрэгжилтийн байдлыг хамтран ажилладаг байгууллагууд **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.50) гэж үнэлжээ. “Цагдаагийн байгууллага нь танай байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг” гэсэн асуултад сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ хамгийн өндөр (3.67) байсан бол “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод бөгөөд эргэлзээгүй байдаг” гэсэн асуултад сэтгэл ханамжийн үнэлгээ хамгийн бага буюу 3.35 гэж үнэлсэн нь **сэтгэл ханамж дунд зэрэг** байгааг харуулж байна. Дээрх үзүүлэлт нь тийм ч муу үр дүн биш хэдий ч бусад үзүүлэлттэй харьцуулахад иргэд, хамтран ажилладаг байгууллагын зүгээс цагдаагийн байгууллагыг ил тод биш гэж үзсээр байна.
3. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн байдалд хамтран ажилладаг байгууллагууд **сэтгэл ханамж дунд зэрэг** (3.45) гэж үнэлжээ. “Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой,

стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ (3.19) буюу **сэтгэл ханамж дунд зэрэг** гарсан нь хамгийн бага үзүүлэлт байсан бол “Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг” гэсэн асуултад хамгийн өндөр үзүүлэлттэй (3.63) байна.

4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамтран ажилладаг байгууллагуудын өгсөн ерөнхий дундаж үнэлгээ 3.78 буюу **сэтгэл ханамж дунд зэрэг** гэжээ. “Бид цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд сэтгэл ханамж өндөр байдаг” гэсэн асуултад 3.71, “Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг” гэсэн асуултад 3.85 буюу **сэтгэл ханамж**

дунд зэрэг гэж хариулжээ.

5. Цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг нийт байгууллагаас хамтран ажиллахад хялбар, эсвэл хүндрэлтэй байдаг талаар 332 санал ирүүлэв. Үүнээс хамгийн олон давталттай эерэг санал нь цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахад шуурхай, итгэлтэй, хариуцлагатай, хялбар байдаг гэж 108 санал (35.6 хувь), хамгийн олон давтагдсан сөрөг саналд ёс зүй, харилцаа хандлага доголдолтой, дээрэнгүй, соёлгүй, албан тушаал ялгаж харьцдаг, чирэгдэл учруулдаг, хүнд сурталтай, хэрэг шийдэхэд удаан, албан бичгийн хариуг хугацаанд нь өгдөггүй, албан хаагчид нь хуулийн мэдлэг дутуу, ур чадвар муу, ажлын ачаалал их, орон тоог нэмэх хэрэгтэй гэсэн асуудлууд багтсан байна.

ЗӨВЛӨМЖ

1. Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгааны бүрдэл хэсэгт хамтран ажилладаг байгууллагын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол оруулах, судалгаанд оролцогчдын тоо, санхүүжилтийг нэмэгдүүлэх, судалгаа явуулах, дүн шинжилгээ хийх аргачлалд шинжлэх ухаанч байдлаар хандаж бодит дүгнэлт гаргахад онцгой анхаарах;
2. Тухайн жилийн үнэлгээг өмнөх жилийнтэй харьцуулах замаар хэрэглэгчийн үнэлгээнд гарч байгаа өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэслэн хариуцлага хүлээлгэх, урамшуулах тогтолцоонд шилжих;
3. Алба хаагчдын харилцааны соёл, ёс зүй төлөвшилт, эрх зүйн мэдлэг, ур чадварыг сайжруулах, байгууллагын дотоод соёлыг төлөвшүүлэх, шинээр цагдаагийн албанд орох алба хаагчдыг сонгон шалгаруулж авахдаа ёс зүй, харилцааны соёлд өндөр шаардлага тавих, зөрчил дутагдал гаргасан шалтгаан нөхцөлийг бодитойгоор тогтоож холбогдох арга хэмжээг шударгаар авч байх;
4. Хуулийн хүрээнд ил болгох боломжтой мэдээллийн талаар оршин сууж буй нутаг дэвсгэрийнхээ иргэдэд мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж байх зэрэг болно.

ХАВСРАЛТ-III.1

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХАД ХЯЛБАР БОЛОН ХҮНДРЭЛТЭЙ БАЙДАГ АСУУДЛЫН ТАЛААРХ САНАЛ

Баруун бүс		
Баян-Өлгий	Цагдаагийн байгууллагын албан хаагчтай хамтран ажиллахад хүндрэлтэй зүйл байхгүй	2
	Хамтран ажиллахад амар байдаг.	4
Говь-Алтай	Ёс зүй харилцаа хандлага бусдыг хүндэтгэх талын сургалт сурталчилгаа хэрэгтэй	4
	Асар их чирэгдэл учруулдаг, хүнд сурталтай	4
	Хөрөнгө санхүүгийн асуудал тулгамдаж байна.	1
	Хамтарч ажиллаж байгаа байгууллагад мэдээллийн тодруулга өгөх дургүй	1
	Албан тушаалаараа дарамталдаг, өөрсдөө хуулиа биелүүлдэггүй байж бусдад хууль бус шаардлага тавьдаг.	1
	Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахад уриалгахан ханддагт талархдаг.	5
Завхан	Шуурхай ажилладаг.	4
	Хүндрэл байхгүй.	3
	Хууль дүрэм дутуу мэдлэгтэй болохоор хамтран ажиллахад хүндрэлтэй, хүнд сурталтай байдаг. Аливаа ажил хэргийг хамтран ажиллаж үр дүнд хүрэхээс илүү тайлан нэхэж тулган шаарддаг.	2
	Санхүү мөнгөний асуудал хүндрэлтэй байдаг.	1
	Олон нийтийн цагдааг ажиллуулах хэрэгтэй.	1
	Хүнд сурталтай	4
Увс	Харилцааны соёлын хувьд, ажил мэргэжлийн хувьд хамтарч ажиллахад орон нутгийн хувьд аюулгүй байдлыг хангаж ажилладаг ба харилцааны ёс зүй дээр анхаарвал зохих байх	4
	Судалгаа, мэдээг шуурхай ирүүлдэг.	2
	Ажил зохион байгуулахад идэвхтэй хамтран ажилладаг	1
